

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



НИЙСЛЭЛИЙН 2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

УЛААНБААТАР ХОТ
2021 ОН

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**НИЙСЛЭЛИЙН 2021-2024 ОНЫ
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Редактор: Б.Бямбасүрэн /Бодлогын судалгааны тасгийн дарга/

Эмхэтгэл: Б.Болортуул /Бодлогын судалгааны тасаг/
С.Ариунцэцэг /Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /

Хэвлэлийн эх бэлтгэл, дизайн: Х.Оюунчулуун

Хэвлэлийн хэмжээ: 176x250 /АА/

Хэвлэлийн хуудас: 12 х.х

Хэвлэгдсэн тоо ширхэг: 1000ш

АГУУЛГА

НЭГ.	НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	11
ХОЁР.	МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ	12
ГУРАВ.	АЛСЫН ХАРАА	49
ДӨРӨВ.	ЭРХЭМ ЗОРИЛГО	49
ТАВ.	ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	50
ЗУРГАА.	СТРАТЕГИЙН ЗОРИЛГО	100
ДОЛОО.	СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА НИЙСЛЭЛИЙН БҮТЦИЙН УЯЛДАА	101
НАЙМ.	СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН	106
ЕС.	НИЙСЛЭЛИЙН СТРАТЕГИЙН ЗУРАГЛАЛ	116

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Нийслэлийн чиг үүрэг	13
Хүснэгт 2.	Нийслэлийн дэд чиг үүрэг	20
Хүснэгт 3.	Холбогдогч талуудын оролцоо	35
Хүснэгт 4.	Нийслэлийн чиг үүргийн хэрэгжилт, хувиар	36
Хүснэгт 5.	Нийслэлийн чиг үүрэг, захиргааны эрх хэмжээний ангиллаар	40
Хүснэгт 6.	Нийслэлийн харьяа зарим байгууллагын хуулиар олгогдсон эрх хэмжээ	44
Хүснэгт 7.	Давхардсан чиг үүрэгтэй байгууллага	46
Хүснэгт 8.	Сургууль, цэцэрлэгийн тоо, хамрагдалт, багш /2020-2021 он, тоогоор/	62
Хүснэгт 9.	Нийслэлийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хийгдсэн ажил	65
Хүснэгт 10.	Хүнсний хангамж /Хүнсний хангамжийг гол нэрийн бүтээгдэхүүнээр /	68
Хүснэгт 11.	Хөдөлмөр эрхлэлтийн байдал /Нийслэл/	69
Хүснэгт 12.	Улаанбаатар хотын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлсэн байдал	70
Хүснэгт 13.	Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн орлогын түвшин	73
Хүснэгт 14.	Улаанбаатар хотын агаарын чанарын үзүүлэлт	77
Хүснэгт 15.	Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ /сая.нэгж/	95
Хүснэгт 16.	Нийслэлийн дотоод ба гадаад орчны шинжилгээний үр дүн /SWOT матриц/	97
Хүснэгт 17.	Стратегийн зорилго, зорилт ба хариуцах байгууллага, нэгж	103

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Нийслэлийн үйл ажиллагаанд холбогдогч талууд	34
Зураг 2.	Судалгаанд оролцогчдын ерөнхий төлөв, хувиар	36
Зураг 3.	Нийслэлийн ерөнхий чиг үүргийн хэрэгжилт, хувиар	39
Зураг 4.	Улаанбаатар хотын өрсөлдөх чадварын индекс	51
Зураг 5.	Улаанбаатар хотын газрын зураг	52
Зураг 6.	Улаанбаатар хотын ерөнхий үзүүлэлт	53
Зураг 7.	Нийслэлийн нутгийн захиргааны бүтэц	56
Зураг 8.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэрэглэгчийн үнэлгээ, 2017 он.	57
Зураг 9.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Шударга байдлын үнэлгээ	57
Зураг 10.	Улаанбаатар хотын Аз жаргалын байдлын индекс	58
Зураг 11.	Нийслэлийн хүн ам /2020 оны байдлаар/	59
Зураг 12.	Хүн амын нас, хүйсийн суварга /2010, 2020/	59
Зураг 13.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хэлбэрээр /2010, 2020/	60
Зураг 14.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдлийн чадвар /хүйс, дүнд эзлэх хувиар, 2020/	61
Зураг 15.	Хүний хөгжлийн индекс. /Улаанбаатар хот болон бүс нутгаар/	61
Зураг 16.	10, түүнээс дээш настай хүн амын боловсролын түвшин	62
Зураг 17.	Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн өвчтний тоо: Бүс нутаг, нийслэл	64
Зураг 18.	Нийслэлийн хүн амын өвчлөлийн байдал /10 мянган хүн амд, 2020 оны байдлаар/	65
Зураг 19.	Ковид 19 цар тахлын тархалт	66
Зураг 20.	15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхийн талаарх бүдүүвч /2010, 2020/	70
Зураг 21.	Нэг албан бус хөдөлмөр эрхлэгчид ногдох өрхийн гишүүдийн статистик тоо	72
Зураг 22.	Албан бус хөдөлмөр эрхлэлт/салбараар/	72
Зураг 23.	Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ажлын байрны түрээсийн төлбөрийн нөхцөл байдал	73
Зураг 24.	Хөдөлмөр эрхлэгчидэд тулгамдаж буй асуудал	74
Зураг 25.	Өрхийн тоо, сууцны төрлөөр /2020/	75
Зураг 26.	Бохирдуулагч үйлдвэрүүд	80
Зураг 27.	Хог хаягдал хүлээн авдаг цэг/хог хаягдлын хувь/	82
Зураг 28.	Улаанбаатар хотын дагуул хот	90
Зураг 29.	Улаанбаатар хотын гадаад харилцаа	94
Зураг 30.	Стратегийн зорилго ба бүтцийн уялдаа	101

ӨМНӨТГӨЛ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 06 дугаар сараас мөрдөгдөж эхэлсэн. Уг хуульд “Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийг үндэслэн аймаг, нийслэлийн дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулна” гэж заасан.

Нийслэлийн хувьд дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь “Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь “Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” байна. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Ингэхдээ нийслэл болон түүний харьяа байгууллагууд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон стратеги төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах юм.

Төрийн албаны тухай хууль (2017 оны шинэчилсэн найруулга)-ийн 53 дугаар зүйлийн 1-д зааснаар “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж тусгасан.

Дээрх хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал” шинэчлэн батлагдсан.

“Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын дагуу Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байдлаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг 4 жилээр боловсруулах шаардлага үүсч байна.

Иймд Нийслэлийн нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг боловсруулахаар Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/90 дүгээр захирамжаар “Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах” үүрэг бүхий ажлын хэсэг, дэд ажлын хэсгүүдийг байгуулан ажлыг зохион байгуулан төслийг боловсруулсан.

Нийслэлийн стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд шаардлагатай өгөгдөл мэдээллийг баримт бичиг судлах, ярилцлага хийх, асуулга судалгаа авах аргаар цуглуулсан.

Мөн эдгээр өгөгдөлд статистик судалгааны SPSS програм болон контент шинжилгээний аргуудыг ашиглан боловсруулалт, дүгнэлт хийсэн болно. Ингээд стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасны дагуу Нийслэлийн стратеги төлөвлөгөөг дараах агуулгын хүрээнд боловсруулав. Үүнд:

1. Нийтлэг үндэслэл
2. Мандатын шинжилгээ
3. Алсын хараа
4. Эрхэм зорилго
5. Орчны шинжилгээ
6. Стратегийн зорилго
7. Стратегийн зорилго ба бүтцийн уялдаа
8. Стратегийн зорилго, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин
9. Стратегийн зураглал

Нэг. Нийтлэг үндэслэл хэсэгт Нийслэлийн стратеги төлөвлөгөө боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг холбогдох эрх зүйн баримт бичгийг судлах байдлаар тодорхойлсон.

Хоёр. Мандатын шинжилгээг хийхдээ Нийслэлийн чиг үүргийг тодорхойлсон холбогдох эрх зүйн баримт бичигт судалгаа, шинжилгээг хийсэн. Мандатын шинжилгээг дөрвөн алхмын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Нийслэлийн чиг үүргийг холбогдох эрх зүйн баримт бичгээс түүвэрлэн авч, үйл ажиллагааны чиглэлээр нь ангилан тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, нийслэлийн ерөнхий, үндсэн, дэд чиг үүргүүдийг тодорхойлов. Ингэхдээ одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006), мөн УИХ-аас 2020 онд баталсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон бусад хууль тогтоомжийг үндэслэсэн. Ялангуяа, Нийслэлийн ерөнхий болон үндсэн чиг үүргийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006, 2020), “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль (1994)”-нд тулгуурлан тодорхойлсон. Харин дэд чиг үүргийг тодорхойлохдоо Салбарын хуулиуд болон Нийслэлийн чиг үүргийн шинжилгээний тайланг¹ үндэслэв. Уг тайланд нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хамаарах дэд чиг үүргийг салбарын хуулиудад үндэслэн тодорхойлсон байна.
2. Нийслэлтэй харилцдаг холбогдогч талууд, тэдгээрийн оролцоог тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, холбогдогч талуудыг тодорхойлохдоо Нийслэлийн Засаг даргаас бусад хуулийн этгээд, байгууллагатай харилцах эрх хэмжээг үндэслэсэн болно. Харин эдгээр холбогдогч талуудын оролцоог мэдээлэх, зөвлөх, санал өгөх, хамтран ажиллах, шийдвэр гаргах гэсэн ерөнхий ангиллын хүрээнд тодорхойлж хүснэгтэд нэгтгэсэн.
3. Нийслэлийн хуулиар олгосон чиг үүргийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг санал асуулгын судалгааны үр дүн болон холбогдох баримт материалд тулгуурлан тодорхойлсон. Тухайлбал, Нийслэлийн чиг үүргийн хэрэгжилтийг тодорхойлохдоо Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ болон холбогдогч талууд (519 албан хаагч)-аас авсан санал асуулгын

¹ ЗГХЭГ-аас хийсэн Нийслэл, аймгийн чиг үүргийн шинжилгээний тайлан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Азийн сангийн хамтарсан чиг үүргийн шинжилгээний тайлан, Нийслэлийн стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн санал

судалгааны дүнг нэгтгэх байдлаар үнэлгээг гаргасан.

4. Нийслэлийн Засаг даргын эрх хэмжээг “захиргааны эрх хэмжээний ангилал”² болох бодлого боловсруулах, зохицуулалт хийх, санхүүжүүлэх, хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх гэсэн ерөнхий чиглэлээр нь ангилан хүснэгтэд нэгтгэн харуулсан.

Гурав. Нийслэлийн алсын харааг тодорхойлохдоо ажлын хэсгийн гишүүд, зөвлөх багийн гишүүдээс ирсэн саналыг үндэслэн боловсруулсан.

Дөрөв. Нийслэлийн эрхэм зорилгыг тодорхойлохдоо ажлын хэсгийн гишүүд, зөвлөх багийн гишүүдээс ирсэн саналыг үндэслэн боловсруулсан.

Тав. Нийслэлийн орчны шинжилгээг хийхдээ статистик, социологийн болон бусад судалгааны аргуудыг өргөн ашигласан ба судалгааны анхдагч мэдээлэл болгон нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг судалсан судалгаа шинжилгээний өнгөрсөн 4 жилийн тайлан, жил, улирлын гүйцэтгэлийн, төсөв санхүүгийн тайлан, хөтөлбөрүүд болон мандатын шинжилгээний хүрээнд хийгдсэн гадагш, дотогш чиглэсэн харилцааны хүрээнд холбогдогч талууд болох Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллага, Дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийт 519 албан хаагчдыг хамруулан хийгдсэн асуулга судалгааны үр дүн, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын “Монгол Улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний салбарын танилцуулга, санал”-аас нийслэлийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид анхаарах зүйлс зэрэг мэдээлэлд үндэслэн SWOT шинжилгээний аргыг ашиглан гүйцэтгэсэн болно. SWOT шинжилгээний арга нь үйл ажиллагааны одоогийн дүр төрхийг тодорхойлж, давуу ба сул тал, боломж, эрсдэлийг тодруулан, түүнд үндэслэн цаашид хөгжүүлэх арга замыг тодорхойлон гаргадаг.

Тиймээс SWOT шинжилгээг нийслэлийн дотоод болон гадаад орчны хүчин зүйлсийг тодорхойлоход голлон чиглэсэн ба үүнийг нийслэлийн мандатад үндэслэхийн зэрэгцээ дараах төрөлд ангилан шинжилгээг хийсэн. Үүнд:

- Ковид 19 цар тахлаас үүдэлтэй хүндрэл
- Засаглал
- Хүний хөгжил
- Эдийн засаг
- Ногоон хөгжил
- Хотжилт /хот төлөвлөлт, дэд бүтэц/

Мөн сүүлийн 2 жилийн цаг үеийн нөхцөл байдлыг харгалзан “Ковид 19” цар тахлын нөлөөлөл, түүний үр дагавар болон стратеги төлөвлөгөөг боловсруулах явцад гарсан хуулийн өөрчлөлтийг шинжилгээнд хамруулан авч үзсэн.

Зураа. Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө боловсруулах хүрээнд нийт 6 стратегийн зорилго тодорхойлсон.

2 Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал

Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.1-д “Стратеги төлөвлөгөө нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэнэ” гэж заасны дагуу “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 6 үндсэн чиглэл буюу зорилгод үндэслэн тодорхойлсон.

Стратегийн зорилго тодорхойлохдоо нийлбэр үзүүлэлт буюу индекс тооцох аргачлалыг ашигласан. Энэхүү аргачлалыг ашигласан үндэслэл нь нэгд, стратеги төлөвлөгөө нь хүний хөгжил, нийгэм, байгаль орчин, эдийн засаг, засаглалын өргөн хүрээний асуудлуудыг хөндөж байгаа бөгөөд ерөнхий үр дүнг 1 үзүүлэлтээр тодорхойлох боломж хязгаарлагдмал байсан. Хоёрт, стратегийн зорилгын хүрээнд хүлээгдэж буй ерөнхий үр дүнгийн статистик өгөгдөл, мэдээллийн бэлэн байдал бүрэн хангагдаагүй байна.

Иймд стратегийн зорилгыг зорилтуудын биелэлтийн хувиар тооцох байдлаар тодорхойлсон. Ингэхдээ зорилтуудыг тэнцүү интервалын зарчмаар тооцох нь зүйтэй гэж үзсэн. Өөрөөр хэлбэл тухайн зорилгын хүрээнд 4 зорилт тодорхойлогдсон тохиолдолд тухайн нэг зорилтод ногдох хувь 25 хувь байна. Стратеги төлөвлөгөө хэрэгжих үеийн түвшинг “0” хувиар тооцох /суурь түвшин/ ба хүлээгдэж буй үр дүнг “100” хувиар тооцож үр дүнг тооцно.

Долоо. Нийслэлийн хувьд тодорхойлсон стратегийн зорилгуудыг холбогдох байгууллага, нэгжийн үндсэн чиг үүрэгтэй нь уялдуулан зураглан үзүүлж, шаардлагатай тайлбарыг бичсэн. Өөрөөр хэлбэл, стратегийн зорилгуудын хэрэгжилтийг хангахад дэмжлэг болох үүднээс зорилго ба бүтцийн уялдааг зургаар илэрхийлж, гүйцэтгэх үүргийг товч тайлбар хэлбэрээр оруулсан.

Найм. Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 6 стратегийн зорилгын хүрээнд 36 зорилт, 36 стратеги, 89 хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойлсон.

Стратегийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин тодорхойлохдоо:

1. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндэслэн, үйл ажиллагаа, гарцад бус үр дүнд чиглүүлэн тодорхойлохыг зорьсон.
2. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд үр дүн, үр нөлөөний шалгуур үзүүлэлт нэмэлтээр оруулан тодорхойлохыг зорьсон.

3. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааны биелэлтээс зорилтын биелэлтийг тооцох, зорилтын биелэлтээс зорилгын биелэлтийг тооцон гаргах арга зүйг ашигласан.
4. Стратегийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинг тодорхойлохдоо нийлбэр үзүүлэлт буюу индекс тооцох аргачлалыг ашигласан.

Ес. Стратегийн зураглал хэсэгт нийслэлийн стратеги төлөвлөгөөг боловсруулсан алхам тус бүрийн үр дүнг нэгтгэн стратегийн ерөнхий зураглалыг нэг хавтгай дээр буулган үзүүлсэн болно. Энэ нь стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хэрэглээг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл, энэхүү зураглалд мандат, алсын хараа, уриа, эрхэм зорилго, үнэт зүйл, стратегийн зорилго, зорилт, баримтлах стратеги, үндсэн болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагыг тусгасан.

Зөвлөх баг:

Я.Бямбасүрэн:	/Удирдлагын академи, Удирдахуйн ухааны сургуулийн захирал, доктор, дэд профессор/
Ц.Дэлгэржаргал:	/Удирдлагын академи, Төрийн захиргааны тэнхимийн багш, доктор/
Д.Намхайдагва:	/Удирдлагын академи, Бодлого, улс төрийн тэнхимийн багш, магистр/
Т.Түмэнцогтоо:	/Удирдлагын академи, Төрийн захиргааны тэнхимийн багш, доктор/

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/667

Улаанбаатар хот

Нийслэлийн 2021-2024 оны стратеги
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдамжаар хангаж, бодлогын уялдааг зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч (Ж.Сандагсүрэн)-д даалгасугай.

3. Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн нутгийн захиргааны байгууллага тус бүрийн стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулах, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нарт үүрэг болгосугай.

4. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар хууль, журмын дагуу тайлагнан ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Т.Оюунчимэг)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЬЯАБАЗАР

111020003118

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Манай улс ардчилсан нийгэмд шилжсэний дараа төрийн салбарт орц, үйл явцаас илүү гарц, үр дүнд чиглүүлэн удирдах арга барилд шилжих чиг хандлага бий болсон. Энэ үеэс стратегийн удирдлагын үзэл санаа төрийн салбарт хөгжин дэлгэрч төрийн байгууллага стратегийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх болсон. Манай улсын төрийн захиргааны шинэчлэлийн хүрээнд Улсын Их Хурал 1996 онд “Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг 38 дугаар тогтоолоор батлан мөрдүүлсэн. Энэхүү баримт бичиг нь төлөвлөлтийг салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд хийхээр зохицуулж өгсөн түүхтэй.

Монгол Улсын Их Хурлаар “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”-ийг 2020 онд шинэчлэн баталсан. Уг хуульд зааснаар Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийг үндэслэн аймаг, нийслэлийн дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулна. Нийслэлийн хувьд дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр байна. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Төрийн албаны тухай хууль (2017 оны шинэчилсэн найруулга)-ийн 53.1-д зааснаар “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж тусгасан. Энэ хүрээнд “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам” батлах тухай Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоол, мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг шинэчлэн баталсан. “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын дагуу Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байдлаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулахаар тусгасан.

Иймд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг үндэслэн Нийслэлийн стратеги төлөвлөгөөг боловсруулах шаардлага үүсэж байна.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандат нь тухайн салбарын болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, байгууллагад хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээтэй холбоотой байдаг. Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан чиг үүрэг дахин хуваарилах аргачлалд тусгаснаар “чиг үүрэг” гэдэг нь төрийн байгууллагад хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнд тодорхой үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тогтвортой чиглэл юм. Нийслэлийн стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд мандатын буюу чиг үүргийн шинжилгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг тус тус мөрдлөг болгосон. Ийнхүү Нийслэлийн мандатын шинжилгээг дараах алхмуудын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Алхам 1. Нийслэлийн үйл ажиллагаанд хамаарах чиг үүргийг тодорхойлох.

Монгол Улсын Их Хурлаас 2020 онд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Уг хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар “Нийслэл нь төрийн дээд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, дүүргүүдийн үйл ажиллагааг зохицуулах, иргэдэд хуульд заасан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хяналтыг хэрэгжүүлэх нэгж мөн” хэмээн тодорхойлсон байдаг.

Нийслэлийн мандатыг тодорхойлохдоо одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006), Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль (1994), мөн УИХ-аас 2020 онд батлагдсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2021 онд батлагдсан Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон бусад хууль тогтоомжийг үндэслэсэн. Ялангуяа, Нийслэлийн ерөнхий болон үндсэн чиг үүргийг Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006, 2020), “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль (1994)”, “Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль (2021)”-нд тулгуурлан тодорхойлсон. Харин дэд чиг үүргийг тодорхойлохдоо Салбарын хуулиуд болон Нийслэлийн чиг үүргийн шинжилгээний тайланг³ үндэслэв. Уг тайланд нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хамаарах дэд чиг үүргийг салбарын хуулиудад үндэслэн тодорхойлсон байна. Эдгээр хууль тогтоомжоос Нийслэлийн үйл ажиллагаанд хамаарах чиг үүргийг тодорхойлж, үйл ажиллагааны чиглэлээр нь ангилав.

Нийслэлийн үйл ажиллагаатай холбоотой 2014⁴ орчим хууль байгаа бөгөөд эдгээрээс үзвэл ерөнхий чиг үүрэг 10, үндсэн чиг үүргийн хувьд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006) болон Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль (1994)-нд зааснаар 48, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2020) болон Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль (2021)-д туссанаар 79 байна. Үүнийг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй байдлаар харуулав.

³ ЗГХЭГ-аас хийсэн Нийслэл, аймгийн чиг үүргийн шинжилгээний тайлан, Нийслэлийн ЗДТГ болон Азийн сангийн хамтарсан чиг үүргийн шинжилгээний тайлан, Нийслэлийн стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн санал

⁴ Нийслэлийн ЗДТГ (2021), Нийслэлийн хуулиуд

Хүснэгт 1. НИЙСЛЭЛИЙН ЧИГ ҮҮРЭГ

№	МУМУЗЗНДНТУТХууль (2006), НЭБТХууль (1994)		МУМУЗЗНДНТУТХууль (2020) шинэчилсэн найруулга МУНУБХЭБТХууль (2021) шинэчилсэн найруулга	
	Нийслэлийн үндсэн чиг үүрэг	Хуулийн зүйл, заалт	Нийслэлийн үндсэн чиг үүрэг	Хуулийн зүйл, заалт
Ерөнхий чиг үүрэг 1. Хүн амд нийгэм, соёлын үйлчилгээг үзүүлэх (МУЗЗНДНТУТ хууль 29.1.5)				
1.1	Хүн амын эрүүл мэндийг хамгаалах	МУЗЗНДНТУТХ 29.1.5а,б,в,г НЭБТХ 8.2.3	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ; <i>(Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)</i>	МУЗЗНДНТУТХ 27.5.4
1.2	Хүн амд боловсролын үйлчилгээг үзүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.5а,б,г, 30.1.14	Сургуулийн өмнөх боловсрол; <i>(Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)</i>	МУЗЗНДНТУТХ хууль 27.5.2.
			Ерөнхий боловсрол; <i>(Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)</i>	МУЗЗНДНТУТХ 27.5.3.
1.3	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.5а,б,г	Нийтийн биеийн тамир; <i>(Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)</i>	МУЗЗНДНТУТХ хууль 27.5.9.
1.4	Соёл урлагийг хөгжүүлэх, соёлын өвийг хамгаалах	МУЗЗНДНТУТХ 29.1.5а,б,г, 30.1.17 НЭБТХ 8.2.1	Соёлын үйлчилгээ; <i>(Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)</i>	МУЗЗНДНТУТХ 27.5.8.
			Хөшөө дурсгалын нийтлэг зохицуулалт;	МУЗЗНДНТУТХ 24.1.18.
			Түүхэн дурсгалт зүйлийн хамгаалалт; <i>(Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)</i>	МУЗЗНДНТУТХ хууль 27.5.19.
			Нийслэл дэх үндэсний хэмжээний түүх, соёлын дурсгалт газрын хадгалалт, хамгаалалт <i>(Тусгай чиг үүрэг)</i> ;	МУНУБХЭБТХ 8.2.4
1.5	Нийслэлийн хэмжээнд тэмдэглэлт ой, баяр ёслол тэмдэглэх, байгууллагад нэр өгөх, нэрэмжит болгох, хөшөө дурсгалын цогцолбор байгуулах асуудлаар өөрийн санаачилгаар болон иргэд, байгууллагын саналыг үндэслэн шийдвэр гаргах.	НЭБТХ 8.1.5	Хуульд өөрөөр заагаагүй бол үндэсний болон олон улсын хэмжээний баяр наадам, хурал, урлаг, спортын болон бусад арга хэмжээг зохион байгуулах <i>(тусгай чиг үүрэг)</i> ;	МУНУБХЭБТХ 8.2.2
Ерөнхий чиг үүрэг 2. Хүн амын хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэх (МУЗЗНДНТУТ хууль 29.1.5)				
2.1	Нутаг дэвсгэрийн хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.5д	Хүн амын хөгжил, хамгааллын үйлчилгээ; <i>(Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)</i>	МУЗЗНДНТУТХ 27.5.5.

2.2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	МУЗЗНДНТУТХ 29.1.5д НЭБТХ 8.2.2, 8.2.4	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, түүний хэрэгжилт; (Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)	МУЗЗНДНТУТХ 27.5.7.
2.3	Нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих	МУЗЗНДНТУТХ 29.1.5е	-	-
2.4	Хөдөлмөрийн харилцааг зохицуулах	МУЗЗНДНТУТХ 30.1.17	-	-
2.5	Нутаг дэвсгэрийн хүн амын нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.5д	Нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах; (Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)	МУЗЗНДНТУТХ 27.5.6.
Ерөнхий чиг үүрэг 3. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах (МУЗЗНДНТУТ хууль 29.1.3, НЭБТХ 3.4)				
3.1	Нутаг дэвсгэрийн байгалийн баялгийг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх	МУЗЗНДНТУТХ 29.1.3б,з,м,н, 30.1.12 НЭБТХ 8.2.3	Байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, нөхөн сэргээлт; (Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)	МУЗЗНДНТУТХ 27.5.10.
3.2	Газар, газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хангах	МУЗЗНДНТУТХ 29.1.3 в,г,е,ж,л. 30.1.4	Газрын харилцаа, газар зохион байгуулалт, төлөвлөлт, хяналт; (Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)	МУЗЗНДНТУТХ 27.5.17.
			Нийслэл хотын болон нийтийн эдэлбэр газар, түүний хэмжээ, ашиглалтын журмыг тогтоох;	МУНУБХ ЭБТХ 21.1.4
3.3	Ашигт малтмалын эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих	МУЗЗНДНТУТХ 29.1.3 е,н, 30.1.5, 30.1.13	-	-
3.4	Нутаг дэвсгэртээ байршдаг амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.3.а, 30.1.17	Мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, түүний гамшгаас урьдчилан сэргийлэх, хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ; (Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)	МУЗЗНДНТУТХ 27.5.14.
3.5	Нутаг дэвсгэртээ ургамал хамгаалах, хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.3.а, 30.1.17	-	-
3.6	Аялал жуулчлалын хөгжлийн бодлогыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 30.1.17	Нийслэлийн аялал жуулчлалын бодлого, менежмент;	МУЗЗНДНТУТХ 24.1.20.
			Нийслэлийн нутаг дэвсгэр дэх дархан цаазат болон байгалийн цогцолбор, нөөц, дурсгалт газрыг иргэдийн аялах, амрах орчныг бүрдүүлэх зорилгоор тохижуулах, хамгаалах төсөл, арга хэмжээ;	МУНУБХЭБТХ 8.3.14
3.7	Ус, цаг уур, орчны шинжилгээний арга хэмжээг хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 30.1.17	-	-

3.8	Усны бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.4в, 30.1.17	Нийслэлийн хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, хяналт;	МУЗЗНДНТУТХ 24.1.7.
			Үйлдвэрлэлийн зориулалттай усан хангамж; (Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)	МУЗЗНДНТУТХ 27.5.13.
			Хүн амын ундны болон ахуйн хэрэглээний төвлөрсөн усан хангамж;	МУНУБХЭБТХ 8.3.7
			Цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт;	МУЗЗНДНТУТХ 24.1.14.
Ерөнхий чиг үүрэг 4. Орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх (МУЗЗНДНТУТХ 29.1.4, 30.1.3, НЭБТХ 3.4)				
4.1	Нутаг дэвсгэрийн хэмжээнд барилга, хот байгуулалтын бодлого хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.4 а,д, 29.1.3л	Хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалт;	МУЗЗНДНТУТХ 24.1.15.
4.2	Нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн талаар баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.4в НЭБТХ 8.2.2	Нийслэлийн нийтийн тээвэр, такси үйлчилгээний зохицуулалт;	МУЗЗНДНТУТХ 24.1.11.
			Олон улсын зорчигч болон ачаа тээвэр, логикийн үйл ажиллагааны удирдлага, зохицуулалт (тусгай чиг үүрэг);	МУНУБХЭБТХ 8.2.3
4.3	Эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.4 д	Эрчим хүч, өндөр хүчдэлийн болон цахилгаан, дулааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг хангах бусад үйл ажиллагаа; (Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)	МУЗЗНДНТУТХ 27.5.16.
4.4	Орон нутгийн чанартай зам гүүр, харилцаа холбоог хөгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.4 в,г	Нийслэлийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын чанартай авто зам барих, түүний арчлалт, засвар, холбогдох үйл ажиллагаа (Тусгай чиг үүрэг);	МУНУБХЭБТХ 8.2.5
			Нийслэлийн авто зам, зогсоолын төлөвлөлт, байршил;	МУЗЗНДНТУТХ 24.1.13.
			Нийслэлийн замын хөдөлгөөний зохицуулалт;	МУЗЗНДНТУТХ 24.1.12.
			Нийслэлийн авто замын арчлалт, засвар, төлөвлөлт, хяналт;	МУНУБХЭБТХ 8.3.6
			Харилцаа холбоотой хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт;	МУЗЗНДНТУТХ 24.1.14.
Ерөнхий чиг үүрэг 5. Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэх (МУЗЗНДНТУТ хууль 29.1.2, 30.1.4, 30.1.11)				

5.1	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийг удирдлагаар хангах	МУЗЗНДНТУТХ 29.1.2а,б,в,г,д,е 29.1.4 б, 29.1.5 б,г, 29.1.6 б, 30.1.4, 30.1.11	Нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт;	МУЗЗНДНТУТХ 24.1.2.
5.2	Орон нутгийн өмчийн бодлого, шийдвэр хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.2а,б,в,г,д,е 29.1.4 б, 29.1.5 б,г, 29.1.6 б, 30.1.4, 30.1.11	Нийслэлийн музей, театр, номын сан, соёлын ордон, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ;	МУЗЗНДНТУТХ 24.1.8.
Ерөнхий чиг үүрэг 6. Хүнсний аюулгүй байдлыг хангаж, хөдөө, аж ахуйг хөгжүүлэх (МУЗЗНДНТУТ хууль 29.1.3)				
6.1	Газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.3б	-	-
6.2	Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнс тэжээлийн нөөцийн талаарх бодлого боловсруулж хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.3а, 29.1.6б.	Хүнсний хангамж, үйлдвэрлэлийн хөтөлбөр, нийтлэг зохицуулалт;	МУНУБХЭБТХ 8.3.4
6.3	Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний бодлого хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.4д, 29.1.6ж, 30.1.3	Худалдаа, үйлчилгээний нийтлэг зохицуулалт, хяналт;	МУЗЗНДНТУТХ 24.1.9.
6.4	Мал аж ахуйг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.3а	Бэлчээрийн менежмент; (Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)	МУЗЗНДНТУТ хууль 27.5.11.
			Малын тэжээлийн нөөц бүрдүүлэлт; (Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)	МУЗЗНДНТУТХ 27.5.12.
			Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, нийтлэг зохицуулалт;	МУНУБХЭБТХ 8.3.4
Ерөнхий чиг үүрэг 7. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөлт, төсөв санхүү, статистикийн бодлого хэрэгжүүлэх (МУЗЗНДНТУТ хууль 29.1.1)				
7.1	Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагаар хангах	МУЗЗНДНТУТХ 29.1.1а НЭБТХ 8.2.5	Нийслэл хотын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт (Тусгай чиг үүрэг);	МУНУБХЭБТ Хууль 8.2.6
			Нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлт;	МУЗЗНДНТУТХ 24.1.1.
			Нийслэл хотыг хөгжүүлэх асуудлаар төсөл, хөтөлбөр санаачлах, төсөл, хөтөлбөрт санал, дүгнэлт өгөх, тухайн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	МУНУБХЭБТХ 22.1.6
			Нийслэлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, хэрэгжилт, хяналт; (Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)	МУЗЗНДНТУТХ 27.5.23.
			Хот, суурин газрын дахин төлөвлөлт;	МУНУБХЭБТХ 8.3.5
			Авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, нийслэл хотод тулгамдсан бусад асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээ;	МУНУБХЭБТХ 8.3.11

7.2	Татварын хууль, тогтоомж хэрэгжилтийг хангаж, төсвийн орлого бүрдүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.1е	Хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;	МУЗЗНДНТУТХ 24.1.4. МУНУБХЭБТХ 16.2
7.3	Орон нутгийн төсөв, санхүүгийн бодлого хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.1в	Нийслэлийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт;	МУЗЗНДНТУТХ 24.1.3.
			Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;	МУЗЗНДНТУТХ 24.1.5.
			Нийслэлийг хөгжүүлэх сангийн менежмент;	МУЗЗНДНТУТХ 24.1.6. МУНУБХЭБТХ 8.3.1
7.4	Статистик, тооллого судалгааг зохион байгуулах, үр дүнг тайлагнах	МУЗЗНДНТУТХ 29.1.1г	Улсын бүртгэл; (Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)	МУЗЗНДНТУТХ 27.5.1.
Ерөнхий чиг үүрэг 8. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх (МУЗЗНДНТУТ хууль 29.1.6)				
8.1	Гадаад, дотоодод тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх;	МУЗЗНДНТУТХ 29.1.6 з НЭБТХ 8.2.6	Гадаад улсад нийслэл хотыг төлөөлөх этгээдийг томилох, чөлөөлөх;	МУНУБХЭБТХ 22.1.10
			Дотоод, гадаадад нийслэлийг төлөөлөх;	МУНУБХЭБТХ 22.1.9
8.2	-	-	Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, төрийн захиргааны болон төрийн бусад байгууллага, гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх (тусгай чиг үүрэг);	МУНУБХЭБТХ 8.2.1
8.3	-	-	Нийслэлийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилт;	МУНУБХЭБТХ 8.3.2
Ерөнхий чиг үүрэг 9. Хууль ёс, нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах (МУЗЗНДНТУТ хууль 29.1.6)				
9.1	Иргэдийн аюулгүй байдал, эрх, эрх чөлөөг хамгаалах	МУЗЗНДНТУТХ 29.1.6 в, д, л НЭБТХ 8.1.2, 8.1.3	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа; (Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)	МУЗЗНДНТУТХ 27.5.22.
9.2	Мэргэжлийн хяналт шалгалтыг орон нутагт хэрэгжүүлэх	МУЗЗНДНТУТХ 29.1.5 в, е, 29.1.6 к, 30.1.17	Мэргэжлийн хяналт; (Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)	МУЗЗНДНТУТХ 27.5.18.

9.3	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангаж, тохирлын үнэлгээний байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	МУЗЗНДНТУТХ 30.1.17	Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг. <i>(Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)</i>	МУЗЗНДНТУТХ 27.5.26.
9.4	Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг удирдан, зохион байгуулах	МУЗЗНДНТУТХ 29.1.6 б, 30.1.6	Онцгой байдлын болон гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа; <i>(Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)</i>	МУЗЗНДНТУТХ 27.5.20.
9.5	Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах	МУЗЗНДНТУТХ 30.1.6	Орон нутгийн хамгаалалт; <i>(Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)</i>	МУЗЗНДНТУТХ 27.5.24.
9.6	Нийслэлд хэв журам сахиулах, хотын аж ахуй, оршин суугчдын нийгэм, соёлын асуудлаар нийтээр дагаж мөрдөх журмыг хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, биелэлтэд хяналт тавих;	НЭБТХ 8.1.2	Нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэх талаар хуульд нийцүүлэн дүрэм, журам, стандарт, заавар батлах;	МУНУБХЭБТХ 21.1.3
Ерөнхий чиг үүрэг 10. Хот, тосгоны нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэх (НЭБТХ 3.4, 8.2.7, ХТЭБТХууль 7-р зүйл)				
10.1	Хотын дэд бүтцийн бодлогыг хэрэгжүүлж, инженерийн байгууламжийн ашиглалтын найдвартай ажиллагааг хангах	ХТЭБТХ 22-р зүйл НЭБТХ 8.2.5	Шинээр байгуулах дэд бүтэц; <i>(Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)</i>	МУЗЗНДНТУТХ 27.5.15.
			Цэвэрлэх байгууламж, үерийн далан, суваг шуудуу;	МУЗЗНДНТУТХ 24.1.16.
			Барилга байгууламж, авто зам болон бусад дэд бүтцийн засвар, арчлалт, цэвэрлэгээ, үйлчилгээ, хамгаалалт <i>(Тусгай чиг үүрэг)</i>	МУНУБХЭБТХ 8.2.7
			Нийслэлийн ус, дулааны төвлөрсөн бус инженерийн хангамж;	МУНУБХЭБТХ 8.3.8
10.2	Газар ашиглах, орчны бохирдлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх	ХТЭБТХ 6, 19-р зүйл НЭБТХ 8.2.3	Хог хаягдлын нэгдсэн төлөвлөлт, удирдлага, зохицуулалт;	МУЗЗНДНТУТХ 24.1.21.
			Орчны аюулгүй байдал;	МУНУБХЭБТХ 8.3.3
10.3	Тохижилт, ногоон байгууламжийн бодлого хэрэгжүүлэх	ХТЭБТХ 19.6-р зүйл	Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж, төлөвлөлт, хяналт;	МУЗЗНДНТУТХ 24.1.19.
			Гудамж, зам, талбай, барилга байгууламжийн нэр, хаягжуулалтын зохицуулалт;	МУЗЗНДНТУТХ 24.1.17.
			Нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн засвар, арчлалт, цэвэрлэгээ, үйлчилгээ, хамгаалалт <i>(Тусгай чиг үүрэг)</i>	МУНУБХЭБТХ 8.2.7
			Нийслэлийн нутаг дэвсгэр дэх голын хамгаалалт, тохижилт;	МУНУБХЭБТХ 8.3.13

10.4	Хотын өөрийн мэдлийн өмчийг захиран зарцуулах, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах	ХТЭБТХ 18-р зүйл	Нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт;	МУЗЗНДНТУТХ 24.1.2.
			Хотын өөрийн мэдлийн орон сууцны ашиглалт, хуваарилалт;	МУНУБХЭБТХ 8.3.15
10.5	Хүнс, худалдаа үйлчилгээний бодлого хэрэгжүүлэх	ХТЭБТХ 20-р зүйл НЭБТХ 8.2.2	Нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын ажиллах цагийн хуваарийг тогтоож, мөрдүүлэх;	МУНУБХЭБТХ 22.1.8
10.6	Хотын дэг журам, аюулгүй байдлыг хангах	ХТЭБТХ 23-р зүйл НЭБТХ 8.2.3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах үйл ажиллагаа; <i>(Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)</i>	МУЗЗНДНТУТХ 27.5.21.
10.7	Хот, нийтийн аж ахуйн хөрөнгө оруулалт, төсөв санхүүг зохицуулах	ХТЭБТХ 17-р зүйл НЭБТХ 8.2.5	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага, үйлчилгээ;	МУЗЗНДНТУТХ 24.1.10.
10.8	Нийгмийн хамгаалал болон ахуйн соёлын хэрэгцээг хангах	ХТЭБТХ 21-р зүйл НЭБТХ 8.2.3, 8.2.4	-	-
10.9	Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.	МУЗЗНДНТУТХ 30.1.17	Оршуулгын газрын нийтлэг зохицуулалт, менежмент.	МУЗЗНДНТУТХ 24.1.22.
			Архивын ажил үйлчилгээ, төрийн архивын баримтын хадгалалт, хамгаалалт, бүрдүүлэлт, ашиглалт; <i>(Төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг)</i>	МУЗЗНДНТУТХ 27.5.25.
			Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааны зохицуулалт, хяналт;	МУНУБХЭБТХ 8.3.9
			Гадна болон явуулын зар сурталчилгааны зохицуулалт, хяналт;	МУНУБХЭБТХ 8.3.10
			Гадаадын зээл, тусламжаар нийслэлд хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний нийслэлийн хариуцах хөрөнгө, зээлийн хүүгийн төлбөр;	МУНУБХЭБТХ 8.3.12

Нийслэлийн дэд чиг үүрэг гэдэгт үндсэн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааны нарийвчилсан чиглэлийг авч үзсэн. Өөрөөр хэлбэл, салбарын хуулиудаас нийслэлийн үйл ажиллагаанд хамаарах 287 дэд чиг үүргийг тодорхойлсон бөгөөд үүнийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2. НИЙСЛЭЛИЙН ДЭД ЧИГ ҮҮРЭГ

д/д	Үндсэн чиг үүргийн ерөнхий ангилал	Дэд чиг үүрэг (салбарын хуулиудад тусгаснаар)
1	Хүн амын эрүүл мэндийг хамгаалах	1. Гамшгийн үед харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагад цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэхэд шаардагдах нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэж, удирдлага зохион байгуулалтаар хангах
		2. Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй эрүүл мэндийн байгууллагуудыг удирдлагаар хангах
		3. Нутаг дэвсгэрийнхээ эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, оновчтой байршуулах, материаллаг бааз, хүний болон санхүүгийн нөөцийг зохистой хуваарилах
		4. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, оновчтой байршуулах
		5. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдлыг хангуулах
		6. Харьяалах нутаг дэвсгэртээ хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөр, төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах
		7. Эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах
		8. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад нэмэлт санхүүжилт олгох
2	Хүн амд боловсролын үйлчилгээг үзүүлэх	9. Иргэнд суурь боловсрол эзэмшүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэжил эзэмшүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх
		10. Орон нутгийн боловсролын сургалтын байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх
		11. Сургалтын орчин нөхцөлийг сайжруулах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээг жигд, тогтвортой зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх
		12. Сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурах бичиг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулах
		13. Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулах
		14. Төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх
		15. Нийслэлийн боловсролын газрын даргыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрснөөр томилох, чөлөөлөх
		16. Ерөнхий боловсролын сургуулийг хичээлийн болон дотуур байраар хангах, дотуур байрны хүүхдийн хоол хүнсний хангамжийг зохих журмын дагуу шийдвэрлэх
		17. Иргэнд суурь боловсрол эзэмшүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэжил эзэмшүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх

3	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх	18.Иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх
		19.Өсвөр үеийн шигшээ багт дэмжлэг үзүүлэх
		20.Спортын холбоод, бусад байгууллагатай хамтран ажиллах
4	Соёл урлагийг хөгжүүлэх, соёлын өвийг хамгаалах	21.Орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг хамгаалах, баяжуулах, дэмжих
		22.Орон нутгийн соёлын байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх
		23.Угийн бичиг хөтлөх ажлыг зохион байгуулах
		24.Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулах
		25.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага, багт дэмжлэг үзүүлэх;
		26.Соёлын өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх
		27.Соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, хадгалан хамгаалах,
		28.Соёлын өвийн судалгаа, тайлан мэдээллийг зохих журмын дагуу гаргаж, мэдээллийн санд хүргүүлэх
5	Нутаг дэвсгэрийн хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх	29.Ахмад настны хөгжил хамгааллын үйл ажиллагааг зохион байгуулах
		30.Ахмад настныг дэмжих, төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах
		31.Ахмадын ордон байгуулж ажиллуулах
		32.Байгаль орчин, түүх, соёлын өвийг хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ардын урлаг, ёс заншил, уламжлалт зан үйлийг хөгжүүлэхэд залуучуудын оролцоог хангах, дэмжих
		33.Гэр бүлийн хөгжил хамгааллын үйл ажиллагаа зохион байгуулах
		34.Залуучуудыг хөгжүүлэх урлаг, соёл, спортын арга хэмжээнд залуучууд оролцох, зохион байгуулсан хуулийн этгээдийг дэмжих
		35.Залуучуудын дунд гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэх, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх, сурталчлах үйл ажиллагааг дэмжих
		36.Залуучуудын оролцоо, хөгжил, хамгааллын үйл ажиллагааг зохион байгуулах
		37.Залуучуудын хөгжлийг дэмжих залуучуудын салбар зөвлөлийг ажиллуулах
		38.Залуучуудыг хөгжүүлэхэд чиглэсэн барилга, байгууламж, дэд бүтцийг байгуулах, өргөтгөх төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх
		39.Залуучууд судлал, орон нутаг захиалгат ажлын байранд очсон залуучууд, Залуучууд хөгжлийн төвийг санхүүгийн хувьд дэмжих
		40.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллах, амьдрах, сурах орчныг бүрдүүлэх, сурах, хөгжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
		41.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний салбар зөвлөлийг ажиллуулах
		42.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөнгөлөлт, тусламж үзүүлэх
		43.Хөгжлийн бэрхшээлтэй хүний бүртгэлийг хөтлөх

6	Нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих	44.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэх
		45.ХАБЭА-н болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төлөвлөж, хэрэгжүүлэх
		46.ХАБЭА-н орон нутгийн зөвлөл байгуулж, ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах
		47.ХАБЭА-н сургалтыг зохион байгуулах
7	Хөдөлмөрийн харилцааг зохицуулах	48.Хөдөлмөрийн хамтын хэлэлцээрт оролцох
		49.Хөдөлмөрийн арбитрыг байгуулж, томилох
		50.Хөдөлмөрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх
		51.Хөдөлмөрийн хамтын гэрээ, хэлэлцээрийг бүртгэх, биелэлтэд хяналт тавих
8	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	52.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх
		53.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх
		54.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлэх
9	Нутаг дэвсгэрийн хүн амын нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэх	55.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх
		56.Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагсдын болон хамруулах шаардлагатай өрхийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх
		57.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх
		58.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд иргэдийг хамруулах
10	Нутаг дэвсгэрийн байгалийн баялгийг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх	59.Байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалах, халдашгүй байдлыг нь хангах, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах
		60.Байгаль орчны албаны даргыг байгаль хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж томилох, чөлөөлөх.
		61.Нутаг дэвсгэртээ нөхөрлөлийн үйл ажиллагаа дэмжин хөгжүүлэх, шаардагдах төсвийг баталж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.
		62.Нутаг дэвсгэртээ ажиллах байгаль хамгаалагчдыг шаардлагатай хувцас, техник хэрэгсэл, уналгаар хангах
		63.Ой хээрийг түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, унтраах үйл ажиллагааг зохион байгуулах
		64.Ой хээрийн хөнөөлт шавьж, өвчнөөс хамгаалах, цэвэрлэгээ арчилгаа хийх
		65. Нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх талаар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, зөрчлийг арилгуулах

11	Газар, газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хангах	66.Газар эзэмших, ашиглахтай холбогдсон маргааныг Газрын тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх
		67.Нутаг дэвсгэртээ газрын хэвлийг ашиглах, хамгаалах ажилд хяналт тавих
		68.Нутаг дэвсгэртээ хийгдсэн геологийн судалгааны болон нутаг дэвсгэртээ оршиж байгаа ашигт малтмалын талаарх мэдээллийг зохих журмын дагуу холбогдох аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулан авч танилцах;
		69.Нутаг дэвсгэртээ газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, газрын тухай хууль тогтоомж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах
		70.Газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах;
		71.Газрын төлөв байдлыг илэрхий доройтуулсан нь мэргэжлийн эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол тухайн газрыг албадан чөлөөлүүлэх шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
		72.Газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон доод шатны Засаг даргын хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, зөрчлийг арилгах арга хэмжээ авах;
		73.Газар эзэмшигч, ашиглагч нь хууль тогтоомж, гэрээнд заасан үүргээ хангалтгүй биелүүлснээс байгаль орчинд сөргөөр нөлөөлж байгаа тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан санал, гомдлын талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулах хүсэлтээ газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргах.
		74.Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэх
		75.Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах
		76.Нийслэлийн газрын нэгдмэл сангийн тайланг ангилал бүрээр гаргаж, дүн шинжилгээ хийх
		77.Газрыг орон нутгийн тусгай хэрэгцээ, хамгаалалтад авах ажлыг зохион байгуулж, хамгаалалтын дэглэм, горимыг тогтоох
		78.Геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах
		79.Иргэн, хуулийн этгээдэд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах арга хэмжээг зохион байгуулж, бүртгэлийг хөтлөх
		80.Газрын бирж, лэнд менежер программ, хур системийг нэвтрүүлэх

12	Ашигт малтмалын эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих	81.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй харилцах, үүргийн хэрэгжилтэд хяналт тавих
		82.Ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;
		83.Байгаль орчны мэдээллийн сангийн мэдээ, баримтыг төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах
		84.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;
		85.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хортой нөлөөлөл бүхий үйлдвэрлэлийн болон бусад үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг харгалзан өмчийнх нь хэлбэрийг үл харгалзан зогсоох;
		86.Нутаг дэвсгэрт нь газар ашиглах, эзэмших, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжид заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулж, гарсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах.
		87.Харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашиглуулах, зөрчил гаргавал таслан зогсоох;
		88.Эрдэм шинжилгээний болон холбогдох мэргэжлийн байгууллагад байгаль орчны судалгаа, шинжилгээний ажил хийх, төсөл боловсруулах захиалга өгч зохих төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээс гадна сонирхогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өөрийн хөрөнгөөр судалгаа, шинжилгээ хийхэд нь дэмжлэг үзүүлэх
13	Нутаг дэвсгэртээ байршдаг амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх	89.Нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
		90.Амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах
		91.Өвчилсөн, гамшигт болон аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах
		92.Иргэдийг амьтанд энэрэнгүй ханддаг үзлээр хүмүүжүүлэх, амьтныг хамгаалах үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах
14	Нутаг дэвсгэртээ ургамал хамгаалах, хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх	93.Үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх
		94.Бэлчээр, тариалангийн газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд ургамал хамгааллын талаар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, зөрчлийг арилгуулах
		95.Ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын тархалт, олшролт, хөнөөлийн тухай төрийн захиргааны төв байгууллагад жил бүр мэдээлэх
		96.Ургамлын хорио цээр тогтоосон үед тэмцэх арга хэмжээг орон нутгийн болон мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд иргэн, хуулийн этгээдийг дайчлан оролцуулах
		97.Нутаг дэвсгэртээ ургамлын хорио цээр тогтоох, цуцлах
		98.Ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал тархсан болон тархаж болзошгүй нутаг дэвсгэрийн тухай нийтэд зарлан мэдээлэх

15	Аялал жуулчлалын хөгжлийн бодлогыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх	99.Нутаг дэвсгэртээ аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх бодлоготой уялдуулан хөтөлбөр, төсөл боловсруулж, зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал оруулах, батлагдсан хөтөлбөрийн дагуу аялал жуулчлал хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх
16	Ус, цаг уур, орчны шинжилгээний арга хэмжээг хэрэгжүүлэх	100.Тухайн газар нутагт байгуулах жуулчны үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг олгож, гэрээ байгуулах 101.Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг шуурхай хангах 102. Аюул болон орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах
17	Усны бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх	103.Ус, усан орчинг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, усны барилга байгууламжийг барихтай холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулах; 104.Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах; 105.Усны тоо бүртгэлийг жил бүр зохион байгуулах, улсын усны мэдээллийн санд оруулах 106.Улсын зэрэглэлтэй хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул, судалгааны захиалга гаргах
18	Нутаг дэвсгэрийн хэмжээнд барилга, хот байгуулалтын бодлого хэрэгжүүлэх	107.Барилга байгууламжийн байршил тогтоох, газар олголт, загвар зураг батлах болон техникийн нөхцөл олгох үйл ажиллагааг зохион байгуулж, нэгдсэн бүртгэл хөтлөх, хадгалах, мэдээлэл түүний аюулгүй байдлыг хангах, мэдээллийн сангийн байнгын үйл ажиллагааг эрхлэх, хяналт тавих 108.Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах 109.Барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах 110.Барилгын үйл ажиллагаанд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх 111.Инженерийн шугам сүлжээний талаарх бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 112.Нийтийн аж ахуйн талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх 113.Нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих 114.Нутаг дэвсгэртээ орон сууц хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөний төсөл боловсруулж, хэрэгжүүлэх 115.Орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах 116.Орон сууцаар хангах төрөөс баримталж байгаа бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх 117.Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах 118.Хот суурины нутаг дэвсгэрт хот байгуулалтын кадастр хөтлөх, хот байгуулалтын архивын санг бүрдүүлэх 119.Хот, суурин газрын барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулах
19	Нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн талаар баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх	120.Нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийг тухайн нутаг дэвсгэрт зохицуулах, зохион байгуулах 121.Нутаг дэвсгэрт авто тээврийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх

20	Эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх	122.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд сэргээгдэх эрчим хүч ашиглахын ач холбогдлыг сурталчлах
		123.Нутаг дэвсгэрийнхээ эрчим хүчний хангамжийн талаарх бодлого боловсруулан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх
		124.Орон нутгийн өмчийн бие даасан үүсгүүрийг иргэн, хуулийн этгээдэд түрээслүүлэх
		125.Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр байршуулах зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах
		126.Тухайн нутаг дэвсгэр дэх эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвасын зөрчлийн хяналтыг хэрэгжүүлэх
		127.Шугам сүлжээг хамгаалах хамгаалалтын зурвасын хэмжээг тогтоох /шугам сүлжээг хамгаалах дүрмийн дагуу
		128.Эрчим хүчний тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
21	Орон нутгийн чанартай зам гүүр, харилцаа холбоог хөгжүүлэх	129.Нийслэл, орон нутгийн чанартай авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөтлөх
		130.Нийслэл, орон нутгийн чанартай авто замын санг бүрдүүлэх захиран зарцуулах
		131.Нийслэл, орон нутгийн чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх бодлого, ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулж, хэрэгжүүлэх
		132.Нутаг дэвсгэрт хамаарах олон улс, улсын болон орон нутгийн чанартай, тусгай зориулалтын авто зам, авто замын барилга байгууламжийн бүрэн бүтэн байдлыг хангах
		133.Нутаг дэвсгэрт хамаарах олон улсын, улсын, орон нутгийн чанартай авто замын байгууламж болон авто замыг цэвэрлэх
		134.Орон нутгийн чанартай зам, авто замын барилга байгууламж барих, засварлах, тэмдэгжүүлэх
		135.Төмөр замын байгууллагын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах
22	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийг удирдлагаар хангах	136.Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг тогтоох;
		137.Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөх, татан буулгах санал боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах
		138.Худалдан авах ажиллагааг зохион байгуулах
		139.Нийслэлийн өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, нийслэлийн өмчийг бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэрэг асуудлаар захиран зарцуулах санал боловсруулан нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж шийдвэрлүүлэх;
		140.Концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих, концессын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх
23	Орон нутгийн өмчийн бодлого, шийдвэр хэрэгжүүлэх	141.Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах эд хөрөнгийн жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийн тухай санал боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;
		142.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг хувьчилсан ажлын дүнг Хуралд тайлагнах
		143.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллого явуулж, дүнг Хуралд танилцуулах, шаардлагатай бол зохих шийдвэр гаргуулж хэрэгжилтийг зохион байгуулах
		144.Оюуны өмчийн байгууллагын орон нутаг дахь хэлтэс, тасаг, оюуны өмчийн улсын байцаагч үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

24	Газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх	145.Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, санхүүжүүлэх
		146.Тариалангийн талбайг зохистой ашиглах, хамгаалах
		147.Тариалангийн үйлдвэрлэлийг төлөвлөх, хэрэгжүүлэх
		148.Тариалангийн үйлдвэрлэлийн мэдээллийн санг эрхлэн хөтлөх
25	Мал аж ахуйг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх	149.Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлж, дэмжлэг үзүүлэх
		150.Бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, малын тэжээл, усан хангамжийн нөөц бүрдүүлэх
		151.Малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах
		152.Уур амьсгалын өөрчлөлт, гэнэтийн аюул, эрсдэлийн нөлөөллийг бууруулж, малын эрүүл мэндийг хамгаалах
26	Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний бодлого хэрэгжүүлэх	153.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн судалгаа, бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх
		154.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх
		155.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний борлуулалтыг болон бусад хэлбэрээр дэмжих
		156.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний гарааны бизнес, кластерыг дэмжих
		157.Жижиг, дунд үйлдвэрийн хүний нөөцийг чадавхжуулах
27	Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнс тэжээлийн нөөцийн талаарх бодлого боловсруулж хэрэгжүүлэх	158.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх асуудлыг зохицуулах, үйлдвэрлэлд хяналт тавих
		159.Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж, стратегийн хүнсний нөөц бүрдүүлэх, зарцуулах
		160.Хүнс үйлдвэрлэлд зохистой дадал, худалдаа, үйлчилгээний стандартыг хангуулах, дэмжлэг үзүүлэх
28	Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагаар хангах	161.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх
		162.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулахад холбогдох саналаа үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх
		163.Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус хүргүүлэх
		164.Дүүргийн түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдааг хангах, үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих
		165. Орон нутагт инновацыг хөгжүүлэх
		166. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулан нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх
		167.Харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах
		168.Төрийн байгууллага, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх

29	Орон нутгийн төсөв, санхүүгийн бодлого хэрэгжүүлэх	169.Батлагдсан төсвийн хэрэгжилтийг хангах, төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд дотоод хяналтыг хэрэгжүүлэх
		170.Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг тайлагнах, батламжлуулах
		171.Орон нутгийн төсвийн төслийг боловсруулах, батлуулах
		172.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хуульд нийцүүлэн байгуулах
		173.Орон нутагт зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих
		174.Нийслэлийн төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;
30	Татварын хууль, тогтоомж хэрэгжилтийг хангах, төсвийн орлого бүрдүүлэх	175.Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөр хураамжийг төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах
		176.Хууль тогтоомжоор орон нутагт шилжүүлсэн татвар, төлбөр, хураамжийн хувь, хэмжээг тогтоох ажлыг зохион байгуулан, өргөн мэдүүлж батлуулах
		177.Нийслэлийн татварын албаны үйл ажиллагааг удирдан чиглүүлж, татварын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
31	Улсын бүртгэл, статистик, тооллого судалгааг зохион байгуулах	178.Албан ёсны статистик мэдээллийн үнэн зөв байдалд тогтмол шалгалт хийж, түүний бодит байдлыг хангах
		179.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийнхээ удирдлагын үйл ажиллагаанд хэрэглэх зорилгоор, захиргааны статистикийн мэдээллийг бусад мэдээлэлтэй давхардуулахгүйгээр статистикийн байгууллагын зөвшөөрснөөр авах, мэдээллийн санг бий болгох.
		180.Мэдээлэл, судалгааны дүнг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэх
		181.Нутаг дэвсгэртээ байгаа статистикийн мэдээлэгчдээс статистикийн мэдээллийг хугацаанд нь гаргуулан авч нэгтгэх, судалгаа, дүгнэлт хийж ашиглах, албан ёсны статистикийн мэдээллийг хугацаанд нь зохих дээд шатны байгууллагад өгөх
		182.Үндэсний статистикийн хорооноос өгсөн удирдамж, чиглэлийн дагуу статистикийн тооллого, түүвэр судалгааг зохион байгуулж явуулах
		183.Нийслэлд хүн амын хэт төвлөрөл бий болох, ажил эрхлэлт, нийтийн үйлчилгээ, тээвэр, холбооны хэвийн ачаалал алдагдахаас сэргийлэх зорилгоор нийслэлд шилжин суурьших асуудлаар хууль тогтоомжийн хүрээнд зохицуулалт хийх
		184.Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэс, тасаг, ажилтны бүртгэлийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга дэмжлэг үзүүлэх

32	Гадаад, дотоодод тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх;	185.Гадаад орны дипломат төлөөлөгчийн газрын ажиллах хэвийн нөхцөлийг хангах, харилцах
		186.Гадаад улсын нийслэл, муж, хотын захиргаатай харилцах
		187.Гадаадын иргэн, хуулийн этгээдтэй харилцах
		188.Олон улсын байгууллагатай харилцах
		189.Олон улсын хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ байгуулах
		190.Улаанбаатар хотын төлөөлөгч гадаад улсын хотод ажиллуулах
		191.Төрийн дээд шагналд тодорхойлох
		192.Хууль тогтоомжид заасан журмын дагуу гадаад улсын зохих шатны нэгжтэй харилцаж, хамтран ажиллах
33	Иргэдийн аюулгүй байдал, эрх, эрх чөлөөг хамгаалах	193.Орон нутгийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах
		194.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах
		195.Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих
		196.Өвлөх эрхийн асуудлаар зохион байгуулалтын арга хэмжээ авах
		197.Гадаадын иргэдийн хаягийн бүртгэл хөтлөх, мэдээ гаргах
		198.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх
		199.Иргэдийг ажил, үйлдвэрлэл, нутаг дэвсгэрийн байрлалаар нь улсын хил хамгаалалтад туслах хүчин болгон зохион байгуулж, хил хамгаалалтад татан оролцуулах
		200.Иргэдийг хүлээж авах ажлыг зохион байгуулж, тэднээс гаргасан өргөдөл, санал, гомдлыг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх
		201.Төрийн ба төрийн бус архивын баримтад нэгдсэн тоо бүртгэл явуулахад дэмжлэг үзүүлж, зохион байгуулах, холбогдох мэдээ тайланг гаргах
		202.Тухайн нутаг дэвсгэр дэх шүүх, прокурорын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, цагдаагийн байгууллагыг удирдах
		203.Улсын хил хамгаалах байгууллагын хангалт үйлчилгээнд туслалцаа үзүүлж, Монгол Улсын хилийн хууль тогтоомжийг сахин биелүүлж байгаад хяналт тавих
		204.Хүн ам өрхийн бүртгэл болон түр оршин суугчийн бүртгэл хөтлөх
		205.Хууль сахиулах болон бусад байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, түүний хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах
		206.Хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, иргэдэд хуулийг сахин биелүүлэх дадал бий болгох
		207.Хүүхдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах, хяналт тавих
		208.Хүүхэд үрчлэн авах шийдвэр гаргах

34	Мэргэжлийн хяналт шалгалтыг орон нутагт хэрэгжүүлэх	209.Автозам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах, хамгаалах, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих
		210.Биеийн тамир, спортын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих
		211.Газрын нэгдмэл сан болон газрын хэвлийг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих
		212.Геодези, зураг зүйн ажилд хяналт тавих
		213.Соёлын хяналтыг хэрэгжүүлэх
		214.Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар нь ашиглуулах, эзэмшүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих.
		215.Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтыг хэрэгжүүлэх
		216.Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний стандарт, нормативын хэрэгжилтэд хяналт тавих
		217.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих
		218.Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтыг хэрэгжүүлэх
		219.Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтыг хэрэгжүүлэх
35	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний хэрэгжилтийг зохион байгуулах	220.Харьяанутаг дэвсгэртээ стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангаж, тохирлын үнэлгээний байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
36	Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг удирдан, зохион байгуулах	221.Аврах анги, отряд, салбар, алба, мэргэжлийн ангийг ажлаа хэвийн явуулах нөхцөлөөр хангах
		222.Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах
		223.Гамшгийн үед нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн хүч, техник хэрэгслийг дайчлан гаргах
		224.Гамшгийн үед шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, түүнийг захиран зарцуулах;
		225.Гамшгийн үеийн хохирлын үнэлгээ хийлгэж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах;
		226.Гамшгийн цагийн байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар дээд шатны байгууллагатай харилцах
		227.Гамшиг болсон нутгийн заагийг тогтоох
		228.Нутаг дэвсгэрийн онцлогт зохицуулан гамшгаас хамгаалах алба, штаб, мэргэжлийн ангиудыг байгуулж, тэдгээрийг гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох
		229.Харилцаа холбоо, зарлан мэдээлэх системийг байнгын бэлэн байдалд байлгах

37	Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах	230.Дайчилгааны бэлтгэл хангах, цугларах, шилжүүлэх байрыг тогтоох
		231.Дайчилгааны даалгаврыг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих
		232.Орон нутгийн хамгаалалтын мэдээллийн сан бүрдүүлэх
		233.Орон нутгийн хамгаалалтын нөөцийг бүрдүүлэх, даалгаваржуулах
		234.Орон нутгийн хамгаалалтын сургалт зохион байгуулах
		235.Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг төлөвлөх, хэрэгжүүлэх
		236.Иргэн цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр оруулан хаах, төлбөрөөс чөлөөлөх шийдвэрийг цэргийн штабын саналыг үндэслэн шийдвэр гаргах
		237.Цэрэг татлагын товчооны шийдвэрийн талаарх гомдол, маргааныг шийдвэрлэх
		238.Цэрэг татлага явуулахад шаардлагатай байр, тээврийн хэрэгслээр хангаж, дэмжлэг үзүүлэх албан тушаалтныг томилж ажиллуулах
		239.Цэргийн бэлтгэл албаны сургалтыг зохион байгуулах
38	Хотын дэд бүтцийн бодлогыг хэрэгжүүлж, инженерийн байгууламжийн ашиглалтын найдвартай ажиллагааг хангах	240.Авто зам, гүүрэн байгууламжийн ашиглалтын хэвийн найдвартай үйл ажиллагааг хангахад салбарын болон хот байгуулалт, төлөвлөлтийн бодлоготой уялдуулан нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах
		241.Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах, өргөх машин механизмын ашиглалт, засвар үйлчилгээ, техникийн аюулгүй байдлыг хангуулж мэргэжлийн байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангах
		242.Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, өдөр тутмын засвар арчлалтад тогтмол хяналт тавих
		243.Улаанбаатар хотын төвлөрсөн болон хэсэгчилсэн дулаан хангамжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах ажлыг салбарын болон хот байгуулалт, төлөвлөлтийн бодлого, зорилтуудтай уялдуулан ашиглалт, төлөвлөлтийн нэгдсэн удирдлагаар хангах
		244.Улаанбаатар хотын орон сууц, нийтийн аж ахуйн барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах ажлыг салбарын бодлого, төлөвлөлттэй уялдуулах, нэгдсэн удирдлагаар хангах
		245.Тээвэр, хөдөлгөөн зохион байгуулалтын бодлого, төлөвлөлттэй уялдуулан нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах
		246.Авто зогсоолын хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, менежментийг үр ашигтай зохион байгуулж, хяналт тавих
		247.Улаанбаатар хотын өндөржилт ус зайлуулах барилга байгууламжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах ажлыг салбарын болон хот байгуулалт, төлөвлөлтийн бодлого, зорилтуудтай уялдуулан, ашиглалт, төлөвлөлтийн байгууллагыг нэгдсэн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах
		248.Улаанбаатар хотын усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах ажлыг салбарын бодлого, төлөвлөлттэй уялдуулах, нэгдсэн удирдлагаар хангах
		249.Улаанбаатар хотын цахилгаан хангамжийн хэвийн найдвартай ажиллагааг хангуулах, салбарын хангагч, ашиглагч, харилцагч байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, нэгдсэн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулж хяналт тавих.

		250.Хотын өөрийн мэдлийн өмчийн тээврийн байгууллагыг удирдаж, нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл цагийн хуваарийг батлан, түүнчлэн оршин суугчдад үйлчилж байгаа тээврийн бусад байгууллагын үйл ажиллагаанд болон төмөр зам, нисэх буудалд зорчигчдын үйлчилгээг зохион байгуулж байгаад хяналт тавих
		251.Ерөнхий архитектороор удирдуулсан Хот байгуулалт, барилга захиалагчийн албыг байгуулах
39	Газар ашиглах, орчны бохирдлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх	252.Хотын эдэлбэр газрын ашиглалтыг төлөвлөх
		253.Хотын усны нөөцийг тогтоосон журмын дагуу ашиглуулах
		254.Хотын ариун цэвэр, эрүүл ахуй-халдваргүйжүүлэлтийн арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах
		255.Хотын экологийн байдлын талаар оршин суугчдад мэдээлэл хийх
		256.Хотын хүрээлэн байгаа орчин, ногоон бүсийг хамгаалах, сэргээх арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
		257.Хотын экологи, эрүүл ахуйн хэм хэмжээ зөрчсөн барилга байгууламжийг барьж ашиглахыг зогсоох
		258.Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг тайлагнах үүрэг бүхий албыг байгуулж ажиллуулах
		259.Хот байгуулалтын үйл ажиллагаа болон газар ашиглалт, хамгаалалтад хяналт тавих
40	Тохижилт, ногоон байгууламжийн бодлого хэрэгжүүлэх	260.Нийтийн эзэмшлийн зам талбайн ногоон байгууламж, түүний арчлалт, хяналтыг хэрэгжүүлэх
		261.Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, ашиглалтын хяналтыг хэрэгжүүлэх
41	Хотын өөрийн мэдлийн өмчийг захиран зарцуулах, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах	262.Хотын мэдлийн өмчийг хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулж, тэдгээрийг шинээр бий болгох, түрээслэх асуудлыг шийдвэрлэх
		263.Хотын оршин суугчдын ашиг сонирхолд нийцүүлэн хот, тосгоны өөрийн мэдлийн өмчийг хувьчлах асуудлыг боловсруулж хууль тогтоомжид заасан журмаар шийдвэрлүүлэх
		264.Хотын оршин суугчдын хэрэгцээг хангахад чиглэгдсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоход тус дэмжлэг үзүүлэх
		265.Хотын өөрийн мэдлийн аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагааг чиглүүлж, удирдлагыг нь томилж, чөлөөлөх
		266.Хотын нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллаж, хүнсний болон өргөн хэрэгцээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх талаар гэрээ байгуулах
42	Хүнс, худалдаа үйлчилгээний бодлого хэрэгжүүлэх	267.Ахуйн үйлчилгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих
		268.Хүнсний хангамж, үйлдвэрлэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих
		269.Хотын өөрийн мэдлийн аж ахуй, худалдаа, үйлчилгээний байгууллагын ажиллах цагийн хуваарийг тогтоох
		270.Худалдаа, яармаг болон үйлчилгээний бусад арга хэмжээг зохион байгуулах
		271.Худалдаа, үйлчилгээний газарт эрүүл ахуйн шаардлагыг хангуулах
		272.Хотын тохижилтын ажилд аж ахуйн нэгж, байгууллагыг гэрээний үндсэн дээр, түүнчлэн оршин суугчдыг зохион байгуулж оролцуулах

43	Хотын дэг журам, аюулгүй байдлыг хангах	273.Нийгмийн дэг журмыг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх талаар хууль хяналтын байгууллагатай харилцан ажиллаж, тэдгээрт туслалцаа үзүүлэх
		274.Оршин суугчдын санал, өргөдөл, гомдол, тэдний ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон асуудлыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хянан шийдвэрлэх
44	Хот, нийтийн аж ахуйн хөрөнгө оруулалт, төсөв санхүүг зохицуулах	275.Хотын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл, хөтөлбөрийг боловсруулан нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, гүйцэтгэлийг зохион байгуулах
		276.Хотын ерөнхий төлөвлөгөөг хууль тогтоомжид заасан журмаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
		277.Хуваарилсан төсвийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах
		278.Хотын нийгэм, эдийн засгийн хөгжилд шаардлагатай санхүү, эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, нөөцийн болон газар ашиглалтын зэрэг мэдээ, тайланг холбогдох байгууллага, албан тушаалтнаар гаргуулах
		279.Орон сууц хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх
		280.Орон сууцны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
45	Нийгмийн хамгаалал болон ахуйн соёлын хэрэгцээг хангах	281.Оршин суугчдын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх
		282.Боловсрол, соёл, эрүүлийг хамгаалах, нийгэм хангамж, биеийн тамир, спортын байгууллагаас үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх
		283.Оршин суугчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн амьдрах орчин, үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх
		284.Оршин суугчдаас нийгмийн хамгаалалт, дэмжлэг үзүүлбэл зохих амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур амьдралтай хэсэгт санхүүгийн болон эд материалын тусламж үзүүлэх санг зарим ажил, үйлчилгээнээс орсон орлогоос бүрдүүлэх
		285.Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалж, тэдгээрийн ашиглалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах
		286.Төсөвт зардлыг хэтрүүлэхгүйгээр баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах
		287.Хот, тосгоны шагналыг бий болгох, бэлгэдлийг батлах

Алхам 2. Холбогдогч талуудыг тодорхойлох.

Холбогдогч талуудыг тодорхойлохдоо Нийслэлийн Засаг даргаас бусад байгууллагатай харилцах эрх хэмжээг үндэслэсэн болно. Үүнийг ерөнхий байдлаар авч үзвэл Нийслэлийн Засаг дарга

1) дээшээ чиглэлд дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ажлынхаа үр дүнг тайлагнах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг нийгмийг хөгжүүлэх талаар санал шийдвэр боловсруулж хүргүүлэх, зөвлөгөө дэмжлэг авах;

2) хэвтээ чиглэлд үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, хамтран ажиллах, саналаа уламжлах, мэргэжил арга зүйн дэмжлэг авах;

3) доошоо чиглэлд нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, санал, иргэдийн дуу хоолойг сонсох, үйлчилгээ үзүүлэх, эргэх холбоогоор хангах зэрэг хэлбэрээр харилцдаг болно. Нийслэлийн үйл ажиллагаанд холбогдогч талуудыг дараах зурагт үзүүлэв.

Зураг 1. НИЙСЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОГЧ ТАЛУУД



Эдгээр холбогдогч талуудын оролцоог мэдээлэх, зөвлөх, санал өгөх, хамтран ажиллах, шийдвэр гаргах гэсэн ерөнхий ангиллын хүрээнд тодорхойлсон болно. Үүнийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3. ХОЛБОГДОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО

Холбогдогч талууд	Оролцоо					
	Мэдээлэх	Зөвлөх, эргэх холбоогоор хангах	Санал өгөх	Хамтран ажиллах	Шийдвэр гаргах	Бусад
УИХ					√	
ЗГ					√	
ЗГХЭГ		√			√	
Яам		√			√	
ЗГ-ын агентлаг		√		√	√	
Төр засгийн удирдах дээд байгууллага		√			√	
Нийслэлийн ИТХ		√			√	
Нийслэлийн ЗДТГ			√			
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба			√			
Нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллага			√	√		
Дүүргийн Засаг дарга	√		√	√		
Хэвлэл мэдээллийн байгууллага	√			√		
Олон улсын байгууллага	√		√	√		
Сургалт, судалгааны байгууллага	√		√	√		
Иргэд, ААН	√		√	√		

Алхам 3. Чиг үүргийн хэрэгжилтийг тодорхойлох.

Нийслэлийн чиг үүргийн хэрэгжилтийг тодорхойлохдоо Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ болон холбогдогч талуудаас авсан санал асуулгын судалгааны дүнг үндэслэсэн. Санал асуулгын судалгааны зорилго нь Нийслэлийн Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, гарсан өөрчлөлт (сүүлийн 4-5 жилийн хугацаанд)-ийг үнэлэхэд чиглэгдсэн болно. Санал асуулгын судалгаанд Нийслэлийн ЗДТГ, захирагчийн ажлын алба, Нийслэлийн ИТХ, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллага, Дүүргийн ЗДТГ-ын нийт 519 албан хаагч хамрагдсан болно.

Зураг 2. Судалгаанд оролцогчдын ерөнхий төлөв, хувиар



Нийслэлийн ерөнхий болон үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн тайлан болон санал асуулгын судалгааны үр дүнд тулгуурлан тодорхойлсон. Үүнийг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй байдлаар үзүүлэв.

Хүснэгт 4. НИЙСЛЭЛИЙН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ХУВИАР

д/д	Чиг үүрэг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн тайлан (хувиар)	Чиг үүргийн хэрэгжилтийн үнэлгээ		
		Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн тайлан (хувиар)	Холбогдогч талуудын үнэлгээ ⁵ (хувиар)	Дундаж үнэлгээ (хувиар)
1	Ерөнхий чиг үүрэг. Хүн амд нийгэм, соёлын үйлчилгээг үзүүлэх (1.1-1.5)	98%	51.5%	74.8%
Үндсэн чиг үүрэг	1.1 Хүн амын эрүүл мэндийг хамгаалах	100%	52.1%	76.0%
	1.2 Хүн амд боловсролын үйлчилгээг үзүүлэх	100%	52.9%	76.4%
	1.3 Биеийн тамир, спортыг хөгжүүлэх	100%	51.9%	76.0%
	1.4 Соёл урлагийг хөгжүүлэх	90%	51.8%	70.9%
	1.5 Соёлын өвийг хамгаалах	100%	49.1%	74.6%
2	Ерөнхий чиг үүрэг. Хүн амд хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэх (2.1-2.5)	85%	51.2%	73%
Үндсэн чиг үүрэг	2.1 Нутаг дэвсгэрийн хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх	-	49.5%	49.5%
	2.2 Нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих	-	49.3%	49.3%
	2.3 Хөдөлмөрийн харилцааг зохицуулах	-	51.6%	51.6%


	2.4	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	70%	49.6%	59.8%
	2.5	Нутаг дэвсгэрийн хүн амын нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэх	100%	56.6%	78.3%
3	Ерөнхий чиг үүрэг. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах (3.1-3.8)		91.6%	37.3%	64.5%
Үндсэн чиг үүрэг	3.1	Нутаг дэвсгэрийн байгалийн баялгийг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх	100%	45.1%	72.6%
	3.2	Газар, газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хангах	-	38.5%	38.5%
	3.3	Ашигт малтмалын эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих	80%	35.1%	57.6%
	3.4	Нутаг дэвсгэртээ байршдаг амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх	100%	42.5%	71.3%
	3.5	Нутаг дэвсгэртээ ургамал хамгаалах, хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх	100%	44.3%	72.2%
	3.6	Аялал жуулчлалын хөгжлийн бодлогыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх	100%	43.4%	71.7%
	3.7	Ус, цаг уур, орчны шинжилгээний арга хэмжээг хэрэгжүүлэх	-	43.7%	43.7%
	3.8	Усны бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх	70%	43.3%	56.7%
4	Ерөнхий чиг үүрэг. Орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх (4.1-4.4)		70%	48.3%	59.2%
Үндсэн чиг үүрэг	4.1	Нутаг дэвсгэрийн хэмжээнд барилга, хот байгуулалтын бодлого хэрэгжүүлэх	70%	44.4%	57.2%
	4.2	Нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн талаар баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх	-	48.8%	48.8%
	4.3	Эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх	70%	48.1%	59.1%
	4.4	Орон нутгийн чанартай зам гүүр, харилцаа холбоог хөгжүүлэх	-	52.0%	52.0%
5	Ерөнхий чиг үүрэг. Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэх (5.1-5.2)		100%	45.0%	72.5%
Үндсэн чиг үүрэг	5.1	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийг удирдлагаар хангах	100%	45.6%	72.8%
	5.2	Орон нутгийн өмчийн бодлого, шийдвэр хэрэгжүүлэх	100%	44.6%	72.3%
6	Ерөнхий чиг үүрэг. Хүнсний аюулгүй байдлыг хангаж, ХАА-ыг хөгжүүлэх (6.1-6.4)		100%	46.6%	73.3%
Үндсэн чиг үүрэг	6.1	Газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх	100%	46.5%	73.3%
	6.2	Мал аж ахуйг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх	100%	46.1%	73.1%
	6.3	Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний бодлого хэрэгжүүлэх	-	47.3%	47.3%
	6.4	Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнс тэжээлийн нөөцийн талаарх бодлого боловсруулж хэрэгжүүлэх	-	46.3%	46.3%

7		Ерөнхий чиг үүрэг. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөлт, төсөв санхүү, статистикийн бодлого хэрэгжүүлэх (7.1-7.4)	98.3%	49.1%	73.9%
Үндсэн чиг үүрэг	7.1	Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагаар хангах	93.3%	49.8%	71.6%
	7.2	Орон нутгийн төсөв, санхүүгийн бодлого хэрэгжүүлэх	100%	49.1%	74.6%
	7.3	Татварын хууль, тогтоомж хэрэгжилтийг хангаж, төсвийн орлого бүрдүүлэх	100%	49.9%	75.0%
	7.4	Статистик, тооллого судалгааг зохион байгуулах, үр дүнг тайлагнах	100%	47.7%	73.9%
8		Ерөнхий чиг үүрэг. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх (8.1)	100%	41.8%	70.9%
ҮЧУ	8.1	Гадаад, дотоодод тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх	100%	41.8%	70.9%
9		Ерөнхий чиг үүрэг. Хууль ёс, нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах (9.1-9.5)	93.3%	52.6%	73%
Үндсэн чиг үүрэг	9.1	Иргэдийн аюулгүй байдал, эрх, эрх чөлөөг хамгаалах	-	52.2%	52.2%
	9.2	Мэргэжлийн хяналт шалгалтыг орон нутагт хэрэгжүүлэх	90%	51.9%	70.9%
	9.3	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангаж, тохирлын үнэлгээний байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	-	47.8%	47.8%
	9.4	Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг удирдан, зохион байгуулах	90%	61.3%	75.7%
	9.5	Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах	100%	50.1%	75.1%
10		Ерөнхий чиг үүрэг. Хот, тосгоны нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэх (10.1-10.8)	96.2%	49.4%	72.8%
Үндсэн чиг үүрэг	10.1	Хотын дэд бүтцийн бодлогыг хэрэгжүүлж, инженерийн байгууламжийн ашиглалтын найдвартай ажиллагааг хангах	-	46.5%	46.5%
	10.2	Газар ашиглах, орчны бохирдлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх	100%	49.3%	74.7%
	10.3	Тохижилт, ногоон байгууламжийн бодлого хэрэгжүүлэх	90%	54.1%	72.1%
	10.4	Хотын өөрийн мэдлийн өмчийг захиран зарцуулах, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах	-	47.9%	47.9%
	10.5	Хүнс, худалдаа үйлчилгээний бодлого хэрэгжүүлэх	95%	50.8%	72.9%
	10.6	Хотын дэг журам, аюулгүй байдлыг хангах	100%	51.7%	75.9%
	10.7	Хот, нийтийн аж ахуйн хөрөнгө оруулалт, төсөв санхүүг зохицуулах	-	46.0%	46.0%
	10.8	Нийгмийн хамгаалал болон ахуйн соёлын хэрэгцээг хангах	-	48.5%	48.5%
ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ (1+2+3+4+5+6+7+8+9+10)			93.2%	47.3%	70.3%

Жич: (-) гэсэн тэмдэглэгээ нь тухайн чиг үүрэгтэй холбоотой арга хэмжээ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй гэсэн утгыг илэрхийлнэ. ЗДҮАХөтөлбөрт тусгагдаагүй үзүүлэлтийг үнэлгээнд оруулаагүй болно.

Нийслэлийн ерөнхий чиг үүргийн хэрэгжилтийг дүгнэн үзвэл 70.3 хувийн үнэлгээтэй байна. Гэхдээ Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн үнэлгээ нь санал асуулгын судалгааны дүнгээс 45.9 пунктээр өндөр буюу 93.2 хувийн үнэлгээтэй байна. Харин санал асуулгын судалгаанд оролцогчид Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд 2.17 буюу 47.3 хувийн үнэлгээ өгчээ. Ерөнхий чиг үүргийн хэрэгжилтийн дундаж үнэлгээг авч үзвэл нийгэм, соёлын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг хамгийн өндөр буюу 74.8 хувь, орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх чиг үүрэг хамгийн бага буюу 59.2 хувийн үнэлгээтэй байна. Нийслэлийн ерөнхий чиг үүргийн хэрэгжилтийн үнэлгээг дараах зурагт харьцуулан үзүүлэв.

Зураг 3. НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ХУВИАР



Алхам 4. Нийслэлийн Засаг даргад олгосон захиргааны эрх хэмжээ

Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан чиг үүрэг дахин хуваарилах аргачлалд заасны дагуу Нийслэлийн Засаг даргын эрх хэмжээг тодорхойлохдоо дараах ангиллыг баримтлав. Үүнд:

1. Бодлого боловсруулах: Үндэсний хэмжээний болон салбар, орон нутгийн урт, дунд, богино хугацааны стратеги зорилт боловсруулах, төлөвлөх, хууль тогтоомжийн төсөл, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандарт тогтоох, бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийх чиглэлээрх Засгийн газар, яамд болон нутгийн удирдлагын байгууллагуудын эрх хэмжээ хамаарна.

2. Зохицуулалт хийх: Тодорхой үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр төрийн байгууллагаас зөвшөөрөл, лиценз, магадлан итгэмжлэх, гэрчилгээ олгох зэрэг эрх хэмжээ хамаарна.
3. Зохион байгуулах: Тухайн шатны төрийн байгууллагад хуулиар тогтоож өгсөн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг удирдан чиглүүлэх эрх хэмжээ хамаарна.
4. Санхүүжилт: Төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллагуудын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, санхүүгийн дэмжлэг, зардал, хөрөнгө оруулалттай холбоотой эрх хэмжээ хамаарна.
5. Хүний нөөцийн бодлого: Удирдах албан тушаалтан болон албан хаагчдыг томилох, чөлөөлөх, чадавхжуулах, бэлтгэх, давтан сургах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх зэрэг эрх хэмжээ хамаарна.
6. Хяналт шинжилгээ, үнэлгээ: Төрийн байгууллагын дэвшүүлсэн зорилт, түүний хэрэгжилт, хүрсэн үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэх, ажлын чанар, гүйцэтгэлд хяналт шалгалт болон дотоод аудит хийх эрх хэмжээ хамаарна.
7. Үйлчилгээ үзүүлэх: Төрөөс үзүүлэх үйлчилгээг төрийн байгууллага болон нутгийн удирдлагын байгууллага, эсхүл гэрээний үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх хэмжээ хамаарна.

**Хүснэгт 5. НИЙСЛЭЛИЙН ЧИГ ҮҮРЭГ, ЗАХИРГААНЫ
ЭРХ ХЭМЖЭЭНИЙ АНГИЛЛААР**

№	ЧИГ ҮҮРЭГ	Захиргааны эрх хэмжээ						
		Бодлого боловсруулах	Зохицуулах	Зохион байгуулах	Санхүүжүүлэх	Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх	Үйлчилгээ үзүүлэх	Хяналт тавих
1	Ерөнхий чиг үүрэг. Хүн амд нийгэм, соёлын үйлчилгээг үзүүлэх (1.1-1.5)							
Үндсэн чиг үүрэг	1.1	Хүн амын эрүүл мэндийг хамгаалах	+	+		+	+	+
	1.2	Хүн амд боловсролын үйлчилгээг үзүүлэх	+	+		+	+	+
	1.3	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх		+		+	+	+
	1.4	Соёл урлагийг хөгжүүлэх	+	+	+	+	+	+
	1.5	Соёлын өвийг хамгаалах	+	+			+	+
2	Ерөнхий чиг үүрэг. Хүн амын хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэх (2.1-2.5)							

Үндсэн чиг үүрэг	2.1	Нутаг дэвсгэрийн хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх			+	+	+	+	+
	2.2	Нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих			+	+		+	+
	2.3	Хөдөлмөрийн харилцааг зохицуулах			+	+	+	+	+
	2.4	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих			+	+	+	+	+
	2.5	Нутаг дэвсгэрийн хүн амын нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэх			+			+	+
3	Ерөнхий чиг үүрэг. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах (3.1-3.8)								
Үндсэн чиг үүрэг	3.1	Нутаг дэвсгэрийн байгалийн баялгийг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх			+	+	+		+
	3.2	Газар, газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах		+	+	+	+		+
	3.3	Ашигт малтмалын эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих		+	+		+		+
	3.4	Нутаг дэвсгэртээ байршдаг амьтныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх			+	+	+		+
	3.5	Нутаг дэвсгэртээ ургамал хамгаалах, хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх			+	+	+		+
	3.6	Аялал жуулчлалын хөгжлийн бодлогыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх	+	+	+	+	+		+
	3.7	Ус, цаг уур, орчны шинжилгээний арга хэмжээг хэрэгжүүлэх			+				
	3.8	Усны бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх		+	+	+	+		+
4	Ерөнхий чиг үүрэг. Орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх (4.1-4.4)								
Үндсэн чиг үүрэг	4.1	Нутаг дэвсгэрийн хэмжээнд барилга, хот байгуулалтын бодлого хэрэгжүүлэх	+	+	+	+	+	+	+
	4.2	Нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн талаар баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх	+		+	+	+	+	+
	4.3	Эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх			+				+
	4.4	Орон нутгийн чанартай зам гүүр, харилцаа холбоог хөгжүүлэх	+	+	+	+	+	+	+
5	Ерөнхий чиг үүрэг. Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэх (5.1-5.2)								
Үндсэн чиг үүрэг	5.1	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийг удирдлагаар хангах	+		+	+	+	+	+
	5.2	Орон нутгийн өмчийн бодлого, шийдвэр хэрэгжүүлэх	+		+	+	+	+	+

6	Ерөнхий чиг үүрэг. Хүнсний аюулгүй байдлыг хангаж, хөдөө, аж ахуйн хөгжүүлэх (6.1-6.4)						
Үндсэн чиг үүрэг	6.1	Газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх			+	+	
	6.2	Мал аж ахуйг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх			+	+	+
	6.3	Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний бодлого хэрэгжүүлэх	+	+	+	+	+
	6.4	Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнс тэжээлийн нөөцийн талаарх бодлого боловсруулж хэрэгжүүлэх			+	+	+
7	Ерөнхий чиг үүрэг. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөлт, төсөв санхүү, статистикийн бодлого хэрэгжүүлэх (7.1-7.4)						
Үндсэн чиг үүрэг	7.1	Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагаар хангах	+		+	+	+
	7.2	Орон нутгийн төсөв, санхүүгийн бодлого хэрэгжүүлэх	+		+	+	+
	7.3	Татварын хууль, тогтоомж хэрэгжилтийг хангаж, төсвийн орлого бүрдүүлэх	+		+	+	+
	7.4	Статистик, тооллого судалгааг зохион байгуулах, үр дүнг тайлагнах	+		+	+	+
8	Ерөнхий чиг үүрэг. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх (8.1)						
үчү	8.1	Гадаад, дотоодод тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх	+		+	+	
9	Ерөнхий чиг үүрэг. Хууль ёс, нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах (9.1-9.5)						
Үндсэн чиг үүрэг	9.1	Иргэдийн аюулгүй байдал, эрх, эрх чөлөөг хамгаалах	+		+		+
	9.2	Мэргэжлийн хяналт шалгалтыг орон нутагт хэрэгжүүлэх			+		+
	9.3	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангаж, тохирлын үнэлгээний байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх			+	+	
	9.4	Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг удирдан, зохион байгуулах	+		+	+	+
	9.5	Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах			+		
10	Ерөнхий чиг үүрэг. Хот, тосгоны нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэх (10.1-10.8)						

Үндсэн чиг үүрэг	10.1	Хотын дэд бүтцийн бодлогыг хэрэгжүүлж, инженерийн байгууламжийн ашиглалтын найдвартай ажиллагааг хангах	+	+	+	+	+	+	+
	10.2	Газар ашиглах, орчны бохирдлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх	+	+	+	+	+	+	+
	10.3	Тохижилт, ногоон байгууламжийн бодлого хэрэгжүүлэх	+	+	+	+	+	+	+
	10.4	Хотын өөрийн мэдлийн өмчийг захиран зарцуулах, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах	+	+	+	+	+	+	+
	10.5	Хүнс, худалдаа үйлчилгээний бодлого хэрэгжүүлэх	+	+	+	+	+	+	+
	10.6	Хотын дэг журам, аюулгүй байдлыг хангах	+	+	+	+	+	+	+
	10.7	Хот, нийтийн аж ахуйн хөрөнгө оруулалт, төсөв санхүүг зохицуулах	+	+	+	+	+	+	+
	10.8	Нийгмийн хамгаалал болон ахуйн соёлын хэрэгцээг хангах			+	+			+

Дээрх хүснэгтийг нэгтгэн харвал Нийслэлийн хэмжээнд Хүн амд нийгэм, соёлын үйлчилгээ үзүүлэх, Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх, Байгаль орчныг хамгаалах, Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйг хөгжүүлэх, Хууль ёс, нийгмийн аюулгүй байдлыг хангах үүргүүдийн хувьд бодлого боловсруулах эрх хэмжээ хязгаарлагдмал, харин бусад чиг үүргийн хувьд энэ эрх хэмжээ нь тодорхой түвшинд олгогдсон байдаг байна. Ялангуяа, нийслэлд төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих эрх хэмжээ нь давамгайл олгогдсон байна.

Гэхдээ нийслэлийн хэмжээнд хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдал, биеийн тамир спортыг хөгжүүлэх, аялал жуулчлалын бодлогыг хэрэгжүүлэх, хотын нийтийн аж ахуйтай холбоотой чиг үүргийн хэрэгжилтийг зохион байгуулахад эрх зүйн зохицуулалт тодорхойгүй, салбарын хуулийг дагаж гарах ёстой зарим нэг журам нь батлагдаж гараагүй, төсвийн эрх хэмжээ нь хязгаарлагдмал байдаг явдал нь хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангахад хүндрэл учруулдаг байна. Өөрөөр хэлбэл, нийслэлд эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэх эрх хэмжээ нь өгөгдсөн хэдий ч түүний хэрэгжилтийг хариуцсан байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагааны зохицуулалтыг холбогдох эрх зүйн зохицуулалтаар тодорхой болгож өгөөгүй тохиолдол байдаг байна. Үүнийг дараах хүснэгтээр үзүүлэв.

**Хүснэгт 6. НИЙСЛЭЛИЙН ХАРЬЯА ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН
ХУУЛИАР ОЛГОГДСОН ЭРХ ХЭМЖЭЭ**

№	Хуулиар олгосон үүрэг	Хуулийн нэр, заалт	Тайлбар	Санал өгсөн байгууллагын нэр
1	Нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд “стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах” журмын дагуу стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ	Хүнсний тухай хууль (2012)-ийн 6.3-р зүйл	ХХААХҮЯамнаас хуулийг дагалдан гарах “стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах” журмыг баталж гаргаагүй байгаа учир энэ заалт хэрэгжихгүй байгаа	Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар
2	Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатны Засаг дарга авч хэрэгжүүлнэ	Хүнсний тухай хууль (2012)-ийн 6.5-р зүйл		Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар
3	Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн нийслэлийн Засаг дарга олгож, сунгаж, хүчингүй болгоно.	Архидан согтууруулахтай тэмцэх тухай хууль (2000)-ийн 4.1-р зүйл	Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл олгож байгаа. Гэхдээ ХХААХҮЯамнаас хуулийг дагалдан гарах журмыг батлагдаж гараагүй байгаа болно.	Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар
5	Сууц өмчлөгчдийн холбоог зохион байгуулах хурлын шийдвэрийг үндэслэн дүүргийн Засаг даргын тамгын газар холбоог бүртгэх	Сууц өмчлөгчдийн холбоодын эрхзүйн байдал, нийтийн зориулалттай байшингийн дундын эзэмшлийн эд хөрөнгийн тухай хууль(2003)-ийн 18.1-р зүйл	Сууц Өмчлөгчдийн Холбоог байгуулах, бүртгэх эрх нь дүүргийн Засаг даргын Тамгын газарт байдаг. Гэтэл дээрх холбоодын үйл ажиллагааны доголдол, иргэдийн гомдлын дагуу хяналт, шалгалтаар илэрсэн асуудлыг эцэслэн шийдвэрлэх, шаардлага хангахгүй СӨХ-ны удирдлагад хариуцлага тооцох эрх нь нийслэл, дүүргийн аль ч шатны удирдлагад байхгүй байна. Уг хуулинд тусгагдаагүй барилгын гүйцэтгэгчтэй холбоотой болон орон сууцны ашиглалтын үйлчилгээ, гадна шугам сүлжээний өмчлөл, эзэмшилтэй холбоотой зохицуулалт бүрхэг хэвээр байна.	Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨТҮГ

6	Гудамж талбайг гэрэлтүүлэх	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль(2006)-ийн 31.1.7-р зүйл	Гудамж талбайг гэрэлтүүлэхтэй холбоотой чиг үүргийг зөвхөн дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд тусгаж өгсөн байдаг. Энэ нь хотын гэрэлтүүлгийн асуудлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангахад хүндрэл учруулдаг.	Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨТҮГ
7	Нийслэлийн Засаг дарга мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006)-ийн 29.1.3.а-р зүйл	Гэрийн тэжээвэр амьтан болох нохой, муур тэжээх, арчилж үржүүлэх, аюул учруулж буй хэсгийг устгахтай холбоотой харилцаа засаг захиргааны нэгжүүдийн аль ч шатанд зохицуулагдаагүй байдаг. Энэхүү харилцааг зохицуулсан журам байхгүй. Тухайлбал, нохой устгалтай холбоотой Хотын захирагчийн ажлын албаны боловсруулан журам байдаг хэдий ч үүнийг Хууль зүйн яамнаас эрхзүйн үндэслэлгүй гэж үздэг.	Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨТҮГ
8	Нийслэлийн Засаг дарга биеийн тамир, спортыг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх эрхтэй	Биеийн тамир, спортын тухай хууль (2017)-ийн 8.1.3-р зүйл	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 47 дугаар тогтоолоор Биеийн тамир, спортын хороо босоо тогтолцоотой болж, Төсвийн тухай хуулийн дагуу улсын төсвөөс санхүүждэг болсон. Өөрөөр хэлбэл, орон нутгийн төсөвт биеийн тамир, спортын талаар бие даасан төсөв байхгүй. Энэ нь хуулийн заалтыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж чадахгүй байна.	Спортын хороо
9	Нийслэлийн Засаг дарга аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлж, аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах, зохион байгуулах	Аялал жуулчлалын тухай хууль(2000)-ийн 18.2.1-р зүйл	Аялал жуулчлалын зочлох үйлчилгээний байгууллага (зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны бааз, гэр буудал)-уудад стандартын хяналт тогтоох бүрэн эрх олгогдоогүй. Учир нь төрийн хяналт шалгалтын тухай хууль(2003)-аар мэргэжлийн хяналтын байцаагчийн эрх хариуцсан байгууллагад нь байдаггүй.	Нийслэлийн Аялал жуулчлалын газар

Үүнээс гадна нийслэлийн хэмжээнд зарим байгууллагын үйл ажиллагаа нь давхардах, чиг үүрэг нь оновчтой хуваарилагдаагүй байдал ажиглагдлаа. Энэ нь нийслэлийн чиг үүргийн хэрэгжилтийг зохион байгуулахад хүндрэл учруулдаг байна. Үүнийг санал ирүүлсэн байгууллагуудын мэдээлэлд үндэслэн дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 7. ДАВХАРДСАН ЧИГ ҮҮРЭГТЭЙ БАЙГУУЛЛАГА

№	Үйл ажиллагаа нь давхардсан байгууллагын нэр	Давхцал үүсдэг үйл ажиллагаа	Тайлбар	Санал ирүүлсэн байгууллага
1	Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газар Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар	Хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Барилга хот, байгуулалтын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1/3738 дүгээр албан бичгээр НЗД-ын 2020 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/1022 дугаар захирамж, Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/63 дугаар тушаалыг /хуульд нийцэхгүй шийдвэр/ хүчингүй болгох, барилга байгууламжийг ашиглалтад оруулах байгууллагын чиг үүргийг тодорхой болгох талаар үүрэг ирүүлсэн. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйл, Барилгын тухай хуулийн 47 дугаар зүйлд барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын чиг үүргийг тодорхой заасан байдаг. Гэхдээ барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагаатай холбоотой эрх олгогдоогүй болно. Барилга байгууламжийн техникийн улсын хяналтыг барилгын улсын хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага чиг үүргийн дагуу зөвхөн хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх нь зүйтэй.	Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газар
2	Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газар Нийтийн тээврийн үйлчилгээний газар	Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 8 дугаар зүйлийн 8.4-т заасан нийслэлийн нутаг дэвсгэр дэх нийтийн тээвэр шуудан тээвэрлэлтийг зохицуулан зохион байгуулах, хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийг тогтоох, өөрчлөх, төлөвлөх НЗД-ын бүрэн эрхийг тус газар нь хэрэгжүүлдэг болно. Гэвч НЗД-ын 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/1113 дугаар захирамжаар “Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газрын дүрэм” шинэчлэн батлагдсан бөгөөд дүрмийн 3.4, 3.5, 3.6 дахь хэсэгт заасан чиг үүрэг нь нийтийн тээврийн үйлчилгээний газрын чиг үүрэгтэй давхцалтайгаар батлагдсан.	Нийтийн тээврийн үйлчилгээний газар

3	Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар	Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил, хамгааллын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар чиг үүргийнхээ хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ, цагийн ажилд зуучлах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагаатай давхцдаг.	Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар
4	Нийслэлийн жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төв Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар	Хөдөлмөр эрхлэлтийн ажлын байрыг дэмжих бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Хөдөлмөр эрхлэлтийн ажлын байрыг дэмжих бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хоёр байгууллагын үйл ажиллагаа давхардах тохиолдол байдаг.	Нийслэлийн жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төв
5	Дүүргүүдийн Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг орон нутагт зохион байгуулах	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, бичил бизнес эрхлэгч хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалт зохион байгуулах, зөвлөгөө мэдээллээр хангах ажлын хувьд давхцал их байдаг.	Нийслэлийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв
6	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба Нийслэлийн Байгаль орчны газар	Орчныг бохирдлыг бууруулах	Орчны бохирдол, хөрс хамгаалахтай холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэхэд давхцал гардаг.	Нийслэлийн байгаль орчны газар
7	Замын хөдөлгөөний удирдлагын төв Нийслэлийн мэдээлэл, технологийн газар	Улс нийслэл, дүүрэг гадаадын зээл тусламжаар суурилуулсан болон шинээр суурилуулах теле хяналтын камеруудыг бүртгэлжүүлэх техникийн тодорхойлолт боловсруулах, ажил хүлээлцэхэд хяналт тавих, хууль эрх зүйн хүрээнд дүрэм, журам, стандартыг мөрдүүлж ажиллах	Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/755 дугаар захирамжаар нийслэлийн хэмжээнд Улс нийслэл, дүүргийн орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл тусламж болон хувийн хэвшлийн санхүүжилтээр нийтийн зээмшлийн гудамж, талбай, олон нийтийн газар, авто зам, нийтлэг үйлчилгээний хяналтын чиглэлээр хийгдэх телехяналтын камерын төлөвлөгөөг батлуулах, техникийн тодорхойлолт боловсруулах, хүлээн авах комисс байгуулж ажиллахыг Нийслэлийн мэдээлэл, технологийн газарт үүрэг болгосон байдаг. Энэ үйл ажиллагаа нь замын хөдөлгөөний удирдлагын төвийн үйл ажиллагаатай давхцал үүсгэдэг.	Нийслэлийн мэдээлэл, технологийн газар

8	Нийслэлийн Орон сууцны корпораци Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газар	Газраа чөлөөлсөн иргэдийг түр суурьшуулах байраар хангах	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд төсөл хэрэгжих байршил дахь айл өрхүүд Нийслэлийн Засаг дарга болон төсөл хэрэгжүүлэгчтэй гурван талт гэрээ байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгөө чөлөөлдөг. Төслийн явцад амьдрах орчин нөхцөл хүндэрсэн айл өрхийг түр суурьшуулах байраар хангах ажлыг Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газар хариуцан гүйцэтгэдэг байсан. Гэтэл Нийслэлийн Орон сууцны корпорацид эрх шилжсэнээр эдгээр иргэдийн байгуулсан гурван талт гэрээг НОСК-д хүлээлгэж өгөх, хүлээж авсан гэрээний дагуу иргэдийг байраар хангаж ажиллах зэргээр НОСК тус ажиллагааг хэрэгжүүлж байгаа нь шат дамжлага үүсгэж, дунд нь мэдээлэл алдагдах, иргэдийн эрх ашиг хохирох зэрэг бэрхшээлийг үүсгэж байна.	Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газар
9	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газар	Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган, шинээр барих Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах	Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан таван төрлийн үйл ажиллагааг Нийслэлийн хэд хэдэн байгууллагад хариуцуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар 12.1.1, 12.1.2 –д заасан үйл ажиллагааг, Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газар 12.1.3, 12.1.4 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн нийслэлийн орон сууцны дэд бүтцийн газар нь Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Нийслэлийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/232 дугаар захирамж, “Дүрэм батлах тухай” Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/304 дүгээр захирамжийн дагуу • хот, суурин газрыг нийгэм эдийн засаг, экологи, соёл боловсролын тогтвортой хөгжлийг хангасан, суурьшлын бүс болгон хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх; • хот, суурин газрыг дахин хөгжүүлэх хуулийн хүрээнд төсөл хөтөлбөрүүдийг иргэдийн оролцоотой зохион байгуулах, ажлын даалгавар, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, төслийн үйл ажиллагаанд хяналт тавих, төсөлд оролцогчдын хууль ёсны эрхийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Ийнхүү чиг үүргийг олон байгууллагад хуваарилан хэрэгжүүлэх нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад хүндрэл учруулж байна.	Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газар

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Алсын хараа нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ирээдүйн төлөвийг илэрхийлсэн, хөгжлийн чиг баримжааг тодорхойлсон үр дүн юм. Өөрөөр хэлбэл, алсын хараа нь амжилт дэвшилд хөтлөх уриа дуудлага бөгөөд нийслэлийн үйл ажиллагаа бүхэлдээ алсын хараанд чиглэнэ.



АЛСЫН ХАРАА:

Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болно.

УРИА:

Бидний үйлдэл - бидний ирээдүй.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрхэм зорилго нь засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн одоо ба ирээдүйн үйл ажиллагааны талаарх үнэт зүйл, хөгжлийн үзэл баримтлал, оршин тогтнох учир шалтгааныг илэрхийлнэ.

Нийслэлийн эрхэм зорилгыг нийгмийн өмнө хүлээсэн үүрэг ба иргэд, оршин суугчдын хүсэл сонирхлыг жолоодох асуудлуудад тулгуурлан томьёолов. Ингэхдээ бид юу хийдэг вэ? хэнд зориулж үүнийг хийдэг вэ?, яагаад үүнийг хийдэг вэ? гэсэн гурван асуултыг чиг баримжаа болгов.



ЭРХЭМ ЗОРИЛГО:

Иргэд, оршин суугчдаа эрүүл, аюулгүй орчинд аз жаргалтай амьдрах таатай боломжоор хангах

ҮНЭТ ЗҮЙЛ:

- ☑ **Иргэн төвтэй байх** – Иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, дээдлэх, тэдний дуу хоолойг сонсох;
- ☑ **Тэгш шударга байх** – Нийтийн эрх ашгийг эрхэмлэх, иргэдийг хөгжлөөс хоцроохгүй байх адил тэгш боломжоор хангах;
- ☑ **Ил тод байх** – Хуулиар нууцын зэрэглэлд хамаарахаас бусад мэдээлэл нь олон нийтэд нээлттэй, ил тод, ойлгомжтой байх;
- ☑ **Хууль дээдлэх** – Үйл ажиллагаандаа хуулийг хэлбэрэлтгүй сахин биелүүлэх, хэрэглэх, хуульд нийцсэн шийдвэр гаргах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, нөлөөнд автахгүй байх
- ☑ **Мэргэшсэн, хариуцлагатай байх** – Ажил үүргээ мэргэжлийн өндөр түвшинд чадмаг, сурамгай, найдвартай гүйцэтгэх, хариуцсан ажилдаа эзэн байх;
- ☑ **Мэдлэг, инновацийг эрхэмлэх** – Асуудлыг шийдвэрлэх гарц, гаргалгаа нь шинжлэх ухаанч, шинэ санаа, технологийн дэвшилтэд шийдэлд тулгуурласан байх;

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Орчны шинжилгээний үндсэн зорилго нь нийслэлийн нөхцөл байдлыг судалж, судалгааны үр дүнг Нийслэлийн дунд хугацааны стратегийн шийдвэрийн гол үндэслэлийг томъёолоход суурь болгон ашиглах юм. Өөрөөр хэлбэл, гадаад, дотоод орчны талаарх мэдээллийг цуглуулж, түүнд дүн шинжилгээ хийх замаар хөгжлийн чиг хандлагыг тодорхойлно.

Орчны шинжилгээг хийхдээ статистик, социологийн болон бусад судалгааны аргуудыг өргөн ашиглах ба судалгааны анхдагч мэдээлэл болгон тухайн салбар, байгууллагын үйл ажиллагааг судалсан судалгаа шинжилгээний өнгөрсөн 4 жилийн тайлан, жил, улирлын гүйцэтгэлийн, төсөв санхүүгийн тайлангууд болон мандатын шинжилгээний хүрээнд хийгдсэн гадагш, дотогш чиглэсэн харилцааны хүрээнд холбогдогч талууд болох Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллага, дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийт 519 албан хаагчдыг хамруулан хийгдсэн асуулга судалгааны үр дүн, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын “Монгол Улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний салбарын танилцуулга, санал”-аас нийслэлийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид анхаарах зүйлс зэрэг мэдээлэлд үндэслэн SWOT шинжилгээний аргыг ашиглан гүйцэтгэсэн болно. SWOT шинжилгээний арга нь үйл ажиллагааны одоогийн дүр төрхийг тодорхойлж, давуу ба сул тал, боломж, аюул заналаар дамжуулан цаашид хөгжүүлэх арга замыг тодорхойлон гаргадаг.

Тиймээс SWOT шинжилгээг нийслэлийн дотоод болон гадаад орчны хүчин зүйлсийг тодорхойлоход голлон чиглэсэн ба үүнийг нийслэлийн мандатад үндэслэхийн зэрэгцээ дараах төрөлд ангилан шинжилгээг хийсэн. Үүнд:

- Ковид 19 цар тахлаас үүдэлтэй хүндрэл
- Засаглал
- Хүний хөгжил
- Эдийн засаг
- Ногоон хөгжил
- Хотжилт /хот төлөвлөлт, дэд бүтэц/


Мөн сүүлийн 2 жилийн цаг үеийн нөхцөл байдлыг харгалзан “Ковид 19” цар тахлын нөлөөлөл, түүний үр дагаврыг шинжилгээнд хамруулан авч үзсэн.

ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Дэлхийн хүн ам хурдацтай өсөн нэмэгдэж байгаагийн зэрэгцээ хот суурин газар төвлөрөн амьдрах хэв маяг нийтлэг үзэгдэл болж байна. Өнөөдрийн байдлаар дэлхий дээр 7.7 тэрбум хүн амьдарч байгаагаас 55.3% буюу 4.2 тэрбум нь хот суурин газрын амьдралын хэв маягтай байна. 2050 он гэхэд хот, суурин газрын оршин суугчдын тоо 6.3 тэрбум буюу манай гарагийн нийт хүн амын 66% -д хүрнэ гэсэн тооцоо байна (Конрад-Аденаур сан, 2019, хуудас 141). Үүний нэгэн адил Монгол улсын Нийслэл Улаанбаатар хотын хүн ам ч хурдацтай өсөж, хотжилтын үйл явц ч эрчимтэй нэмэгдэж байна.

Улаанбаатар хотын хүн ам жилээс жилд өсөн нэмэгдэж, суурьшлын бүс өргөжин төлсээр байгаа хэдий ч хотын амьдралын чанар, амьдрах орчин, аюулгүй байдал, засаглалын үзүүлэлт сайнгүй хэвээр байна (Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв, 2019)

Зураг 4. УЛААНБААТАР ХОТЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКС



Эх сурвалж: (Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв, 2019)


Улаанбаатар хотын өрсөлдөх чадварын индексээс харвал эдийн засаг, амьдралын чанарын индекс сайн, аюулгүй байдал дундаж, засаглал, амьдрах орчны индекс бага үзүүлэлттэй байна. Эндээс хотын засаглал, амьдрах орчны үзүүлэлтүүдийг анхаарах шаардлагатай нь харагдаж байна.

Улаанбаатар хот нь нийт 4.375,1 км² газар нутагтай, Монгол Улсын нийт газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг. Улаанбаатарын бүс нь Улаанбаатар хот түүнийг тойрсон дагуул хот, тосгод гэсэн тогтолцоотой, Улаанбаатар хот нь нийгэм эдийн засаг, дэд бүтэц, инженерийн хангамж зэрэг хот байгуулалтын бүх үзүүлэлтээр бусад хот тосгодоос илүү давуу талтай. Улаанбаатарын бүсэд Улаанбаатар хот, Налайх, Багануур, Багахангай дүүргүүд, хотыг тойрсон Сонгино-Био, Туул-Шувуу, Өлзийт,

Гацуурт, Хонхор, Жаргалант, Рашаант, 361-н гарам, Тэрэлж гэх мэт төвлөрсөн хот, тосгон, 60 гаруй амралт сувилал, хөдөөгийн суурингууд хамрагдана. Хөдөө орон нутгаас Улаанбаатар хотыг чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний урсгалыг бүсийн хот суурингууд сааруулан шингээх чадвар дутмаг байх тул хаяа дагуул хот тосгодын өсөлт удаан байна.

Нийслэл нь засаг захиргааны нэгжийн хуваарилалтаар 9 дүүрэг, 171 хороонд хуваагдана.

Зураг 5. УЛААНБААТАР ХОТЫН ГАЗРЫН ЗУРАГ



Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын бараг 2 хүн тутмын нэг нь нийслэл хотод төвлөрч, хүн амын нягтралаар хамгийн өндөр хот болж байна. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгж байгууллагын 64.2 хувь нь нийслэл хотод төвлөрч, дотоодын нийт бүтээгдэхүүний 66.6 хувийг бүрдүүлж, улсын нийгэм, эдийн засгийн цөм болон хөгжиж байна.

Улаанбаатар хотын эдийн засгийн 58.4 хувийг үйлчилгээний, 41.3 хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 0.4 хувийг хөдөө аж ахуйн салбар тус тус эзэлж байна.


Эдийн засгийн бодит өсөлт жилд дунджаар 8.7 хувь байсан ба хамгийн их өсөлт барилга, аж үйлдвэрийн салбарт гарсан байна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2019 онд 16.9 мянган төгрөг байна.

Нийслэлийн төсвийн орлого нь “Төсвийн тухай” хуулийн 23 дугаар зүйлд зааснаар төсвийн орлогын ангиллын дагуу нийтдээ 23 нэр төрлийн татварын болон татварын бус орлогын нэр төрлөөс бүрдэж байгаагаас 16 нэр төрөл нь татварын орлогоос, 5 нь татварын бус орлогоос, 2 нь хөрөнгийн түрээс болон өмч хувьчлалын орлогын нэр төрлөөс бүрдэж байна.

Нийслэлийн төсвийн орлогын 60.5 хувийг Хувь хүний орлогын албан татвар бүрдүүлж байгаагийн 45.3 орчим хувийг Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар дангаар эзэлж, үлдэх хувийг үл хөдлөх хөрөнгө, буу, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгсэл, газар, ус гэх мэт тодорхой нэг объектод хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулдаг хязгаарлагдмал эх үүсвэр бүхий орлого бүрдүүлж байна.

Монгол Улсын Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичигт Улаанбаатар ба дагуул хот бие даасан бүлгийг тусгуулсан. Нийслэлийг хөгжүүлэх дунд болон богино хугацааны бодлогоо тодорхойлсон.

Зураг 6. УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ



Улаанбаатар хот нь 1.5 сая хүн амтай, нийгмийн болоод инженерийн дэд бүтэц дутагдалтай, нийт хүн амын 54,5 хувь буюу 185.400 мянган өрх гэр хороололд, 45.5 хувь буюу 226.600 мянган өрх орон сууцанд амьдарч, агаар хөрсний бохирдол, замын түгжрэл зэрэг олон асуудалтай тулгарч байгаа. Мөн хотын газар зүйн байршлын хувьд тэлэх боломж хязгаарлагдмал, инженерийн дэд бүтцийн хөгжлөөр “заримдаг”, газрын харилцааны хөгжил сул байдалтай хүн ам голлон төвлөрсөн байдал зөрчилдөж, хотын “даацын чадамж”-ийн талаар онцгой анхаарах шаардлагатай болсон. Сүүлийн 2 жилд дэлхий дахинд дэлгэрээд байгаа “Ковид 19” цар тахлын улмаас хүн амын эрүүл мэнд, боловсрол, эдийн засгийн нөхцөл байдал зэрэг нийгмийн бүхий салбарт хүндрэл бэрхшээлийг үүсгэж байна.

Нийслэлийн стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн мандатын хэрэгжилтийн түвшинг тодорхойлсон судалгааны үр дүнгээс үзвэл Нийслэлийн Засаг даргын ерөнхий чиг үүргийн хэрэгжилт 70.3 хувийн үнэлгээтэй байна. Үүнд нийгэм, соёлын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг хамгийн өндөр буюу 74.8 хувь, орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх чиг үүрэг хамгийн бага буюу 59.2 хувийн үнэлгээтэй байна.

Нийслэлийн нутгийн захиргааны бүтэц: 1992 оны Монгол Улсын Үндсэн Хуулийн 61.4 дүгээр зүйлд Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 100 дугаар тогтоол “Нийслэлийн засаг даргын тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтэц, тэдгээрийн орон тооны хязгаарыг батлах тухай”-оор шинэчлэн тогтоосон. Өнөөдөр нийслэлийн төрийн захиргааны удирдлага дараах бүтцээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч
- Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч (хөгжлийн бодлогын асуудал хариуцсан)
- Нийслэлийн Засаг даргын орлогч (хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан)
- Нийслэлийн хот байгуулалтын асуудал хариуцсан төслийн удирдагч
- Инновац технологийн асуудал хариуцсан төслийн удирдагч
- Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслийн удирдагч
- Зам, тээврийн асуудал хариуцсан төслийн удирдагч
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Нийслэлийн ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга

Харин тус тогтоолоор тогтоосны дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Захирагчийн ажлын алба дараах бүтцээр ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтэц:

- Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Хүний нөөцийн удирдлагын тасаг, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, Сургалт, судалгааны төв (Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дүрэм шинэчлэн батлах тухай. 2020 оны 6 сарын 25-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын А/881 захирамж);
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Бодлогын судалгааны тасагтай);
- Төсөл, хөтөлбөрийн хяналт, зохицуулалтын хэлтэс;
- Санхүү, төрийн сангийн хэлтэс;
- Нийгмийн бодлогын хэлтэс (Соён гэгээрүүлэх тасагтай);
- Хууль, эрх зүйн хэлтэс;
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс;
- Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс (Олон нийттэй харилцах тасагтай);
- Цэргийн штаб.


Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба:

- Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга;
- Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс;
- Хотын инженерийн байгууламжийн хэлтэс;
- Хүнс үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хэлтэс;
- Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтэс;
- Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтэс;
- Дотоод хяналтын хэлтэс.

Мөн Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах хэрэгжүүлэгч агентлагууд ажиллаж байна. Үүнд:

1. Авто замын хөгжлийн газар;
2. Агаарын бохирдолтой тэмцэх газар;
3. Архивын газар;
4. Аялал жуулчлалын газар;
5. Байгаль орчны газар (Зуслангийн товчоотой);
6. Спортын хороо;
7. Боловсролын газар;
8. Нийслэлийн газар зохион байгуулалтын алба;
9. Хот байгуулалт, хөгжлийн газар;
10. Орон сууцны дэд бүтцийн газар;
11. Дотоод аудитын газар;
12. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;
13. Мал эмнэлгийн газар;
14. Мэдээлэл, технологийн газар;
15. Мэргэжлийн хяналтын газар;
16. Нийгмийн даатгалын газар;
17. Нийгмийн халамжийн газар;
18. Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар;
19. Нийслэлийн бүртгэлийн газар;
20. Онцгой байдлын газар (Нөөцийн албатай);
21. Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар;
22. Статистикийн газар;
23. Соёл, урлагийн газар;
24. Татварын газар;
25. Нийтийн тээврийн үйлчилгээний газар;
26. Хөдөлмөр эрхлэлтийн газар;
27. Хүнс, хөдөө аж ахуйн газар;
28. Худалдан авах ажиллагааны газар;
29. Нийслэлийн цагдаагийн газар;
30. Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газар;
31. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба;
32. Эрүүл мэндийн газар;
33. Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газар;
34. Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар

Зураг 7. НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БҮТЭЦ



Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас хотын иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээ: Улаанбаатар хот нь Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээнд шинэ менежмент нэвтрүүлэн, мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглаж, төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэн, хариуцлагыг дээшлүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, тэгш, нээлттэй хүргэх тогтолцоог хөгжүүлэх чиглэлд олон арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Төрийн үйлчилгээг хүн бүрд, тэр тусмаа хүн амын орхигдсон хэсэгт ялгаваргүйгээр хүргэх нь чухал асуудал боловч нийслэлээс иргэдэд хүргэж байгаа төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайнгүй байгааг 2017 оны Хэрэглэгчийн үнэлгээ харуулж байна.

Зураг 8. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ, 2017 ОН.




Эх сурвалж: http://unelgee.gov.mn/open/home/19?_perid=7#_per. Нээлmmэй засаг, 2017 он

Улсын хэмжээгээр 2018 онд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 269 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн авлигын гэмт хэргийн 74.3 хувийг эзэлж байна. Улаанбаатар хотод бүртгэгдсэн 170 авлигын хэргийн 126 (74.1 хувь) нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг байна. Авлигын гэмт хэргийн тоо жил ирэх тусам нэмэгдсээр байна.


Гэхдээ Авлигатай тэмцэх газраас тооцон гаргадаг Шударга байдлын үнэлгээний 2019 оны судалгаагаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газар 71.2 оноо авсан нь улсын дунджаас 4 хувиар бага боловч 2018 оны үзүүлэлтээс 3.5 пунктээр өссөн байна.

Зураг 9. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ



Шударга байдлын үнэлгээ нь гадаад, дотоод, бодлогод оролцогчдын гэсэн 3 бүрэлдэхүүнтэй ба Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын шударга байдлын үнэлгээгээр 12 сарын хугацаанд үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын төлөөллийн үнэлгээгээ хамгийн бага байна. Үнэлгээнээс харахад байгууллагуудын ил тод хариуцлагатай байдал дутмаг, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг, бусдад хууль бусаар давуу байдал олгодог зэрэг асуудлууд байна (НЗДТГ, 2020).

Зураг 10. УЛААНБААТАР ХОТЫН АЗ ЖАРГАЛЫН БАЙДЛЫН ИНДЕКС



Тайлбар: 186 хотоос 136 дугаарт орж байна.

Хотын сайн засаглалыг бэхжүүлэх хүрээнд өмнө нь 2015 оноос “Хотын засаглал” төслийг Швейцарын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлж эхэлсэн ба уг төслийн хүрээнд нийслэлийн есөн дүүргийн 33 хорооны 330 мянга гаруй иргэнийг хамруулан иргэдийн санал хүсэлтийг шийдвэрт тусгахад дэмжлэг үзүүлэх, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг сайжруулах, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх зэрэг ажлуудыг явуулж байна.

Нийслэлийн хүн ам: Улаанбаатар хотын хүн ам сүүлийн 10 жилд 24.6 хувь буюу 295 мянгаар нэмэгдэж 1.5 сая, дундаж наслалт 3.38 жилээр нэмэгдэж 71.7 хүрсэн нь улсын дундажтай харьцуулахад өндөр байна. Нийслэлийн хүн амын өсөлтөд механик өсөлт буюу хөдөө орон нутгаас шилжин ирсэн хүн ам ихээхэн нөлөөлсөн. Үүнд 2009 оноос 2018 оны хооронд нийслэлд 253 мянган хүн шилжин ирсэн бол 111 мянган хүн шилжин явсан байна. Монгол улс 2020 оны байдлаар 3.296.866 хүн амтай, үүний 72,9% буюу 2.307.710 хүн хот, суурин газарт амьдарч байна. Үүний 1.539,810 хүн буюу 411 420 өрх Улаанбаатар хотод амьдардаг (1212.mn). Үүнээс гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа Монгол Улсын харьяат иргэн 91.2 мянга байна. Түүнчлэн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа гадаадын харьяат, харьяалалгүй 17.5 мянган иргэд оршин сууж байна. Харин бүртгэлгүй шилжин суурьшигчид, оюутнууд зэрэг түр оршин суугчдыг оролцуулбал тус хотын хүн ам хамгийн багадаа 100 орчим мянгаар нэмэгдэнэ. Улаанбаатар хотын нийт хүн амын 48.1 хувь нь эрэгтэйчүүд, 51.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 11. НИЙСЛЭЛИЙН ХҮН АМ /2020 ОНЫ БАЙДЛААР/




Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2020)

Хүн амын тоо 2020 онд өмнөх 2010 оны тооллогын дүнгээс (1240.0 мянга) 299.8 мянган хүнээр өссөн нь 2000-2010 оны тооллого хоорондын өсөлтөөс 1.6 дахин буурсан байна. Сүүлийн 10 жилийн хүн амын өсөлтийн бууралтыг агаар орчны бохирдол, нийгмийн дэд бүтцийн хүртээмжгүй байдлыг харгалзан нийслэлийн Засаг даргын захирамжаар хүн амын шилжилт хөдөлгөөнийг 2017 оноос хязгаарласантай холбон тайлбарлаж болно.

Улаанбаатар хотын хүн ам нь насны бүтцийн хувьд ерөнхийдөө залуу хэвээр байна. Нийт хүн амд 0-14 насны хүүхдийн эзлэх хувийн жин 2010 оны тооллогоос 8.0 пунктээр нэмэгдэж, эсрэгээр хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь 8.6 пунктээр буурчээ. Голч насыг тооцож үзэхэд ерөнхийдөө залуу хандлагатай ба 1989 онд 20.6, 2000 онд 23.5, 2010 онд 25.6, 2020 онд 28.7 байна.

Зураг 12. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА /2010,2020/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (2020). Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нийслэлийн нэгдсэн дүн/хураангуй/. УБ. хуудас 5.


Хөгшчүүдийн ачаалал 6.8 болсон нь бага мэт харагдаж байгаа боловч тооллогоос тооллогод тасралтгүй нэмэгдэж өмнөх тооллогоос 1.7 пунктээр нэмэгдсэн байгаа нь цаашид хүн амын насжилт нэмэгдэх, улмаар нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжийн бодлогын асуудалд анхаарал хандуулж эхлэх хэрэгтэй болсныг илтгэж байна.

Нийслэлийн хүн амын өрх, гэр бүлийн байдал: Улаанбаатар хотын хэмжээнд 411.4 мянган өрх тоологдсоноос 52.4 хувь нь ам бүлээрээ байгаа өрх, 28.9 хувь нь нийлмэл ам бүлтэй, 14.6 хувь нь ганц бие, 4.1 хувь нь холимог ам бүлтэй өрх байна. Улаанбаатар хотын өрхийн тоо 2010 оныхоос 109.2 мянган (36.1%) өрхөөр өссөний дотор Хан-Уул дүүргийн өрхийн тоо 78.0 хувь, Баянзүрх дүүргийн өрхийн тоо 42.8 хувиар өссөн байна.

Нийслэлийн хүн амын сууршил: Дүүрэг, хороодын нутаг дэвсгэрийн хэмжээ, хот төлөвлөлт, эдийн засгийн хөгжил зэрэг олон хүчин зүйлсийн нөлөөллөөс үүдэн нийслэл хотын суурьшил, нягтрал харилцан адилгүй байдаг. 2020 онд нийслэлийн нийт хүн амын 24.0 хувь нь Баянзүрх дүүрэгт, 22.3 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, нэг үгээр хэлэхэд бараг тал орчим хувь нь энэ хоёр дүүрэгт суурьшиж байна.

Нийслэлийн хөгжлийн бэрхшээлтэй хүн ам: Улсын хэмжээнд 2020 оны хүн ам, орон сууцны тооллогоор хөгжлийн бэрхшээлтэй 106.4 мянган хүн байгаа нь хүн амын 3.3 хувийг эзэлж, 2010 оноос 0.8 пунктээр буурсан байна. Үүнээс 36.7 мянга буюу 34.5 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна.

Зураг 13. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР /2010, 2020/




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (2020). Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нийслэлийн нэгдсэн дүн/хураангуй/УБ. хуудас 11.

Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний 20.2 мянга буюу 55.1 хувь нь эрэгтэй, 16.5 мянга буюу 44.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй хүний 11.4 хувь буюу 4.2 мянган хүн харааны, 3.0 хувь буюу 1.1 мянган хүн ярианы, 8.6 хувь буюу 3.1 мянган хүн сонсголын, 20.9 хувь буюу 7.7 мянган

хүн хөдөлгөөний, 19.9 хувь буюу 7.3 мянган хүн сэтгэцийн, 6.4 хувь буюу 2.4 мянган хүн хавсарсан, 29.8 хувь буюу 10.9 мянган хүн “Бусад” төрлийн хөгжлийн бэрхшээлтэй байна.


Зураг 14. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ҮЙЛДЛИЙН ЧАДВАР
/ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (2020). Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нийслэлийн нэгдсэн дүн/хураангуй/.УБ. хүүдас 13.

Хүний хөгжил: Энэ хэсэгт нийслэлийн хүн ам, боловсрол, эрүүл мэндийн талаар сүүлийн 3 жилийн нөхцөл байдлыг Зураг 12-д харуулав. Улсын нийслэл, төр захиргааны байгууллагууд төвлөн үйл ажиллагаа явуулдаг, төрийн үйлчилгээг иргэдэд төвлөн хүргэдэг онцлогоос хамаарч бусад хотуудын хувьд Улаанбаатарчуудын хүний хөгжлийн индекс нь харьцангуй өндөр байдаг.


Зураг 15. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС. /УЛААНБААТАР ХОТ БОЛОН БҮС НУТГААР/



Нийслэлийн хүн амын боловсрол, бичиг үсэг тайлалтын байдал: Арав, түүнээс дээш насны хүн амын 95.9 хувь нь ямар нэгэн боловсролын түвшин эзэмшсэн байна. Харин 15, түүнээс дээш насны хүн амын 99.5 хувь нь бичиг үсэг тайлагдсан байна.

Зураг 16. 10, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Арав, түүнээс дээш настай хүн ам



Тайлбар: Нийт арав, түүнээс дээш насны амын тоонд Монгол улсад удаан хугацаагаар амьдарч байгаа гадаад улсын иргэдийг хамруулаагүй болно.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (2020). Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нийслэлийн нэгдсэн дүн/хураангуй/. УБ. хуудас 9.

Боловсролын үйлчилгээ: Хотын хүн амын өсөлтийг дагаад хамран сургалт тасралтгүй өсөж, 2018 оны байдлаар 76.6 хувьд хүрсэн нь улсын дунджаас 5.3 хувиар доогуур байна. Сүүлийн 10 жилд цэцэрлэгийн тоо 435-аар, хамран сургалт 11.7 хувиар өссөн боловч 10 хүүхдийн 2 нь гэртээ байна. Цэцэрлэгийн нэг ангид дунджаар төрийн өмчийн цэцэрлэгт 44 хүүхэд, төрийн бус өмчийн цэцэрлэгт 21 хүүхэд сурч байна. Нийслэлд 2018 онд нийт 672 цэцэрлэг 797 хичээлийн байранд үйл ажиллагаа явуулсан байна.

Бага, дунд боловсролын хувьд 2018-2019 оны хичээлийн жилд Монгол Улсын хэмжээнд ерөнхий боловсролын 803 сургууль үйл ажиллагаа явуулснаас 245 (30.5 хувь) нь нийслэлийн нутаг дэвсгэрт байрлаж байна. Сүүлийн 10 жилд ерөнхий боловсролын сургуулийн тоо 18.3 хувиар, суралцагчдын тоо 42.8 хувиар, багшийн тоо 37.3 хувиар нэмэгдсэн нь сайн талтай ч нэг ангид ногдох хүүхдийн тоо буурахгүй бүр зарим хэсгээрээ /хотын төвд нэг ангид 50-60 хүүхэд/ нэмэгдэх хандлагатай байсаар байна. Нийслэлийн хэмжээнд 3 ээлжээр 23 сургуулийн 188 бүлэгт 7743 суралцагч хамрагдаж байгаа бөгөөд нийт сургуульд 08 цагаас 18 цагийн цагийн хооронд тасралтгүй үндсэн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Хүснэгт 8. СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ТОО, ХАМРАГДАЛТ, БАГШ /2020-2021 ОН, ТООГООР/

№	Ангилал	Тоо	Нийт	Бүлэг	Нийт	Хамрагдалт	Нийт	Багш, ажилтан	Үндсэн багш	Нийт үндсэн багш
1	Төрийн өмчийн цэцэрлэг	261	684	2329	3726	81843	111572	9879	2817	4129
2	Төрийн бус өмчийн цэцэрлэг	423		1397		29729		3911	1312	

3	Төрийн өмчийн сургууль	148		7606		277762		16230	11527	
			275		9668		317978			14578
4	Төрийн бус өмчийн сургууль	127		2062		40216		4713	3051	

Нийслэл хотод 2016-2020 оны хооронд нийт 99 цэцэрлэгийн барилга, 43 сургуулийн барилга, 12 бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга баригдаж, цэцэрлэгийн хүчин чадлыг 15805-аар, сургуулийн хүчин чадлыг 25760-аар, бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын хүчин чадлыг 3600-аар тус тус нэмэгдүүлсэн байна.

Улс, нийслэл, дүүрэг, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 2020 онд нийслэлийн нийт 50 сургууль, цэцэрлэгт 4.3 тэрбум төгрөгийн их засварын ажил хийгдэх хөрөнгө батлагдан засварын ажил бүрэн дууссан. “Ковид-19” цар тахлын улмаас сургууль, цэцэрлэгийн их засварт төлөвлөгдсөн 19 сургууль, цэцэрлэгийн их засварын хөрөнгө эргүүлэн татагдсан.

2020 онд нийслэлийн сургууль, цэцэрлэгүүдийн нийт багш нарын 12 хувь нь үндсэн болон давтан сургалтад хамрагдаж мэргэжил, заах арга зүйгээ дээшлүүлсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулгын хүрээнд цахим хичээлийн иж бүрэн сан бүрдүүлж, зайн сургалтын үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Нийслэлийн хэмжээнд сургуулиуд өөрсдийн боломжоо дайчлан цахим хичээлийн сан үүсгэн ажиллаж байна⁶.

Дэлхий дахинд Ковид-19 цар тахал дэгдсэний улмаас нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд 2020 онд 20 долоо хоног цахимаар хичээллэж, 12 долоо хоног танхимаар хичээллэсэн. Тус хугацаанд теле болон цахим хичээлд хамрагдалт ерөнхий боловсролын сургуульд 86.12-89.70%, цэцэрлэгт 76-82.5%-тай байлаа. Суралцагчид хэдийгээр теле хамрагдсан боловч сургалтын хөтөлбөрийн агуулгын 48-54 хувийг эзэмшиж байна. Мөн 2021 онд интернет сүлжээ, компьютер, гар утас гэх мэт хэрэгсэлгүйн улмаас 173 мянган хүүхэд цахим хичээлд оролцож чадаагүй, хичээлийн хоцрогдол үүсээд байна. Багш нар цахим хичээлийг бэлтгэн, агуулгын хоцрогдлыг арилгах чиглэлээр ажиллаж байна.


Нийслэлийн хүн амын интернэт, гар утасны хэрэглээ: Дэлхий нийтээр даяаршиж интернэтийн хэрэглээ маш хурдан өссөөр байгаа ба Монгол Улсад ч бас 3G болон 4G сүлжээ орж ирснээр гар утас болон интернэт хэрэглэгчдийн тоо ихэссэн байна. Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор Улаанбаатар хотын 6, түүнээс дээш насны хүн амын 91.2 хувь буюу 1136.6 мянган иргэн гар утас хэрэглэж байгаа ба 2010 оны тооллогын үеэс 251.8 мянга хүнээр буюу 28.5 хувиар нэмэгджээ. Гар утас хэрэглэгчдийн 46.5 хувийг эрэгтэй, 53.5 хувийг эмэгтэйчүүд эзлэж байна. Харин интернэт сүлжээ хэрэглэгчдийн хувьд 6, түүнээс дээш насны нийт хүн амын 76.0 хувь буюу 946.7 мянган хүн интернэт хэрэглэж байгаа бөгөөд интернэт хэрэглэгчдийн хувь 2010 оноос 26.7 пунктээр өсчээ. Эдгээрийн 47.4 хувь нь эрэгтэй, 52.6 хувь нь эмэгтэйчүүд байв⁷.

6 Нийслэлийн Боловсролын газар (2021). Монгол улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний салбарын танилцуулга. УБ

7 Үндэсний статистикийн хороо (2020). Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нийслэлийн нэгдсэн дүн/хураангуй/. УБ.

Эрүүл мэндийн үйлчилгээ: Хүн амын дунд сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд хүн амын нас баралтын 77.0 хувь нь урьдчилан сэргийлж, эрт үед нь илрүүлж, эмчлэх боломжтой халдварт бус өвчин зонхилж, үүнд, салбарын нийт төсвийн 70 гаруй хувь зарцуулагдаж байна. Улс орны нийгэм эдийн засгийн хөгжилтэй холбоотойгоор эрүүл мэнд, биеийн тамир, спортын тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтэрч, өвчнийг эрт илрүүлэх, оношлох, үйлчилгээ үзүүлэх талаар нэлээдгүй ахиц гарч хүн амын дундаж наслалт нэмэгдэж, эх хүүхдийн эндэгдэл буурч байгаа боловч хүн амын нас баралтын гол шалтгаануудад дорвитой ахиц гарахгүй байна.

**Зураг 17. ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ЭМЧЛҮҮЛСЭН ӨВЧТӨНИЙ ТОО:
БҮС НУТАГ, НИЙСЛЭЛ**



Нийслэлийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар, түүний харьяа 29 байгууллага, 141 Өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн 2,700 гаруй эмнэлэг, сувилал, клиник, эмийн сангаар дамжуулан үзүүлж байна. Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллага болон Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийт 7,000 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байгаа ба эмч, сувилагчийн харьцаа 1:0.9 байгаа нь стандартын шаардлагад хүрэхгүй, юуны өмнө сувилагчийн хүрэлцээг нэмэгдүүлэх нэн шаардлагатай байна. Улаанбаатар хотод нэг эмчид ногдох хүний тоо 200.6, нэг сувилагчид ногдох хүний тоо 213.8 байна⁸.

2016 онд хүртэл дүүргийн эмнэлгүүд зөвхөн дотор, мэдрэл, хүүхдийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлж байсан ба 2017 онд анх удаа “Нийслэлийн эрүүл мэнд” дэд хөтөлбөр батлуулж дүүргийн эмнэлэгт үзүүлж буй тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, нэр төрлийг нэмэгдүүлэх зорилт тавин ажилласан. Нийслэлийн Эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тусламж үйлчилгээний төсөв, хөрөнгө оруулалт жил ирэх бүр нэмэгдэж байна. 2016 онтой харьцуулахад 2020 онд төсөв 70 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба үүнтэй зэрэгцээд улс, нийслэлийн хөрөнгө оруулалт нэмэгдэж олон эмнэлэг шинэ барилгатай болж тоног төхөрөөмжийн хангалт сайжирсан.


⁸ Нийслэлийн Эрүүл мэндийн газар (2021). Монгол улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний салбарын танилцуулга.УБ

Хүснэгт 9. НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

№	Хийгдсэн ажил	Он
1	Нийслэлийн нэгдсэн эмнэлгүүд, ор бүхий эрүүл мэндийн төвүүд хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг хүргэх болсон.	2016 он
2	Хорт хавдрын өдрийн хими эмчилгээний нэгж, гемодиализийн эмчилгээг дүүргийн эмнэлгүүдэд хийж эхэлсэн.	2017 он
3	Хан-уул, Чингэлтэй, Баянгол дүүргүүдэд мэс засал, гэмтлийн тасгийг нээн ажиллуулсан.	2017 он
4	Амгалан амаржих газарт нярайн эмгэгийн тасгийг байгуулсан.	2018 он
5	Баянзүрх, Сүхбаатар дүүргүүдэд мэс засал гэмтлийн тасгийг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд харвалт шигдээсийн нэгж, зарим дүүргийн ЭМТ-дэд нярайн эмгэгийн тасгийг байгуулсан.	2020 он
6	Туул тосгоны Эрүүл мэндийн төв, ХУД-т 50 ортой хүүхдийн эмнэлэг, СХД жишиг нэгдсэн эмнэлэг, Нийслэлийн эх хүүхдийн эмнэлэг ашиглалтад орсон ба зориулалтын 40 авто машин авч парк шинэчлэлт хийсэн.	2020 он

Нийслэлийн хэмжээнд сүүлийн 3 жилийн дундажтай харьцуулахад нийт төрөлт 1,185-р нэмэгдсэн ба эхийн эндэгдэл 2016 онтой харьцуулахад 100,000 амьд төрөлтөд 17.5 промилээр, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1,000 амьд төрөлтөд 3.3, нийт халдварт өвчин 2016 оноос 10,000 хүн амд 120.6 промилээр тус тус буурсан байна. Улаанбаатар хотын хүн амын дундаж наслалт 71.8 үүнээс эрэгтэйчүүдийн дундаж наслалт 67.06, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.11 байна.

Зураг 18. НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН БАЙДАЛ /10 МЯНГАН ХҮН АМД, 2020 ОНЫ БАЙДЛААР/



Эх сурвалж: Нийслэлийн эрүүл мэндийн газар (2020). УБ


Эрүүл мэндийн чиглэлээр жил бүр олон талт арга хэмжээ авч төлөвлөн хэрэгжүүлсний дүнд эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт болох төрөлт нэмэгдэн, өвчлөл, эндэгдэл буурч байгаа эерэг үр дүнтэй ажиллаж байна. Гэхдээ биеийн тамир, спортын тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт техник технологийг ашиглах, өвчнийг эрт илрүүлэх, оношлох, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх зэргийг цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Ковид 19 цар тахлын тархалтын тухай: Дэлхийн хэмжээнд нийт 88 бүс нутаг, улс оронд 160.6 тун вакциныг хийгээд байгаагаас Израйль улс хамгийн өндөр буюу нийт хүн амын 68.1 хувийг вакцинжуулаад байна. Харин Англи улс хүн амынхаа 21.8 хувь, АНУ 14.0 хувь, БНХАУ 2.9 хувь, ОХУ 2.9 хувийг тус тус вакцинд хамруулаад байна (Financial times). Вакцинжуулалт эхэлснээр коронавируст халдварын тархалт өндөр байсан улс орнуудад халдварын тохиолдол буурч эхэлж байна. Монгол Улсын хувьд эсрэгээрээ, халдварын тархалт эрчимтэй нэмэгдэж байна.

Коронавируст халдварын тохиолдол Монгол Улсад 2020 оны I сарын байдлаар нийт 1779 болов. 2020 оны II сарын 13-ны өдрийн байдлаар 2293 болсон нь 1 дүгээр сартай харьцуулахад 13 хоногийн дотор 514 тохиолдол буюу 28.9 хувиар өссөн.

Нийслэлд коронавирусын КОВИД-19 халдварын анхны тохиолдол бүртгэгдсэн 11 сарын 11-ний өдрөөс хойш 2021 оны 6 сарын 19-ны байдлаар нийслэлд 75.721 тохиолдол бүртгэгдсэн байна.

Зураг 19. КОВИД 19 ЦАР ТАХЛЫН ТАРХАЛТ



Эх сурвалж: Корона вирус ба эдийн засаг. <https://www.1212.mn>

Нийслэлд коронавирусын КОВИД-19 халдварын анхны тохиолдол бүртгэгдсэн цагаас коронавирусийн халдвараас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, үйл ажиллагааны Нийслэлийн нэгдсэн төлөвлөгөөг батлуулан холбогдох бүх байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажилласан.

Коронавируст /КОВИД-19/ халдвар тархсан эхний 2 долоо хоногт 9 дүүрэгт шинжилгээ авах байнгын болон түр 120 цэгийг байгуулан халдварыг тандах илрүүлэх, халдвар голомтлон гарсан дүүргүүдэд байнгын цэг, түр цэг, явуулын тандалтын багуудыг байгуулан голомтын өргөтгөсөн тандалтыг Баянгол, Баянзүрх дүүргүүдэд хийснээс гадна Засгийн газрын шийдвэрийн дагуу “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээ, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын тандалт, шуурхай хариу арга хэмжээний 34 баг 150 хүний бүрэлдэхүүнтэй өдөр тутам үйл ажиллагаа явуулж байгаагаас 6 нь ХӨСҮТ, 6 нь НЭМГ-т, 22-нь дүүргүүдэд тандалт хийн ажиллаж байна.

Эрүүл мэндийн яамнаас Ковидын халдварыг илрүүлэх шинжилгээний бүртгэлийг эрүүл МН поснын төхөөрөмжөөр www.eruul.gerege.mn аппликешнийг ашиглан шинжилгээний бүртгэл хийх, сорьцыг кодлон ажиллах, иргэд шинжилгээний хариуг www.eruul.gerege.mn аппликешнээс авах, коронавирусыг илрүүлэх ПГУ-ын

шинжилгээ өгөх өдөр, цагаа 2020 оны 01 сарын 14-ний өдрөөс www.eriul.gerege.mn сайтаар орж захиалах боломжтой болсон.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн хуралдааны 69 дүгээр тэмдэглэл, Эрүүл мэндийн сайдын А/01 дүгээр тушаалын дагуу төвийн 6 дүүрэгт Молекул биологийн лаборатори байгуулан ажилласан.

2020 оны 2 сараас 7 сар хүртэл, мөн 9 сараас өнөөдрийг хүртэл Нийслэлийн авто тээврийн шалган нэвтрүүлэх 9 товчоодод эрүүл мэндийн хяналтыг хийж ирлээ. Товчоодод өдөр бүр эрүүл мэнд, онцгой, цагдаа, мал эмнэлэг, мэргэжлийн хяналтын 80-100 ажилтан албан хаагч 24 цагаар товчоогоор орж, гарсан автомашин болон иргэдийн зорчих хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна⁹. Мөн тусгаарлах байрнаас гарч хяналтад орсон, дам хавьтлын улмаас гэрийн ажиглалтад орсон иргэдийн эрүүл мэндийн байдалд дүүрэг, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хяналт тавин ажиллаж байна. 2021 оны 06 дугаар сарын 07-ны байдлаар нийслэлийн хэмжээнд “Ковид-19” халдварын эсрэг вакцины 1-р тунд 892, мөн 2-р тунд 8895 буюу нийт 9787 иргэнийг дархлаажуулалтад хамрууллаа. Вакцинжуулалт эхэлснээс хойш нийслэлийн 18-аас дээш насны иргэдийн 100.4 хувь буюу 957.615 нь 1-р тунд, 85.2 хувь буюу 812.503 нь 2-р тунд хамрагдаад байна.

Хүнсний аюулгүй байдал: Хүн амын хүнсний нийт хэрэглээний 50 хувийг импортоор оруулж ирдэг улс орныг хүнсний аюулгүй байдлын хувьд эрсдэлтэй гэж үздэг. Манай улсын хувьд хүнсний бүтээгдэхүүний 40-50 хувь, жимс жимсгэний 90 орчим хувийг импортоор, тэр дундаа өмнөд хөрш БНХАУ-аас оруулж ирж байна. Манай улсын хувьд хүнсний хангамж муугүй үзүүлэлттэй мэт боловч экспорт, импортын зохистой харьцаа алдагдаж, импортоос хараат орны тоонд багтдаг болсон. Монгол хүний хүнсний хэрэглээнд мах, гурилан бүтээгдэхүүн зонхилж, эрдэс амин дэмийн гол эх үүсвэр болдог жимс, жимсгэнэ, нарийн ногоо бага хэвээр байна (Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, 2017). Судалгаагаар, хүн амын дунд зонхилон тохиолдож буй хоол тэжээлээс хамааралтай эмгэгийн тэргүүлэх шалтгаан нь “Өрхийн хүнсний баталгаат байдал алдагдсан явдал” болохыг тогтоожээ. Мөн монгол өрх, гэр бүлийн 23 хувьд хүнсний баталгаат байдал ноцтой алдагдсан, 28 хувьд “дунд зэрэг” гэсэн үнэлэлттэй байна. Өөрөөр хэлбэл, хүн амын талаас илүү хувь нь чанар, шим тэжээлтэй, эрүүл аюулгүй хүнсээр хангагдах боломжоо алдсан. Үүнээс улбаалан хүн амын дундах аминдэм, эрдэс бодисын дутагдал харьцангуй их, хорт хавдрын өвчлөл илт нэмэгдсэн зэрэг нь Монгол Улс хүн ардынхаа хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоогоо шинэчлэх цаг болсныг харуулж байна (Үндэсний статистикийн хороо, 2018). Тиймээс хүн амын дундах илүүдэл жин, таргалалт, нийгмийн эрүүл мэндэд ноцтой үр дагавар учруулах түвшинд хүрсэн тул эрүүл хооллолт, зохистой хэрэглээний талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, амин дэм, эрдсээр баялаг, хоол хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэр төрлөөр нь 2019 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг 2018 онтой харьцуулахад гурил үйлдвэрлэлт 15.0 хувиар, малын мах 27.7 хувиар, хиам, консерв үйлдвэрлэлт 0.7 хувиар, архи 0.9 хувиар тус тус буурсан бол гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 11.0 хувиар, боловсруулсан шингэн сүүний үйлдвэрлэлт 4.0 хувиар, шар айраг 1.0 хувиар, ус, ундаа 1.1 хувиар тус тус өссөн байна.

9 Нийслэлийн Эрүүл мэндийн газар (2021.02). Монгол улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний салбарын танилцуулга. УБ

Нийслэлийн хүнсний үйлдвэрүүд 2020 оны 9 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1009.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1484.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 3.9 хувиар, борлуулалт 16.4 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 10. ХҮНСНИЙ ХАНГАМЖ /ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙГ ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР /

№	Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Үйлдвэрлэлт 2019 мян.тн	Улаанбаатар хотын жишсэн хүн амын жилийн хэрэгцээ, мян.тн	Хангамж хувь
1	Малын мах	22.7	51.6	44.0
2	Загас	0	12.9	0.0
3	Шувууны мах	0	17.2	0.0
4	Сүү /үнээний сүү, 3.2% тослогтой/	38.6	68.8	56.1
5	Цагаан идээ /тараг/	29.3	77.4	37.9
6	Гурил	172.3	43	400.7
7	Гурилан бүтээгдэхүүн	46.3	77.4	59.8
8	Төрөл бүрийн будаа	0.2	21.5	0.9
9	Төмс	1.5	51.6	2.9
10	Хүнсний ногоо	4.5	111.9	4.0
11	Буурцагт ургамал	0	17.2	0.0
12	Жимс, жимсгэнэ	0.1	86.0	0.1
13	Өндөг	0	8.6	0.0
14	Ургамлын тос	0	9.9	0.0
15	Цөцгийн тос, 72% тослогтой	0.2	4.3	4.7
16	Сахар, Чихрийн зүйл	0.4	14.2	2.8

Тайлбар: Хүнсний хангамжид загас, шувууны мах, төрөл бүрийн будаа, буурцагт ургамал, ургамлын тос, элсэн чихэр, жимс, жимсгэнэ зэрэг нь бараг 100 хувийн импортын хамааралтай байна.

Нийслэлийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал: 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар нийслэл Улаанбаатар хотод ажиллах хүч 548,277, ажиллагчид 513.653, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч 1,639, ажилгүй хүн 34,624, ажиллах хүчнээс гадуурх хүн ам 501,523, байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2020 оны 12 дугаар сарын байдлаар 21,953 байна (Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, 2021).

Хүснэгт 11. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ /НИЙСЛЭЛ/

Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо	Хэмжих нэгж мян.хүн	2015 он 946.1	2016 он 974.2	2017 он 993.1	2018 он 991.5	2019 он 989.4
Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо	мян.хүн	494.1	511.5	553.6	555.4	529.5
Ажиллагчдын тоо	мян.хүн	460.0	465.1	512.2	513.1	471.0
Ажилгүй иргэдийн тоо	мян.хүн	34.1	46.4	41.4	42.3	58.5
Бүртгэлтэй, ажилгүй иргэдийн тоо	мян.хүн	12.6	12.0	7.0	8.3	6.7
Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо	мян.хүн	423.7	469.9	498.7	484.3	436.1
Ажиллах хүчний оролцооны түвшин	хувь	53.8	52.1	52.6	53.4	54.8
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	хувь	50.1	47.4	48.7	49.4	48.8
Ажилгүйдлийн түвшин	хувь	6.9	9.1	7.5	7.6	11.0

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар нийслэлийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 48.9 хувь, ажилгүйдлийн түвшин 6.3 хувь, ажиллах хүчний оролцооны түвшин 52.2 хувь байгаа нь 2015 онтой харьцуулбал хөдөлмөр эрхлэлтийн түвшин 1.2 пунктээр, ажилгүйдлийн түвшин 0.6 пунктээр, ажиллах хүчний оролцооны түвшин 1.6 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар болон 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүд нийслэлийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг иргэдэд хүргэхээс гадна, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр” зэрэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласан. Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, Цагийн ажлын бирж зэрэг иргэдэд үйлчлэх төвүүдээр хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг иргэдэд нэг дороос үзүүлж байна.

Хүснэгт 12. УЛААНБААТАР ХОТЫН ХЭМЖЭЭНД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН БАЙДАЛ¹⁰

№	Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020
	Бүртгэгдсэн шинэ ажлын байр	17728	15185	16469	6838	5371	6632
	Ажлын байрны захиалга	28482	30143	30679	24169	18806	21255
	Бүртгүүлсэн иргэн	26107	29513	36529	25090	14999	21953
	Ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэн	31452	23110	25209	20120	15266	14310
	Үүнээс ажилд орсон иргэн	15006	15606	15199	15570	13987	9032
	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл авсан иргэн	15982	25192	43654	27036	41944	17487
	Нийтийг хамарсан ажилд хамрагдсан иргэн	11538	13683	8885	6394	4931	1345

Ажил эрхэлдэг хүн амын тоо 502.0 мянга болж 2010 оноос 110.5 мянган хүнээр буюу 28.2 хувиар өссөн нь эерэг үр дүн байлаа.

Зураг 20. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ /2010, 2020/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (2020). Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нийслэлийн нэгдсэн дүн/хураангуй/. УБ. хуудас 15.

¹⁰ Нийслэлийн Эрүүл мэндийн газар (2021.02). Монгол улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний салбарын танилцуулга.УБ

Арван тав, түүнээс дээш насны хүн амын 50.7 хувь нь ажил эрхэлж байгаа нь улсын дунджаас 3.1 пунктээр доогуур байна. Энэ нь нэгдүгээрт, нийслэлд их, дээд сургууль олноор төвлөрч, суралцагчдын тоо байнга нэмэгдэж байгаа, хоёрдугаарт, хүн ам хэт төвлөрснөөс үүдэн ажлын байрны олдоц ховор байгаа, гуравдугаарт, хэдийгээр сүүлийн гурван жилд Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгалыг тодорхой хэмжээгээр хязгаарласан боловч өмнөх он жилүүдэд шилжин ирэгсдийн тоо өндөр байсан зэрэгтэй холбоотой. Мөн Улаанбаатар хотын хүн ам улсын хүн амын 45.9 хувийг эзэлж, хувийн жин нь жилээс жилд нэмэгдэж байгаа боловч ажил эрхэлдэг хүний хувийн жин хүн амын өсөлтөө даган төдийлөн хурдацтай нэмэгдэж чадахгүй байна.

Улаанбаатар хотын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2020 онд 14.5 болж, өмнөх тооллогын үеийнхээс 1.1 пунктээр өсч, улсын дүнгээс 4.6 пунктээр дээгүүр байна. (Улсын дүн 9.9 хувь байна). Мөн дээд боловсролтой болон мэргэжилтэй ажилгүй иргэдийн тоо нэмэгдсээр байгаа нь хөдөлмөрийн зах зээлд боловсролын түвшин, мэргэжлийн байдлаар эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт харьцааг ихээхэн анхаарах шаардлагатай болсныг харуулж байна.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээс харахад 2020 оны 2-р улиралд өмнөх улирлаас ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдэж, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал сайжирсан бол 2020 оны 3-р улиралд өмнөх улирлаас буурсан байна. Ажиллах хүч 2020 оны 3-р улирлын байдлаар 1 286.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 13.9 мянга буюу 1.1 хувиар буурсан байна.


Ажиллах хүч буурсан нь Ковид-19 цар тахлаас үүдэлтэй гэж таамаглаж болохоор байна. Тухайлбал ажилгүйчүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 34.0 мянга буюу 26.8 хувиар буурч, боломжит ажиллах хүч 11.2 мянга буюу 21.8 хувиар өссөн байна. Эндээс харахад Ковид -19 цар тахлын үеийн хөл хорионы нөлөөгөөр ажилгүй хүмүүсийн ажил хайх, ажил хийх оролдлого нь хязгаарлагдсан нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны хүн ам цар тахлаас болгоомжлон ажил хийх, хайхаас илүү гэртээ байх шийдвэр гаргаснаас үүдэж боломжит ажиллах хүчийг нэмэгдүүлсэн байна.

Хөдөлмөр эрхэлж байгаа хэдийн ажлаа солих хүсэлтэй ажил хайгч 4 хүн тутмын гурав нь орлого нь хүрэлцэхгүй байгаа гэсэн шалтгаанаар ажил хайж байна. Мөн бүртгэлтэй ажилгүй иргэдийг ажил хайж байгаа шалтгаанаар нь авч үзвэл бүртгэлтэй ажилгүй хоёр иргэн тутмын нэг нь ажлаас чөлөөлөгдсөн/ халагдсан хүмүүс байна. Ажлаас чөлөөлөгдсөн/ халагдсан хүмүүсийн 17.8 хувь нь орон тооны цомхотголд орсон байна. Улсын онцгой комиссын зүгээс Ковид-19 цар тахлын тархалтын байдлаас шалтгаалж хатуу хөл хорио болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон ажлын байрны захиалга, ажил зуучлагдсан иргэдийн тоо буурахад нөлөөлсөн байх магадлалтай юм.

Ковид-19 цар тахлын хатуу хөл хорионы үеийн албан бус хөдөлмөр эрхлэгчдийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгааг судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эс Ай Си Эй” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд цаг үеийн нөхцөл байдалд уялдуулан 2020 оны 11 сарын 12ны өдрөөс 2021 оны 1 сарын 11-ны өдрийн хооронд 385 албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хүрээнд хийжээ. Зөвхөн энэ судалгааны хүрээнд гэхэд 10 иргэн тутмын 4 нь гэр бүлийнхээ гишүүнтэй хамтран хөдөлмөр эрхэлдэг, мөн адил 10 иргэн тутмын 4 нь өөрөөсөө гадна ажилтан цалинжуулдаг, ажилчидтай гэж хариулсан 43.4 хувийн цаана нийт 659 ажилтан, 1 албан бус хөдөлмөр эрхлэгчийн

цаана 4 ажилтан тус бүр байна гэжээ (Судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эс Ай Си Эй” ХХК, 2021.01).

Зураг 21. **НЭГ АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД НОГДОХ ӨРХИЙН ГИШҮҮДИЙН СТАТИСТИК ТОО**



Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн орлого хатуу хөл хорионы үед 97 хувь буурсан байна.

Зураг 22. **АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ /САЛБАРААР/**

Салбараар:



Эх сурвалж: Судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эс Ай Си Эй” ХХК (2021.01). COVID-19 цар тахлын хатуу хөл хорионы үеийн албан бус хөдөлмөр эрхлэгчдийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа.УБ

Судалгаанд хамрагдсан 4 албан бус хөдөлмөр эрхлэгч тутмын 3 нь үйл ажиллагаагаа эрхлэхтэй холбоотойгоор түрээсийн төлбөр төлдөг байна.


Хүснэгт 13. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН ОРЛОГЫН ТҮВШИН

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн өдрийн дундаж орлого, төгрөгөөр

Үзүүлэлт	Нийт түүврийн хувьд	Хүнснээс бусад жижиглэнгийн худалдаа	Авто засвар, үйлчилгээ	Нийтийн хоол	Үсчин, гоо сайхан	Бусад
	n=385	n=76	n=75	n=77	n=81	n=76
Сард ажилладаг хоног / өдрөөр/	27	27	28	26	27	27
Хатуу хөл хорионоос өмнөх үеийн өдрийн орлого	320 700	468 300	240 500	603 800	80 600	210 300
Хатуу хөл хорионы үеийн өдрийн орлого	9700	35 700	5700	1700	4300	1300

Түрээсийн төлбөр төлдөг нийт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 40 орчим хувь нь хөл хорионы үед түрээсийн төлбөрөө түрээслэгчтэйгээ ярилцаад хойшлуулсан, 30 орчим хувь нь огт төлөөгүй, хугацаа хэтрэлттэй байгаа бол үлдсэн хэсэг нь цаг тухайд нь төлж байгаа мөн тодорхой хувийн хөнгөлөлт эдлэн төлж байгаа гэсэн хариултуудыг өгчээ.

Зураг 23 . АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН АЖЛЫН БАЙРНЫ ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ



Цаашид зээлийн хүүг бууруулах, зээл төлөлтийг хөнгөрүүлэх, түрээсийн төлбөрт хөнгөлөлт, зохицуулалт хийх зэрэг туслалцаа дэмжлэгийг төр засгаас илүүтэй хүссэн байна.

Зураг 24. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

n = 385



Хотжилт: Нийслэл нь Монгол улсын газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг хэдий ч нийт хүн амын 46 хувь, их дээд сургууль, коллежийн 96 хувь, иргэдийн хадгаламжийн 82 хувь, автомашины 68 хувь, бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 75 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 66 хувийг эзэлдэг гэх мэт үзүүлэлтээр улсын хэмжээнд тэргүүлж байна.


Улаанбаатар хотын төвийн хэсэгт (Их тойруу) төр, захиргааны байгууллага, их дээд сургууль худалдаа үйлчилгээ, оффисын болон орон сууцны барилгажилт төвлөрч нэг төвт хотын тогтолцоо бүрдсэн байна. “Их тойруу” хотын төв рүү хоногт дунджаар 200 мянга орчим авто машины хөдөлгөөн бүртгэгдсэн судалгаа хийгдсэн. Хотын төв хэсэгт инженерийн шугам сүлжээний хангамж хүрэлцээтэй, бизнесийн орчин сайн байх тул бизнес эрхлэгчдийн сонирхол хотын төвд барилга барих, хөрөнгө оруулалтын өгөөжийг өндөр байлгах сонирхлоор бага талбайд их барилгажилт явагдаж байна.

Улаанбаатар хотын газар нутгийн Хот, тосгон бусад суурингийн газрын 50.6 хувийг барилга байгууламжийн дэвсгэр газар, 28.7 хувийг гэр хорооллын газар эзэлж байна. Өмнөх оноос хот, тосгон бусад суурингийн газрын хэмжээ 0.8 хувиар нэмэгдсэн. Нийслэлийн гэр хорооллын нийт газар нутгийн хамгийн их буюу 43.8 хувийг Сонгинохайрхан дүүрэг, 13.7 хувийг Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр эзэлж байна. Сүүлийн жилүүдэд орон сууцны барилга нэмэгдэж байгаатай холбоотойгоор гэр хорооллын өрхийн эзлэх хувь бага зэрэг буурах хандлагатай байна.

Орон сууц: 2020 оны байдлаар Монгол Улсын нийт өрхийн 45.8 хувь нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч байгаа нь 2010 онтой харьцуулахад 2.2 пунктээр илүү байна. Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр нийслэл Улаанбаатар хотод 411.4 мянган өрх амьдарч байгаагийн 22.2 хувь нь монгол ард түмний уламжлалт сууц гэрт, 77.3 хувь нь байшинд, 0.5 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна.

Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеийнхээс 6.8 пунктээр буурсан бол байшинд амьдардаг өрхийнх 7.7 пунктээр нэмэгджээ. Байшин, орон сууцны тооллогоор хүн байнга амьдардаг 141.7 мянган сууц, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулбал 387.8 мянган сууц тоологдсон.

Зураг 25. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР /2020/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (2020).
Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нийслэлийн нэгдсэн дүн
/хураангуй/. УБ. хуудас 18.

Улаанбаатар хотын гэр хорооллыг төвийн, дундын, захын гэр хороолол гэж ангилан үзвэл, дунд болон захын гэр хороолол маш том талбайг эзэлж байна. Эдгээр нь дулааны болон ариутгах татуурга зэрэг инженерийн шугам сүлжээ, хог хаягдал зайлуулах систем байхгүй хэсэгт байрлаж байна. Гэр хорооллын ихэнх өрх төвийн бүсийн нэгдсэн сүлжээнээс эрчим хүчээ авч байгаа ч бусад нийтийн аж ахуй, үндсэн дэд бүтэц хангалтгүй байна. Ялангуяа, ариутгах татуургын сүлжээнд холбогдсон өрх маш бага байна.

Гэр хороолол: “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн 2.1.5 Дэд бүтцийн салбарын зорилт 6-д “Хот суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ гэж заасны дагуу Улаанбаатар хотын төвийн бүсийн гэр хороололд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл, дундын бүсийн гэр хороололд хэсэгчилсэн инженерийн дэд бүтцээр хангах “Дэд бүтцийн төв” төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлаар батлагдсан “Улаанбаатар хотыг хөгжүүлэх 2020 оны ерөнхий төлөвлөгөө, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-т нийцүүлэн нийслэл хотын гэр хорооллыг 3 бүсчилж хувааж хөгжүүлэхээр тусган, тус бүрд нь хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх түвшинг тодорхойлон “Нийслэлийн Орон сууц, дэд бүтцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 14/01 тогтоолоор баталсан.

Төвийн бүсийн гэр хороололд нийт 27 байршил, 84 хэсэгчилсэн талбай, 20 мянга 539 нэгж талбар бүхий 1,694 га газарт гэр хорооллыг газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлж байна. Энэ нь гэр хорооллын нутаг дэвсгэрийн 17.3 хувийг эзэлж байна. Төслийн хүрээнд нийт 6,468 айлын яндан, нүхэн жорлонг буулгаж, 9,229 айлын орон сууц ашиглалтад оруулсан.

Дундын бүсийн гэр хороолол нь нийт гэр хорооллын 28.8 хувь буюу 2,794 га талбайг хамардаг бөгөөд төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох боломжгүй дундын бүсэд инженерийн хангамжийг нэвтрүүлэх “Дэд бүтцийн төв” төслийг Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банк болон нийслэлийн төсвийн хөрөнгөөр хамтран санхүүжүүлэх ба нийт 3 үе шаттайгаар 6 дэд төвийн суурь дэд бүтцийн ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 118 дугаар тогтоолоор эхний ээлжийн 16 байршлыг баталсан. Үүнээс Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо, Налайх дүүргийн 1 дүгээр хороо, Сүхбаатар дүүргийн 18 дугаар хороонд хэсэгчилсэн инженерийн хангамж бүхий “Дэд бүтцийн төв” төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Мөн гэр хорооллын гурав дахь бүс буюу төвлөрсөн болон хэсэгчилсэн шугамд холбогдох боломжгүй захын бүсэд сэргээгдэх эрчим хүч, шингэрүүлсэн түлш зэргийг ашиглах бие даасан технологийг ашиглахаар шийдвэрлэн, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/931 дүгээр захирамжаар Гэр хорооллын захын бүсэд хэрэгжүүлэх бие даасан инженерийн хангамжийн төслүүдийн ТЭЗҮ боловсруулах ажлын санхүүжилтийг шийдвэрлэсэн. 2021 онд ТЭЗҮ-г боловсруулж, 2022 онд эхний 100 өрхийг бие даасан инженерийн хангамжаар хангах ажлыг хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

Ногоон байгууламж: Орчин үеийн томоохон хотуудын хөгжлийн гол үзүүлэлтийн нэг нь ногоон байгууламж юм. Улаанбаатар хотын нягтшил төв хэсэгтээ нилээд бага, хотын захын гэр хороололдоо туйлын бага (олон улсын жишигтэй харьцуулахад) байхад ногоон орчинд зориулсан нийтийн талбай аль алинд нь хомс байна. Улаанбаатарын хувьд ногоон байгууламж шаардлагатай хэмжээнээс хэд дахин бага ч жил бүр ногоон байгууламжийг нэмэгдүүлэх тал дээр дорвитой арга хэмжээ авч ажиллаж байгаагийн үр дүнд нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ 2016-2017 онд 2.4-3.2 м², 2019 онд 4.6 м², 2020 онд 4.8 м² болж нэмэгдсэн. Харин олон улсын жишигт доод тал нь 10м² байвал хангалттай гэж үздэг байна. Цаашид хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх, доройтсон ойг сэргээх, ойжуулах, моджуулах, эвдрэлд орж бохирдсон хөрсийг сэргээх, ургамалжуулах зэрэг ажлыг нэмэгдүүлэх шаардлагатай. Мөн “Байгалийн гамшгаас үүдсэн эдийн засгийн хохирлын тооцооны ДНБ-д эзлэх хувь” гэдэг үзүүлэлт 2% (2017) орчим байгаа нь олон улсын жишгээр тодорхойлсон хангалттай түвшин 0.5%-с 4 дахин их байна. Эдгээр нь гэнэтийн үерийн эрсдэлийг нэмэгдүүлж, Улаанбаатар хотын гэр хороололд орон сууцны хорооллоос илүү нөлөөлж болзошгүй байна. Хотод олон зориулалтын ногоон байгууламж бий болгох нь хотыг, ялангуяа үерийн эрсдэл хамгийн их байдаг газруудыг уур амьсгалын нөлөөнөөс хамгаалахад чухал ач холбогдолтой нь тодорхой.

Нийслэл хотын газар нутгийн 227.263 мянган га нь ойн сан бүхий газарт хамаарагддаг бөгөөд үүнээс Богд уулын дархан цаазат газар 22.129 га, Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газар 70.546 га, тусгай хамгаалалтад ороогүй ойн сан 134.588 га талбайг тус тус эзэлдэг. Ойн сангийн талбай 115.998 га, үүнээс ойгоор бүрхэгдсэн талбай 93.613 га, ойгоор бүрхэгдээгүй талбай 18.519 га, ойн бус талбай 3.866 га байна. Ногоон бүсийн нутаг дэвсгэрт түймэрт өртөж шатсан талбай 1,585 га, 0.2 ба түүнээс доош өтгөрөлттэй тармаг модод 5.386 га, мод бэлтгэсэн талбай 3.901 га бүртгэгдсэн байна. Улаанбаатар хотын ногоон бүсийн ойн сангийн байгалийн ойн нийт нөөц 10.884.300 шоо.метр ба түүний 42.1 хувийг болц гүйцсэн хөгшин ой, 25.7 хувийг болц гүйцэж яваа ой, 31.3 хувийг дунд насны ой, 0.6 хувийг залуу насны ой эзэлж байна (НБОГ, 2019). БОАЖЯ-ны дэргэдэх Ойн нөөцийн зөвлөлөөр батлагдсан “Нийслэлийн ногоон бүсийн ой зохион байгуулалтын тайлан”-д ойжуулах, нөхөн

сэргээх шаардлагатай 17098 га талбай байгааг тогтоосон. Нийслэлийн хэмжээнд 2016-2020 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 759 га талбайд ойг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулснаас ойжуулалтын ажлыг 537 га, ойн зурвасыг 45 га талбайд, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг 57 га талбайд тус тус хийж гүйцэтгээд байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт 2412 га талбай уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэгдсэн ба үүнээс 2374 га нь тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаагаар эвдэгдсэн байна. /1179 га нь Багануурын уурхай/

Бичил уурхайн улмаас эвдэгдсэн /Налайх/ 667 га талбайгаас 338 га эзэнгүй орхигдсон талбайг “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хүрээнд нөхөн сэргээхээр зорилт тавин ажиллаж байгаа боловч коронавируст цар тахлын улмаас аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж нөхөн сэргээлтийн ажил орхигдох эрсдэлтэй байна. Мөн бичил уурхайн улмаас ухагдаж эвдэгдэн, эзэнгүй орхигдож, нөхөн сэргээгдэлгүй үлдсэн нийт 192,3 га талбай байгаа бөгөөд тухайн талбайг нөхөн сэргээхэд улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх шаардлага тулгарч байна.

Нийслэлийн агаарын чанар: Сүүлийн 8 жилийн дунджаар, PM2.5 тоосонцрын хэмжээ Монгол Улсын хүлээн зөвшөөрөх стандарт хэмжээнээс 12 дахин их, ДЭМБ-ын зөвлөмжөөс 25 дахин их байна (Үндэсний статистикийн хороо, 2019).

2019 оны байдлаар Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах шаардлагатай бүсэд төр болон хувийн хөрөнгө оруулалттай 100кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуух 290 байгууламжийн 507 зуух байна.

Нийслэлийн агаарын чанарын хяналт, хэмжилтийг 1970-аад оны сүүлээр анхлан химийн буюу гар аргаар хэмжиж эхэлсэн байдаг ба улмаар 2009 оноос агаарын чанарыг автомат анализатороор хэмждэг болсон. Одоогийн байдлаар агаарын чанарыг нийт 11 байршилд автомат анализатораар тодорхойлдог ба 2015 оноос эхлэн иргэд, олон нийтэд цахим сүлжээгээр болон гар утасны апплекейшнээр нээлттэй мэдээлдэг болсон.

Хүснэгт 14. УЛААНБААТАР ХОТЫН АГААРЫН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

№	Бохирдуулах бодисын агууламж	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламж мкг/м3	Дундаж агууламж мкг/м3			
			2018 оны 12 сарын байдлаар	2019 оны 12 сарын байдлаар	2020 оны 2 сарын байдлаар	2021 оны 2 сарын байдлаар
1	PM10 тоосонцор	100	242	138	97	98
2	PM2.5 тоосонцор	50	182	113	68	63
3	Хүхэрлэг хий	50	54	106	77	139
4	Азотын давхар исэл	50	51	65	58	41

Эх сурвалж: Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал.

Цаг уур, орчны шинжилгээний газар

Монгол Улсын Засгийн газрын 98 дугаар тогтоолоор “Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр” батлагдсан бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2018 онд “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол батлагдаж Баянзүрх дүүргийн 20, Сонгинохайрхан дүүргийн 21, Хан-Уул дүүргийн 12, 13, 14 дүгээр хороодоос бусад хороодын цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээс бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын түүхий нүүрсний хэрэглээг 2019 оны 05 сарын 15-ны өдрөөс хориглосон. Тус тогтоолд Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор өөрчлөлт орж дээрх 5 хороод түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон бүсэд нэмж орсон.

Засгийн газрын 2018 оны 62-р тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрчим хүчний яам сайжруулсан хатуу түлшний үйлдвэрлэлийг хариуцан ажиллаж байгаа бөгөөд жилд 600 мянган тонн сайжруулсан түлш үйлдвэрлэх хүчин чадалтай “Таван толгой түлш” ХХК-ийг байгуулж, 2018 оны 11 дүгээр сарын 23-нд үйлдвэрийг ашиглалтад оруулсан. Мөн Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн ээлжит хуралдаанаар нийслэлийн зүүн бүсэд сайжруулсан шахмал түлшний хоёр дахь үйлдвэрийг Налайх дүүрэгт барьж байгуулах шийдвэр гарч, жилд 600,000 тн түлш үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг ашиглалтад оруулан ажиллаж байна. Түүхий нүүрсний хэрэглээг халж, “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшийг гэр хорооллын 200,000 айл өрхийн хэрэглээнд нэвтрүүлснээр агаарын бохирдлыг 50 хүртэлх хувиар бууруулсан. 2021 онд сайжруулсан түлшний тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сайжруулсан түлшний тээвэрлэлт хийх 35 аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан 522 автомашинаар өдөрт 686 борлуулалтын цэг, 27 хангамжийн бааз, 28 агуулахын түлшний тээврийг 24 цагаар тогтмол түгээлтийн ажлыг зохион байгуулан 2021 оны 01, 02 сард нийт 175,994 тн түлш тээвэрлэж борлуулаад байна.

Нийслэлийн агаарын бохирдлын 56 хувийг гэр хороолол болон халаалтын зуух, 20 хувийг автомашин, 10 хувийг цахилгаан станц, 14 хувь нь бусад эх үүсвэрээс үүдэлтэй байдаг ба гэр хорооллын 160.0 мянган айл өрхийг сайжруулсан түлшээр хангаж, сайжруулсан түлш нөөцлөх, түгээх, борлуулалтын цэгүүдийг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлсэн.

Хэдийгээр Улаанбаатар хотод түүхий нүүрсний хэрэглээг хориглож, сайжруулсан түлш хэрэглэж, гэр хорооллын өрхийн шөнийн цахилгаан эрчим хүчний хөнгөлөлт, цахилгаан болон бусад эх үүсвэрээр халаах, уурын зуухыг төвлөрсөн дулаанд холбож эхэлсэнтэй холбоотойгоор агаарын бохирдол 50 орчим хувиар буурч байгаа боловч агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас их хэвээр байгааг цаашид анхаарах шаардлагатай байна¹.

Ус хангамж: Найдвартай ундны ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн үйлчилгээгээр хангагдах нь эрүүл мэнд, сайн сайхан аж амьдрал, бүтээмжид нөлөөлөх гол хүчин зүйл юм. Улаанбаатар хотын хүн ам нь 2020 оны түвшинд 1,534 мянга буюу нийт хүн амын /48,5%/ байхаар ерөнхий төлөвлөгөөнд тусгасан. Монгол улсын үндэсний аюулгүй байдал, Хүн амын усны нөөц, Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор 2030 оны түвшинд Нийслэл хотын хүн амыг улсын хүн амын 50,3% байхаар тооцсон. 2020 оны байдлаар төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээгээр нийт хүн амын 46,0 хувийг хангаад байна. Улаанбаатар

11 Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар (2021.02). Монгол улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний салбарын танилцуулга. УБ

хот орчимд нийт 286800 м3/хон нөөц бүхий 7 эх үүсвэрээс ф80-ф800 мм ийн голчтой 586 км урт цэвэр усны шугамаар цэвэр ус түгээж цэвэрлэгдсэн усыг ф100-ф1400 мм-ийн голч бүхий 236 км бохир усны шугамаар татан зайлуулж 190-210 мянган м3/хон хүчин чадал бүхий 8 цэвэрлэх байгууламжаар дамжуулан цэвэршүүлж байна. Гэр хороолол, амны сууцанд нийт хүн амын 20 хувь төвлөрсөн шугаманд холбогдсон ус түгээх 320 байруудаар үйлчлүүлдэг. Гэр хороололд 4 усан санг 193 км цэвэр усны төвлөрсөн шугамаар холбосон. Шугаманд холбогдоогүй 294 байранд зөөврөөр ус түгээж байна.


Улаанбаатар хотын ус хангамжид өдөрт 145,000-170,000м3 усыг олборлон нийлүүлж, батлагдсан нөөцийн 55 хувийг ашиглаж байгаа бөгөөд үйлдвэр, бусад салбарын усны хэрэглээ өдөрт-177.000м3 байна. 2019 оны эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хотын орон сууцны тоолууртай хэрэглэгчийн өдрийн хэрэглээ 127 литр, зөөврийн ус түгээх байраар үйлчлүүлж буй хэрэглэгчийн өдрийн хэрэглээ 7.3 литр, төвлөрсөн шугамд холбогдсон ус түгээх байраар үйлчлүүлж буй хэрэглэгчийн хэрэглээ 8.7 литр, 24 цагаар тасралтгүй ажилладаг ухаалаг ус түгээх байраар үйлчлүүлж буй хэрэглэгчийн өдрийн хэрэглээ 10.7 литр байна (Ус үндэсний хөтөлбөр 1.1).

Улаанбаатар хотын усны хэрэглээ жил ирэх бүр өсөн нэмэгдсээр байгаа. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-д 2030 он гэхэд 2010 оноос 2 дахин ус хэрэглэхээр байна гэж таамагласан байна. Монгол Улс нийт усны хэрэглээнийхээ 80 орчим хувийг газрын гүний усаар хангадаг бол Улаанбаатар хот усны хэрэглээний 99 хувийг газрын гүний усаар хангадаг. 1980 онд газрын гүний усны нөөцийг судалснаас хойш энэ ажил хийгдээгүй, харин 2015 онд Улаанбаатар хотын ус хангамжийн төвлөрсөн ба төвлөрсөн бус ус хангамжид ашиглаж буй усны нөөцийг дахин судалсан. Өмнө нь болон одоогоор Улаанбаатар хотод саарал усыг ашиглаагүй байгаа юм.

Ариутгах татуурга: Төв цэвэрлэх байгууламж нь хоногт дунджаар 190000-210000м3 бохир усыг хүлээн авч механик болон биологийн цэвэрлэгээг хийн, хэт ягаан туяагаар халдваргүйжүүлж Туул голд нийлүүлж байна. Байгууламж нь хүчин чадлаасаа усны хэмжээний хувьд 20-40 мянгаар их, бохирдлын хэмжээний хувьд 2-5 дахин их усыг хүлээн авч байна.


ҮЙЛДВЭРҮҮДИЙН ТОО


/Үйл ажиллагааны төрлөөр/



Цэвэрлэх байгууламжид ирж байгаа болон цэвэрлэгдэн гарсан усны бохирдолтын хэмжээг стандарттай харьцуулахад 2-9 дахин их байна. Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч-Хүлээн авах бохир усны стандарт-300 мг/л, цэвэрлэгдээд гарах усны стандарт-20мг/л, Хүлээн авч буй усны бохирдолт нэмэгдэх тусам цэвэрлэгээний түвшин буурч байна. Сүүлийн жилүүдэд хүлээн авч байгаа бохир усны хэмжээ болон бохирдолт эрс нэмэгдсэн. Бохирдуулагч үйлдвэрүүд нь урьдчилсан цэвэрлэгээ хийгээгүй өндөр бохирдолтой усыг төвлөрсөн шугаманд нийлүүлдэг. Төв цэвэрлэх байгууламжид “Бохирдуулагч үйлдвэрүүд” гэсэн ангилалд доорх 7 чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 225 үйлдвэр аж ахуйн газрууд бохирдсон усаа нийлүүлж байна.

Зураг 26. БОХИРДУУЛАГЧ ҮЙЛДВЭРҮҮД





Үйлдвэрийн урьдчилсан ЦБ/Харгиа/ 1972 онд байгуулагдсан 13000 м3/хон хүчин чадалтай. Одоогоор 1000-3000 м3/хон ус хүлээн авч цэвэрлэж байна. Механик химийн технологиор үйлдвэрийн бохирдлыг цэвэршүүлдэг. Үйлдвэрийн өндөр бохирдолтой ус, технологийн хоцрогдлоос болоод стандарт хангахгүй байна. Харгиа цэвэрлэх байгууламжид MNS 5582:2006 стандартаас 1.5-2 дахин өндөр бохирдолтой ус хүлээн авч бохирдлын хэмжээг 2-3 дахин бууруулж төвийн шугамд нийлүүлж байгаа боловч төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэх MNS 6561:2015 стандартын шаардлагыг хангахгүй байна.

Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих ажлыг Хятадын Монголын засгийн газар хоорондын гэрээгээр 2020-2025 оны хооронд байгуулахаар төлөвлөж байгаа.

Нийслэлийн хэмжээнд бохир усны шугам сүлжээний насжилт өндөр, хурын болон хөрсний ус шугам сүлжээ хийгдээгүйн улмаас хөрсний усыг бохир усны шугаманд зайлуулж байгаа нь цэвэрлэх байгууламжийн ачааллыг ихээр нэмэгдүүлж байна. Мөн Төв цэвэрлэх байгууламжийн төслийн технологийн шаардлагатай уялдуулан арьс шир ноос ноолуурын үйлдвэрүүдийг хотоос шилжүүлэх Харгиа цэвэрлэх байгууламжийг татан буулгах шаардлагатай байна.

Одоогийн байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд

- ✓ Үерийн хамгаалалтын ил далан суваг 147 км
- ✓ Зам талбайн борооны ус зайлуулах шугам 182 км
- ✓ Хөрсний ус зайлуулах шугам 18 км шугам, хөрсний усны ажиглалтын 53 цооног байнгын ашиглалтад байна.

Хөрсний бохирдол: Хот суурин газрын гэр хороолол тэлэхийн хэрээр стандартын шаардлагад нийцэхгүй ариун цэврийн байгууламж нэмэгдэж, улмаар ус, хөрсний бохирдлын гол эх үүсвэр, халдварт өвчин дэгдэх суурь нөхцөл болж байгаа ч нөгөө талаас, хөрсний бохирдлын гол эх үүсвэр нь хог хаягдал, уул уурхайн хаягдал, малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн хаягдал, агаарын бохирдол болж байна.


Улаанбаатар хотын нийт нийт хөрсний бохирдлын 80 гаруй хувь нь гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлонгоос, үлдсэн 20 хувь нь хог хаягдлаас шалтгаалдаг ба жилд 1.4 сая тонн хог хаягдал үүсч байна. Нийт хог хаягдлын 71 хувийг төвлөрсөн хогийн цэгт, 22 хувийг дахин боловсруулах түүхий эдийн цэгт, 7 хувь нь ил задгай хууль бусаар хаягддаг байна. Хогийн цэгт ирж байгаа хог хаягдлын 15 хувийг барилгын, 60 хувийг ахуйн, 25 хувийг үнс эзэлдэг. Нийт хог хаягдлын 70 гаруй хувийг дарж булж устгаж байна. Ил задгай хог хаягдал, гэр хорооллын нүхэн жорлон, машин засвар, угаалгын газруудын хаягдал зэрэг олон хүчин зүйлээс үүдэн Улаанбаатар хотын хөрсний бохирдол ихэссээр байна.

Хотын бохир ус цэвэрлэх байгууламж, аж үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагаас гарах хаягдал ус, төрийн эзэмшлийн болон хувийн цэвэрлэх байгууламжаас гарах дутуу цэвэршүүлсэн хаягдал усыг нийтийн татуургад нийлүүлэх, аж үйлдвэрийн болон ахуйн шингэн хаягдал зэрэг нь хөрс, усны нөөцийг бохирдуулагч гол эх үүсвэр болж байна.

Хог хаягдал: Улаанбаатар хотоос жилд дунджаар 1.1 сая тонн хог хаягдал гарч, 95 хувийг төвлөрсөн цэгт дарж булшилдаг, хог хаягдал дахин боловсруулах жижиг дунд үйлдвэрүүд 2016 оноос эхлэн эрчимтэй байгуулагдаж эхэлсэн ба тухайн онд нийт үүссэн хог хаягдлын 21 орчим хувийг дахин боловсруулсан байна. Түүнчлэн 200 гаруй тогтмол хог түүгч нар байгаа бөгөөд тэд өдөрт дунджаар 10 тонн орчим дахин боловсруулах хаягдлыг цуглуулж байна (НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2018).

Барилгын хог хаягдал нь хатуу хог хаягдлын 20-25 хувийг бүрдүүлдэг ба энэхүү хаягдлын дийлэнх хувийг хууль бус замаар хаяж байна. Барилгын компаниудад хог хаягдлынхаа төрөл, бүтцийг бүртгэх, хаягдлаа ангилан ялгах тогтсон системгүй байна. Үүний зэрэгцээ хогийн цэгүүд дээр буулгаж байгаа барилгын хог хаягдлын хэмжээ улам нэмэгдсээр байна (НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2018). Улаанбаатар хотын хатуу хог хаягдлыг устгаж булшлах энэ гурван цэг инженерчлэл, менежментийн үйл ажиллагааны стандартын хувьд ялгаатай бөгөөд харилцан адилгүй хэмжээний хог хаягдал хүлээж авдаг.

Зураг 27. **ХОГ ХАЯГДАЛ ХҮЛЭЭН АВДАГ ЦЭГ/ХОГ ХАЯГДЛЫН ХУВЬ/**



Гэр хороололд хог шилжүүлэн ачих станцууд байгуулах туршилтууд хийсэн боловч одоогоор нэг нь ч ажиллахгүй байна. Хог хаягдлыг шууд хогийн цэг рүү задгай болон битүү чингэлэгтэй машинуудын аль алиныг хэрэглэн тээвэрлэдэг. Ихэнх машин хүний гар ажиллагаа шаарддаг, ялангуяа өвлийн улиралд үнс ачихад хүний гэр ажиллагаа шаардлагатай болдог байна.

Улаанбаатар хотын Хог хаягдлын менежментийн хэлтсийн 2019 оны тоо баримтаас үзэхэд нийт 18 тохижилт, үйлчилгээний компанийн (ТҮК) 294 хог ачилтын машин ажиллаж байна. Эдгээрийн 7 нь 81 машинтай хувийн компаниуд байна. Тэд бүгд төвийн 6 дүүрэгт ажилладаг. Автомашины заримд нь байршил, хурд хянах GPS систем суурилуулсан, түлшний зарцуулалт хянах мэдрэгчтэй байна. Харин санхүүжилт хүрэлцээгүйгээс эдгээр машин, техникийг шинэчлэх нь ховор байдаг байна¹².

2017 оны 5-р сарын 12-ны өдөр УИХ-ын чуулганаар Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, хог хаягдал гэдэг ойлголт нь эдийн засгийн ойлголт болж эхэлсэн. Хог хаягдлын тухай хуулийн гол үзэл баримтлал нь хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, үйлдвэрлэгч, импортлогчийн хариуцлагыг нэмэгдүүлэх, иргэдэд хог хаягдлын боловсрол олгох, аюултай хог хаягдлын асуудлыг бүхэлд нь зохицуулах явдал юм.

Хотын хэмжээнд одоогоор хог цуглуулж ачих үйлчилгээ нэг ижил стандартаар хийгдэхгүй байгаа бөгөөд хог хаягдлын үндсэн үйлчилгээг зохистой үзүүлэх тал дээр гэр хорооллын хэд хэдэн газар хоцрогдож байгаа буюу үйлчилгээний давтамж, чанар, найдвартай ажиллагаа хангалтгүй байна. Гэр хороололд үүссэн хог хаягдлын хэмжээ хоёр дахин нэмэгддэг өвлийн улиралд хог ачих үйлчилгээний давтамж багасч, үйлчилгээний компаниудад энэ хэмжээний хогийг ачих хүчин чадал дутагдаж байна. Түүнчлэн өвлийн улиралд үүссэн нүүрсний үнс нь аюулгүй байдлын эрсдэл дагуулж, хогийн саванд болон хогийн цэгт хаясан халуун үнс нурам гал түймэр үүсгэж, улмаар агаарын бохирдлын асуудлыг улам дэвэргэхэд хүргэж байна.

Гэр хорооллын хог цуглуулж ачих үйлчилгээнд тогтоосон үнэ тарифийн төлөлт муу байгаагаас их хэмжээний татаас олгож байна. Энэ нь уг үйлчилгээг цаашид хөгжүүлэхэд саад учруулаад зогсохгүй хог хаягдал бууруулах зорилт, түүнд хүрэх мэдлэг дутагдаж буйг харуулж байна.

Хүлэмжийн хийн ялгарал: Улаанбаатар хотын агаарын температурын олон жилийн дундаж өөрчлөлт 2.6°C байгаа нь улсын дунджаас (2.24°C) 0.36°C-аар их, дэлхийн дунджаас 3 дахин өндөр байна. Цаашид уур амьсгалын өөрчлөлтийн эрчимшил ойрын ирээдүйд буюу 2016-2035 онд 1.0-1.5°C, 2046-2065 оны үед 3.1°C, 2081-2100 оны үед 5.6°C хүртэл нэмэгдэж дулаарах хандлагатай байна. Хур тунадасны хувьд өвлийн улиралд хур тунадас хүлэмжийн хийн ялгаралтаас хамааран хугацааны эхэн, дунд, төгсгөлд 12.1 хувь, 30.7 хувь, 52.4 хувь хүртэл тус тус нэмэгдэх бол зуны улиралд 10 хүртэл хувиар нэмэгдэх төлөвтэй байна (НБОГ, 2019). Монгол Улсын хүлэмжийн хийн ялгаруулалт нь дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгарлын 0.1 хувийг эзэлж байгаа нь харьцангуй бага үзүүлэлт мэт боловч уур амьсгалын өөрчлөлтийн хор хөнөөл нь газрын доройтол, агаарын бохирдол, цөлжилт, усны болон ойн сангийн хомсдол, байгалийн гамшигт үзэгдлийн тоо давтамж ихсэх зэргээр хүчтэй илэрч байна. Монгол Улсын нийт хүн амын 46 хувь нь Улаанбаатар хотод төвлөрч байгаагаас гадна хүлэмжийн хийн ялгаруулалтын гол

12 Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө (2017)

эх үүсвэр болсон нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцууд, эрчим хүчний томоохон хэрэглэгчдийн ихэнх нь Улаанбаатар хотод байгаа нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад нийслэлийн үүрэг их байгааг харуулж байна.

Эргэлтийн эдийн засаг нь Улаанбаатарт төдийгүй ерөнхийдөө Монгол улсын хувьд харьцангуй шинэ ойлголт юм. Эргэлтийн эдийн засгийн чиглэлээр Азийн Сангаас хэрэгжүүлж байгаа хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах зорилготой төсөл хэрэгжиж байна.

Тус төсөл тухайн салбарт байгаль орчинд ээлтэй технологи авч хэрэглэх эрх зүй, санхүү, технологийн таатай орчин бий болгох чиглэлээр Засгийн газар ба орон нутгийн захиргаадад дэмжлэг үзүүлж байна.

Авто зам, тээврийн сүлжээ: Улаанбаатар хотын авто замын сүлжээний өнөөгийн нөхцөл байдал нь авто машин, хүн амын өсөлттэй шууд хамааралтай. Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын авто замын сүлжээ 1,135.6 км хатуу хучилттай авто зам, 7,613 урт метр гүүрэн байгууламж, 187 км авто замын борооны ус зайлуулах байгууламжтай байна. Хотын барилгажсан нутаг дэвсгэрт хатуу хучилттай авто замын дундаж нягтрал 2.1 км/км² байгаа нь олон улсад харьцуулахад 21 дахин бага байна. Мөн хотын хэвтээ болон босоо тэнхлэгийн холбоос замууд хүртээмжгүй, явган хүний зам, ус зайлуулах байгууламжууд болон авто зогсоолын хүртээмж муу байна. Улаанбаатар хотын автозамын ерөнхий сүлжээ нь 349,000 хүн амтай, 10,044 автомашинтай буюу хүн амын ердөө 2.9% нь автомашинтай байсан 1975 оны ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдсан бөгөөд тэр үед хотын хүн амын даац 400,000–500,000 байхаар тооцоолсон байдаг. Гэтэл бүртгэлтэй автомашины тооноос үзэхэд 2019 онд нийт тээврийн хэрэгсэл 1,048,028 болж өссөн ба үүний 568,866 буюу 54.5% нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байна (Зам тээврийн хөгжлийн яам, 2019, хуудас 11). Энэ 35 жилийн хугацаанд ялангуяа, сүүлийн жилүүдэд гол тэнхлэг зам болох зүүнээс баруун чиглэлтэй Нарны зам ба үүний хойд талын Энхтайваны өргөн чөлөөтэй паралель замуудыг холбох ажил хийгдсэн боловч хүн ам, автомашины тооны өсөлттэй харьцуулахад зам, гүүр хангалтгүй хэвээр байна. Мөн замын хөдөлгөөний энэ түгжрэлийг хөдөлгөөний хяналт дутмаг, замын хөдөлгөөний соёл муу, зам дээр машинаа зогсоодог зэрэг үзэгдлүүд улам хурцатгаж байна.

Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний хурд 13 км/цаг байна. Оргил ачааллын үед 8.9 км/цаг болж байна. 2010 онтой харьцуулахад авто замын сүлжээний даац гурав дахин хэтэрсэн. Иргэд өдөрт 2.5 цаг, жилд 35 өдрийг түгжрэлд өнгөрөөж байна. Улаанбаатар хотын авто замын 78 хувь нь түгжирдэг. 2010 онд авто замын сүлжээний урт 954 км, 234 мянган тээврийн хэрэгсэлтэй байсан бол 2020 онд замын урт 1136 км, машины тоо 632 мянга болж нэмэгдсэн байна. Иймээс авто замыг гурав дахин нэмэгдүүлэх шаардлагатай. Энэ байдлаар үргэлжилбэл 2025 онд автомашины хурд 6 км цаг, 2030 онд 3 км цаг болох эрсэдэлтэй байна. ДНБ-ийнхээ 8 хувийг түгжрэлд алдаж, иргэдийн 85 хувь түгжрэл дээд түвшиндээ хүрсэн гэж үнэлэлт дүгнэлт өгч байна. Иймд түгжрэлийг 50 хувь хүртэл бууруулах тодорхой төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өргөтгөсөн хуралдаанаар Улаанбаатар хотын тулгамдсан асуудлыг хэлэлцэж, авто замын түгжрэлийг бууруулах цогц арга хэмжээ авч, 2022-2024 онд жил бүр 420-оос доошгүй тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцуулж байхаар шийдвэрлэсэн. (Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 146 дугаар тогтоол)

Нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 1,189 тээврийн хэрэгсэл байгаа бөгөөд дундаж насжилт 9.5 жил

байна. Нийтийн тээврийн үйлчилгээнд нийслэлийн өмчийн 2, хувийн хэвшлийн 18 аж ахуйн нэгж үндсэн 98 чиглэлд нийт 920 их багтаамжийн автобус, троллейбусоор өдөрт 550-600 мянган зорчигчдод үйлчилж байна¹³.

Ангилал ба үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага, стандартын дагуу нийтийн тээврийн үйлчилгээнд үйлдвэрлэгдсэнээс хойш 12 жил ашиглагдсан тээврийн хэрэгсэл ашиглахыг хориглодог бөгөөд 2020 онд 133 автобус, 2021 онд 531 автобус, 2022 онд 121 автобус, 2023 онд 151 автобус, 2024 онд 60 автобус нийт 81.7 хувь нь үйлчилгээнээс хасагдахаар байна. 2021 онд орон нутгийн өмчит байгууллагаас 250 ширхэг, хувийн хэвшлийн 280 ширхэг нийт 530 тээврийн хэрэгсэл насжилт дуусаж ашиглалтаас хасагдах тул нийтийн тээврийн парк шинэчлэлтийн төсөл нь нэн тэргүүний шаардлагатай төслүүдийн нэг юм.

2018-2020 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:

- ☑ 2019 онд МОН-30 Монголд үйлдвэрлэсэн 2 автобус,
- ☑ 2020 онд БНХАУ-аас 10 цахилгаан автобусыг авч туршилтаар Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглаж байна.
- ☑ 2020 онд сургуулийн хүүхдийн автобус нийт 75-ийг авахаас эхний ээлжинд 5ш автобусыг 10 дугаар сард оруулж ирсэн.

Нийтийн тээврийн үйлчилгээнд нийт 959 зогсоол ашиглагдаж байгаагаас эцсийн 57, дундын 902 зогсоол байна. Нийслэлийн нутаг дэвсгэрт нэр бүхий 212 байршилд автобусны зогсоолын байгууламж барих төслийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлж байна.

Улаанбаатарын бүсийн доторх хаяа дагуул хот суурингууд, дорвитой хөгжиж чадахгүй байгаагийн улмаас логиستيкийн үйл ажиллагаа сул хөгжсөн. Ачаа тээврийн эргэлт нь агаарын тээвэр, авто тээвэр, төмөр замын тээвэр гэсэн 3 төрлөөр хөгжиж байна. Ачаа эргэлт нь олон улсаас Улаанбаатар хотыг чиглэсэн, Улаанбаатар хотыг дамжин өнгөрөх, Улаанбаатар хотоос гадагш чиглэсэн урсгалтай байна. Одоогоор төмөр замын үндсэн магистраль даган ихэнхдээ хотын 1 ба 2 дугаар бүсэд байрласан ачааны 9 терминал байна. Нийт зам талбайн хэмжээ нь 271,923 м2, салаа төмөр замын урт 10,136 м, ачаа ачиж буулгах талбай 53,502 м2, хяналтын талбай 74,212 м2 байна. Нийт 40,000 м2 талбайтай 11 дулаан, 28,000 м2 талбайтай 37 хүйтэн агуулахтай байна.

Инженерийн дэд бүтэц: Нийслэл Улаанбаатар хотын цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийг Монгол улсын төвийн эрчим хүчний системээс буюу ДЦС-2, ДЦС-3, ДЦС-4 дүгээр цахилгаан станцуудаас “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ны Улаанбаатар салбарын 110кВ-ын 30 дэд станц, “Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК-ны эзэмшлийн 35кВ-ын дэд станцуудаар дамжуулан цахилгаан эрчим хүчээр хангадаг. Эдгээр дулааны цахилгаан станцуудын нийт суурилагдсан хүчин чадал 910МВт юм. Нийслэл хотын цахилгаан эрчим хүчний хэрэглэгчдийн найдвартай ажиллагааг хангах үүднээс дэд станцуудыг шинээр барьж байгуулах, шинэчлэх өргөтгөх шаардлагатай. Үүнд: Улаанбаатар цахилгаан дамжуулах сүлжээнд 35кВ-н 4 станцыг өргөтгөн шинэчлэх, 2 станцыг шинээр барих мөн 110/35/10кВ-н шинээр 10 дэд станц барих шаардлагатай.

Улаанбаатар хотыг төвлөрсөн дулаан хангамжаар хангадаг дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэдэг ДЦС-2,3,4 станцууд, Амгалан дулааны станцын үйлдвэрлэсэн

13 Нийтийн тээврийн үйлчилгээний газар (2021.02). Монгол улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний салбарын танилцуулга. УБ

дулааны эрчим хүчийг 15ш магистраль, 334 км урт дулааны төв шугам, даралт өргөх насосын 10 станцаар дамжуулан 2924.2 Гкал/цаг ачаалал бүхий 11900 гаруй барилга байгууламжийг дулаанаар хангаж байна. Өнөөгийн түвшинд дулаан хангамжийн системийн нийт 334 км урттай шугамын 27% буюу 90.7км урттай дулааны төв шугам 30 жилээс дээш насжилттай, насжилтын хугацаа дууссан тул ойрын хугацаанд шинэчлэн солих шаардлагатай байна. Сүүлийн жилүүдэд нийслэл хотод барилгажилт эрчимтэй явагдаж байгаатай уялдуулан жилд дунджаар 180-230 Гкал/цагийн ачаалал бүхий 400 орчим барилга төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдож байгаа бөгөөд дулаан түгээлт жилдээ 4-7 хувиар өсөж байна. Одоогийн байдлаар төвлөрсөн дулаан хангамжийн системийн эх үүсвэрүүд 420.2 Гкал/цагийн хүчин чадлын дутагдалд орсон ба гадна агаарын тооцоот температурыг -390С утганд, хэрэглэгчдийн дулааны тооцоот ачааллыг 150/700С температурын графикаар сүлжээний усны тооцоот зарцуулалтыг тооцдог ба бодит байдалд гадна агаарын температурын өөрчлөлтөөс шалтгаалж, нийт хэрэглэгчдийн дулааны хэрэглээ хувьсах учир дамжуулах сүлжээнд тоон болон чанарын тохируулга хийж хэрэглэгчдийг найдвартай дулааны эрчим хүчээр хангаж байна.

Улаанбаатарын бүс, хот, хот орчмын нутаг дэвсгэрт төвлөрсөн, хэсэгчилсэн инженерийн дэд бүтцийн хангамжийн эх үүсвэр, дамжуулах шугамын хүчин чадал нь одоогийн хэрэгцээ шаардлагыг хангаж байх боловч хэтийн ирээдүйд өсөн нэмэгдэх хэрэгцээг хангах бололцоогүй юм. Мөн шугам сүлжээний насжилт өндөртэй, технологийн хувьд хуучирч муудсан байдалтай байна. Тиймээс инженерийн дэд бүтцийн найдвартай хүртээмжтэй, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх, өргөтгөн шинэчлэх төслүүдийг хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Харилцаа холбооны хөгжил, түүний дэд бүтэц: 2011 оноос интернет, телевиз, яриа хосолсон гурвалсан /triple play/ үйлчилгээний хэлбэр нэвтрүүлэхээр техникийн боломжийг бий болгон Мобиком, Скайтел, Юнител компаниуд хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн. Одоогийн байдлаар Монгол Улсын нийт интернет хэрэглэгчийн тоо 2.6 сая хүрч, 2010 оноос 13 дахин өссөн ба 2016 оноос 8.5 хувь илүү өссөн байна. Интернет протоколд суурилсан олон сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 642.0 мянга буюу орон сууцтай өрхийн 92 хувьд нэвтэрсэн. Харилцаа холбооны системийн технологийн хөгжил хурдацтай байна.

Хотын стандарт: 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Улсын Их Хурлаас Нийслэл хот болон, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгонтой холбоотой хууль эрх зүйн орчныг бүрдүүлсээр ирсэн хэдий ч нийслэл хотын хүн амын өсөлт, төрийн байгууллагын төвлөрөл, үйлдвэрлэл, эдийн засгийн төв бүс нутаг болж хөгжсөнтэй холбоотойгоор эрх зүйн зохицуулалтын хувьд тодорхой хүндрэл, бэрхшээлтэй асуудлууд тулгарч байна. Тухайлбал, 2019 онд нийслэлийн хэмжээнд орчны аюулгүй байдал алдагдсан 5'423 зөрчил дутагдал илэрч, нийт зөрчил дутагдлын дийлэнх буюу 25 хувь нь явган замын засвар ашиглалт, 11.5 хувь нь авто замын эвдрэл, орц гарц, 21 хувь нь инженерийн шугам сүлжээний ашиглалт зэрэг асуудлууд эзэлж байх тул амьдралын таатай орчныг хэмжих хотын стандартуудыг баталж, мөрдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 100 дугаар тогтоолоор Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, хотын стандарт, норм, дүрмийг боловсруулах, мөрдүүлэх, хяналт тавих, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зохион байгуулах чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг “Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар”-ийг шинээр үүсгэн байгуулсан. Тус газраас хийсэн Нийслэлийн хэмжээнд стандартын хэрэгжилтийг

хотын гудамж зам талбайн орчин, дэд бүтцийн хангамж болон Нийслэлийн Нутгийн Захиргааны байгууллагуудын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байгаа стандарт баримт бичгийн хэрэгжилтийн судалгаа (2019.6-7 сар)-наас үзвэл “Нийслэлийн нутгийн захиргааны болон харьяа нийт 61 байгууллагаас 702 ширхэг стандарт, 619 ширхэг норм ба дүрэм, 57 ширхэг журмыг тус тус үйл ажиллагаанд мөрдөж ажиллаж байна гэсэн боловч гадаад орчинд хийсэн судалгаагаар орчны аюулгүй байдал алдагдсан 5423 тохиолдол илэрсэн” байна. Нийт зөрчил дутагдлын дийлэнх олонх нь явган замын засвар ашиглалт, авто замын эвдрэл, орц гарц, инженерийн шугам сүлжээний ашиглалт болон барилгын үйлдвэрлэлийн аюулгүй байдалтай холбоотой хууль, дүрэм журам, норм стандартын хэрэгжилт хангалтгүй байгаа нь ажиглагдаж байна. Хангалтгүй байгаа шалтгаануудыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ☑ Төрийн болон мэргэжлийн байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүдийн чанар стандартын талаар мэдлэг ойлголт сул, шаардлага тавих чадвар, ухамсар доогуур байгаагаас илт стандартын шаардлага хангаагүй ажил үйлчилгээг хүлээн зөвшөөрч арга хэмжээ авалгүй өөгшүүлдэг.
- ☑ Төрийн болон мэргэжлийн байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүдийн ажилдаа хандах хандлага, мэдлэг чадвар, мэргэжил, мэргэшил хангалтгүй.
- ☑ Төрийн болон мэргэжлийн байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг хянах хариуцлага хяналтын тогтолцоо байхгүй.
- ☑ Стандарт, техникийн зохицуулалтын баримт бичигт тавигдсан шаардлага нь хэт ерөнхий байдалтай, нарийн заавар зөвлөгөө дутмаг, хуучирч шинэ цагийн хот төлөвлөлт, барилгажилтын шаардлага хангахгүй болсон, мөн онол арга зүйн талаар бичсэн хэт их бичиглэлтэй, зураг схем дутмаг байдаг.
- ☑ Монгол улсын стандартын улсын бүртгэлд 6390 стандарт байгаа ба эдгээр стандартуудыг иргэд, байгууллагууд заавал биелүүлэх бус сонгож хэрэглэх нөхцөлтэй. Төрийн байгууллагуудын чиг үүрэгт стандартын хэрэгжилтийг хангуулж ажиллахаар заасан байдаг боловч, уг ажлыг мэргэжлийн хяналтын байгууллагын ажил гэж боддог байна.

Өнөөгийн байдлаар норм стандартын эрх зүйн орчин нь Монгол улсын стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Барилгын тухай хууль болон Барилгын норматив баримт бичгийн тогтолцоо / БНБД 00-01-99/ -оор зохицуулагдаж байна.

Нийслэл Улаанбаатар хот иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ болон иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжийг хангасан барилга, зам дэд бүтэц инженерийн шугам сүлжээг үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт шаардлагад тулгуурлан олон улсын хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэх Хотын стандарт¹⁴ шалгуур үзүүлэлтийг тогтоож барьж байгуулах нөхцөл боломж эрх зүйн орчинг бүрдүүлж ажиллаж байна. 2020 оны байдлаар нийт 15 хотын стандартыг батлан мөрдүүлж байна. Үүнд:

1. Орчны аюулгүй байдал: Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага (UCS0001-01:2019)

14 Хотын стандарт (UCS) гэдэг нь Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын иргэдэд хүргэх бүтээгдэхүүн үйлчилгээний шаардлагыг үндэсний болон олон улсын стандартад нийцүүлэн тогтоох, үйл ажиллагааны дотоод зохион байгуулалтыг нэгдсэн удирдамж арга зүйгээр хангах зориулалт бүхий баримт бичгийг хэлнэ хэмээн тодорхойлжээ. (<http://standart.ub.gov.mn/>, 2020)

2. Иж бүрэн гудамж: Хашаа, хайс, хашлагад тавигдах ерөнхий шаардлага, хэрэглээ (UCS0001-02:2019)
3. Гадна орчны тохижилт: Хүүхдийн тоглоомын талбайн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага (UCS0002-02:2019)
4. Цэвэр агаар, эрүүл орчин: Зуух, пийшин, яндангийн бүрэн бүтэн байдал, галлагаанд тавигдах шаардлага
5. Зорчигч тээврийн үйлчилгээ: Такси зогсоолд тавигдах шаардлага (UCS1602B:2020)
6. Зорчигч тээврийн үйлчилгээ: Такси үйлчилгээнд тавигдах шаардлага (UCS 1803C:2020)
7. Зорчигч тээврийн үйлчилгээ: Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавигдах шаардлага (UCS 1601B:2020)
8. Зорчигч тээврийн үйлчилгээ: Хүүхдийн автобусанд тавигдах шаардлага (UCS 1602C:2020)
9. Зорчигч тээврийн үйлчилгээ: Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага (UCS 16001C:2020)
10. Гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл: Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага (UCS 1901B:2020)
11. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө: Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах хогны саванд тавигдах шаардлага (UCS 1403C:2020)
12. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө: Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах сандалд тавигдах шаардлага (UCS 1404C:2020)
13. Иж бүрэн гудамж: Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага (UCS 0902B:2020)
14. Иж бүрэн гудамж: Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавигдах шаардлага (UCS 0903B:2020)
15. Иж бүрэн гудамж: Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлага (UCS 0901B:2020)

Хот төлөвлөлт, хотын ерөнхий төлөвлөгөө: Хотын ерөнхий төлөвлөгөөнүүдээс үзвэл 1985 онд 850 мянган хүн ам бүхий хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, төлөвлөгөөний дагуу барилгажилтын үйл ажиллагаа явагдаж байсан бол 1992 онд Ардчилсан хувьсгал гарч улс орон зах зээлийн чөлөөт эдийн засгийн тогтолцоонд шилжин орсны улмаас бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөж хот байгуулалтын бодлого бүрэн алдагдсан байгаа юм. (Нийслэлийн Зураг Төслийн Хүрээлэн, 2013).

2020 он хүртэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Япон улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/-ийн тусламжтайгаар 2010 онд боловсруулж хэрэгжүүлэх чиглэлээр ажилласан боловч нэгэнт алдагдсан хот байгуулалтын бодлого, газрын хууль бус наймаа, нэгдсэн зураг төсөл төлөвлөлт байхгүйгээр Улаанбаатар хот өнөөгийн төрхийг олсон байна. Мөн өнгөрсөн хугацаанд баталж ирсэн ерөнхий төлөвлөгөөнүүдээс үзвэл 10 жилээс дээшгүй хугацаанд өөрчлөгдөж ирсэн байна.

Энэ нь тухайн нийгэм эдийн засаг, хүн амын өсөлттэй холбоотой. Ялангуяа, сүүлийн 30 жилд хот төлөвлөлт алдагдсан. Уг нь 20 жилийн хугацаатай батлагдаж хэрэгжих нь тогтвортой хөгжлийг ахиулах боломж бүрддэг гэж эрдэмтэд үздэг байна.


Хотжих үйл явц энэ маягаар газар ашиглалтын талаар томоохон арга хэмжээ авахгүйгээр үргэлжилбэл Улаанбаатар хотын хувьд хотын хяналтгүй тэлэлт бололцоотой бүх л газрыг бүрхэн үргэлжлэх болно. Нөгөө талаар, ямар нэгэн зохицуулалтгүй суурьшиж улмаар хотыг гамшгийн түвшинд хүргэх, хотын эдийн засгийн хөгжлийг бууруулж байна. Иймээс хотын эдийн засгийн хөгжилтэй зэрэгцүүлэн хотын өсөлтийг зохицуулах нь зайлшгүй шаардлагатай болж байна.

Монгол улсын УИХ-ын 2013 оны 02 сарын 08-ны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичгийн тайланд Улаанбаатар хотод үүсээд байгаа нөхцөл байдлыг “зохисгүй төвлөрөл бий болсноор хүн амын амьдрах орчин эрсдэлтэй болж, гамшгийн түвшинд хүрсэн” гэж тодорхойлсон бөгөөд хотод тулгамдаж байгаа асуудлууд болон түүний үүсэх болсон шалтгааныг дараах байдалтай тодорхойлсон байна.

Нийслэлийн дагуул хот: Нийслэл нь эдийн засгийн дэд бүтцийг тэнцвэртэй хөгжүүлэх, хүн амын хэт төвлөрөл болон хотын хангамж, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах, оршин суугчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгаль орчны зохистой харьцааг хадгалах үүднээс дагуул хот /алслагдсан дүүрэг, хаяа хот, тосгон/-той байж болно (<https://www.legalinfo.mn/law/>) гэж “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль”-нд заасан. Үүний дагуу УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-т Улаанбаатар хотыг 15 дагуул хоттой байхаар төлөвлөсөн. Мөн Улаанбаатар хотын Дагуул, хаяа, хот, тосгодын суурьшлын бүсийн хил хязгаарыг тогтоох тухай нийслэлийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/917 дугаар захирамж гарсан.

Улаанбаатарын дагуул хот, тосгоны бүсэд Аргалант-Эмээлт, Налайх, Багануур, Багахангай дүүргүүд, хотыг тойрсон Сонгино-Био, Шувуу, Аэросити, Өлзийт, Гачуурт, Хонхор, Жаргалант, Рашаант, 361-н гарам, Тэрэлж гэх мэт төвлөрсөн хот, тосгод хамрагдана. Дээрх захирамжид Улаанбаатар хотыг бүсийн голлох томоохон хотын үүргийг хэвээр хадгалж, улсын нийслэл, эдийн засаг, санхүүгийн төв, оюуны өндөр багтаамж бүхий үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ хөгжсөн хот, дагуул, хаяа, хот, тосгодыг түүхий эд боловсруулах, түлш эрчим хүч, уул уурхай, барилгын материалын болон хөдөө аж ахуй, хүнс хөнгөн үйлдвэрлэл, аялал жуулчлалын чиглэлээр хөгжсөн, оршин суугчдын амьдралын таатай орчин бүрдсэн хот, тосгод болон хөгжүүлэхээр төлөвлөсөн. Тухайлбал, Налайх хотыг барилгын материалын үйлдвэрлэл хөгжсөн, Багахангай хотыг хөнгөн үйлдвэрлэл технологийн парк, тээвэр ложистик хөгжсөн, Био-Сонгино, Туул, Рашаант, Жаргалант зэрэг тосгодыг хөдөө аж ахуйн чиглэлээр хөгжсөн, Гачуурт, Тэрэлж тосгодыг аялал жуулчлалын чиглэлээр хөгжсөн хот суурин байхаар төлөвлөсөн байгаа юм.

Зураг 28. УЛААНБААТАР ХОТЫН ДАГУУЛ ХОТ



Хаяа дагуул хот, суурингуудыг үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулна.

Улаанбаатар бүс нь босоо тэнхлэгт Ази, Европыг холбосон эдийн засгийн коридорын дагуу хийгдэж байгаа АН-3 хурдны авто зам, одоогийн төмөр зам, хэвтээ тэнхлэгт мянганы замын дагуу байрлаж байна. Мөн өмнө хэсэгт Хөшигийн хөндийд олон улсын нисэх онгоцны шинэ буудал ашиглалтад орсон нь чухал ач холбогдолтой байна.

Налайх дүүргийн хувьд Үйлдвэр, аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх бол Багануур дүүрэг нь 2030 он хүртэл 70 орчим мянган хүн амтай уул уурхай, эрчим хүч, хими технологи, барилгын материалын үйлдвэрлэл түлхүү хөгжсөн аж үйлдвэрийн хот болно. Эмээлт-Аргалант нь 15 орчим мянган хүн амтай шинээр байгуулагдах дагуул хот байх юм. Хөгжүүлэх үйлдвэр нь ноос ноолуур, арьс ширний анхан шатны боловсруулалт, тээвэр ложистик, бөөний худалдаа, хүнсний жижиг дунд үйлдвэрлэл байна. Туул-Шувуу нь Улаанбаатар хотын хүн амыг хүнсний нарийн ногоо, гахай шувууны махаар хангах гол ХАА-н үйлдвэрлэл дагнан хөгжих ба 12,000 орчим хүн амтай байна. Энд гахай шувууны эрчимжсэн аж ахуй, хүнсний нарийн ногооны хүлэмжийн аж ахуй, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах жижиг дунд үйлдвэрлэл, сав баглаа боодлын үйлдвэрлэл зонхилон хөгжинө.

Био-Сонгино нь 6 орчим мянган оршин суугч бүхий дагуул суурин байна. Хөгжүүлэх чиглэл нь малын эм бэлдмэлийн үйлдвэрлэл, амралт сувилал, нано-биотехнологи. Өлзийт нь 5 мянган байнгын оршин суугчтай дагуул суурин байх ба гол төлөв хотын иргэдийн зуслан, туслах аж ахуйн чиглэлээр хөгжинө. Үүнд: төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, хүнсний нарийн ногооны хүлэмж зэрэг багтана. Гачуурт дагуул суурин 7 мянган оршин суугчтай байх ба гол төлөв амралт зугаалга, байгалийн аяллын чиглэлээр хөгжинө. Партизан-Жаргалант нь 13 орчим мянган хүн амтай дагуул суурин байна.

Уг суурьшил нь 361-ийн гарам, Рашаант 0442, Партизан-Жаргалант гэсэн 3 суурингаас бүрдэх бөгөөд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дагнан хөгжинө. Аэро ситийг /Хөшигийн хөндий/ шинээр барих олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн байгуулах бөгөөд 100,000 хүн ам оршин сууна. Зонхилох үйлдвэрлэл нь агаарын тээвэр, мэдээлэл технологи, худалдаа үйлчилгээ, бизнесийн төв, ложистик байна. Оюутны хотхоныг /Шивээтийн хөндий/ шинээр байгуулна. Энд их дээд сургуулиуд төвлөрч сургалт, эрдэм шинжилгээний судалгаа чиглэлээр үйл ажиллагаа явуулах ба багш оюутны байр орон сууц, бүх төрлийн үйлчилгээ төвлөрсөн 100,00 мянган хүн амтай хотхон байна.

Гэхдээ өнөөдрийн байдлаар Улаанбаатарын бүсийн доторх хаяа дагуул хот суурингууд, дорвитой хөгжиж чадахгүй байгаагийн улмаас логистикийн үйл ажиллагаа сул хөгжсөн. Ачаа тээврийн эргэлт нь агаарын тээвэр, авто тээвэр, төмөр замын тээвэр гэсэн 3 төрлөөр хөгжиж байна. Ачаа эргэлт нь олон улсаас Улаанбаатар хотыг чиглэсэн, Улаанбаатар хотыг дамжин өнгөрөх, Улаанбаатар хотоос гадагш чиглэсэн урсгалтай байна. Одоогоор төмөр замын үндсэн магистраль даган ихэнхдээ хотын 1 ба 2 дугаар бүсэд байрласан ачааны 9 терминал байна. Нийт зам талбайн хэмжээ нь 271923 м², салаа төмөр замын урт 10136 м, ачаа ачиж буулгах талбай 53502 м², хяналтын талбай 74212 м² байна. Нийт 40000 м² талбайтай 11 дулаан, 28000 м² талбайтай 37 хүйтэн агуулахтай байна.

Нийслэлийн дагуул томоохон суурин газар Налайх, Багануур, Багахангай дүүрэг дагуул хот тосгодын одоо ашиглагдаж байгаа дулааны эх үүсвэрт БЗИУ-100, НР-18, ДТХ, КВТС маркийн зуухнуудыг ашиглан дулаан хангамжаар хангаж байна. Нийслэлийн дагуул хот тосгодын дулааны шугам сүлжээний ихэнх хэсэг хуучирч элэгдэх шатандаа орж шинэчлэх сайжруулах шаардлагатай байна.

ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Гадаад орчны шинжилгээ нь (PESTLE - улс төр, эдийн засаг, нийгэм, технологи, эрх зүй, байгаль орчин) бичил судалгааны үр дүнд тулгуурлан тодорхойлох юм.

Эдийн засгийн орчин: Улаанбаатар хотод Монгол улсын эдийн засгийн үйл ажиллагааны талаас илүү хувь нь явагддаг ч Монгол улсын татварын орлого бүрдүүлэх төвлөрсөн тогтолцоо нь Улаанбаатар хот, төвлөрүүлж болох татварын орлогодоо түшиглэн төрийн үйлчилгээний хангамжийг бие даан санхүүжүүлэх бололцоог хязгаарлаж байгаагаас гадна улсын болон нийслэлийн төсөв батлах үйл явц нь нийслэлийн удирдлагын зүгээс дэвшүүлсэн зорилгоо хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна. Тухайлбал, улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн санал болон тухайн оны Төсвийн тухайн хуульд туссан байдлыг харьцуулсан судалгаанаас үзэхэд, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хүргүүлсэн 783 төрлийн (төсөвт өртөг нь 3,735.6 тэрбум төгрөг) төсөл, арга хэмжээнд зориулж 1,935.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн саналаас салбарын яамд болон Сангийн яамны хяналтаар 760 санал нь хасагдаж, зөвхөн 23 нэр төрлийн (төсөвт өртөг нь 867.5 тэрбум төгрөг) хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зориулж 276.5 тэрбум төгрөгийн санхүүжилт буюу анхны саналын дөнгөж 15 хүрэхгүй хувьтай тэнцэх саналыг Улсын төсвийн төсөлд тусгахаар төлөвлөжээ. Төсөв батлагдсаны дараа буюу Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд төсвийн төсөлд тусгагдсан 276.5 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 23 нэр төрлийн саналаас зөвхөн 12.8 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 16 нь тусгагджээ. Харин орон нутгийн саналд тусгагдаагүй байсан 94 төсөл арга хэмжээг УИХ-аар улсын төсөв хэлэлцэх үед нэмж, нийт 110 нэр төрлийн (410.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий) төсөл, арга хэмжээнд зориулж 73.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нийслэлд зориулж баталсан байна (НЗДТГ, 2020).

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2016 онд нийт 99 төрлийн (348 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий) төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж 149.3 тэрбум төгрөгийн саналыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн байна. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хэлэлцүүлгийн явцад нийт өргөн барьсан хөрөнгө оруулалтын 99 саналаас 11 саналыг хасаж, 88 саналыг хэвээр үлдээн, харин Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн саналаар 12 саналыг нэмж, нийт 346.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 100 нэр төрлийн төсөл, арга хэмжээнд зориулж 203.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг баталсан байна. Эндээс харахад улсын төсвийн хөрөнгөөр санхүүжин нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын санал болон Монгол Улсын их хурлаас баталсан Монгол Улсын төсвийн тухай хуульд туссан төсөл хоёрын хооронд ихээхэн ялгаа байна (НЗДТГ, 2020).

Улс төрийн орчин: УИХ-д нийслэлээс сонгогдсон гишүүдийн санаачилгаар Нийслэлийн хөгжлийг дэмжих зорилгоор түр хороо байгуулан ажиллахаар болсон. Мөн нийслэлээс сонгогдсон УИХ-ын гишүүд сонгогдсон тойрогтоо тодорхой ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлдэг. Хууль эрх зүйн хүрээнд нийслэлийнхний хүсэл сонирхлыг илэрхийлэх боломж олгодог. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”, 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох

үндсэн чиглэл"-д Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналаа тусгуулсан.

Эрх зүйн орчин: Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдөр шинэчлэн баталсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн нийслэл хот нийгэм, эдийн засгийн хувьд бие даан хөгжих хөшүүргийг бий болгох, хүн амын төвлөрлийг сааруулах, нийслэлийг нэг төвт хотоос олон төвт, орчин үеийн хот болгон хөгжүүлэх, нийслэлийн дагуул хот, тосгодыг хөгжүүлэх, нийслэлийн удирдлагын эрх зүйн байдлыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагад тулгуурлан Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг ажиллаж байна.

Нийгэм, соёлын орчин: Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын бараг 2 хүн тутмын нэг нь нийслэл хотод төвлөрч, хүн амын нягтралаар хамгийн өндөр хот болж байна. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгж байгууллагын 64.2 хувь нь нийслэл хотод төвлөрч, дотоодын нийт бүтээгдэхүүний 66.6 хувийг бүрдүүлж, улсын нийгэм, эдийн засгийн цөм болон хөгжиж байна.

Улаанбаатар хотын эдийн засгийн 58.4 хувийг үйлчилгээний, 41.3 хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 0.4 хувийг хөдөө аж ахуйн салбар тус тус эзэлж байна. Нийслэлийн эдийн засагт худалдаа, зочид буудал, зоогийн газар, боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, олборлолт, санхүү, бизнес, тээвэр, мэдээлэл, холбооны үйл ажиллагаа жинтэй хувийг эзэлдэг.

Эдийн засгийн бодит өсөлт жилд дунджаар 8.7 хувь байсан ба хамгийн их өсөлт барилга, аж үйлдвэрийн салбарт гарсан байна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2019 онд 16.9 мянган төгрөг байна.


Нийслэлийн төсвийн орлого нь "Төсвийн тухай" хуулийн 23 дугаар зүйлд зааснаар төсвийн орлогын ангиллын дагуу нийтдээ 23 нэр төрлийн татварын болон татварын бус орлогын нэр төрлөөс бүрдэж байгаагаас 16 нэр төрөл нь татварын орлогоос, 5 нь татварын бус орлогоос, 2 нь хөрөнгийн түрээс болон өмч хувьчлалын орлогын нэр төрлөөс бүрдэж байна.

Нийслэлийн төсвийн орлогын 60.5 хувийг Хувь хүний орлогын албан татвар бүрдүүлж байгаагийн 45.3 орчим хувийг Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар дангаар эзэлж, үлдэх хувийг үл хөдлөх хөрөнгө, буу, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгсэл, газар, ус гэх мэт тодорхой нэг объектод хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулдаг хязгаарлагдмал эх үүсвэр бүхий орлого бүрдүүлж байна.

Монгол Улсын Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичигт Улаанбаатар ба дагуул хот бие даасан бүлгийг тусгуулсан. Нийслэлийг хөгжүүлэх дунд болон богино хугацааны бодлогоо тодорхойлсон.

Гадаад хамтын ажиллагаа: Улаанбаатар хот нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, Гадаад бодлогын үзэл баримтлалын дагуу Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах хүрээнд гадаадын хотуудтай найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлсээр ирсэн бөгөөд өнөөдөр дэлхийн 40 гаруй хоттой харилцан ашигтай Ах дүүгийн болон найрамдалт харилцаатай хамтран ажилладаг.

Зураг 29. УЛААНБААТАР ХОТЫН ГАДААД ХАРИЛЦАА



ТАЙЛАР

Монгол Улс:


- Төрийн байгууламжийн хувьд нэгдмэл
- Ардчилсан ёс
- Хүний эрх, эрх чөлөө
- Чөлөөт эдийн засаг
- Далайд гарцгүй
- Хөгжиж байгаа орон

Улаанбаатар хот:

- Монгол Улсын нийслэл
- Гадаад орны 13 хот руу тогтмол болон хуваарьт нислэгтэй
- ОХУ, БНХАУ-ыг холбосон төмөр замын шугам

Гадаад харилцааны бодлогын чиглэл:

- ОХУ, БНХАУ
- АНУ, Япон, ХБНГУ
- Энэтхэг, БНСУ, Тайланд, Сингапур, Турк, Дани
- Нидерланд, Финланд, Австри, Швед, Швейцари
- Польш, Унгар, Чех, Казакстан, Украин, Беларусь, Киргизстан, Узбекистан



ТАЙЛАР

Оросын Холбооны Улс

- 144,5 сая хүн
- Дэлхийн 12 дахь том эдийн засаг
- Хий дамжуулах хоолойн төслүүд

БНХАУ:

- 1,4 тэрбум хүн
- Дэлхийн 2 дахь том эдийн засаг
- Нэг бүс, нэг зам төсөл

Монгол Улс:

- 3,2 сая хүн
- Эдийн засгийн нөөц боломж
- Бүс нутгийн асуудалд тогтвортой

Улаанбаатар хот нь анх 1957 онд ОХУ-ын Москва хоттой Ах дүүгийн харилцаа тогтоосон түүхтэй. Өнөөгийн байдлаар БНХАУ-ын Бээжин /2014/, Хөх хот /1991/, БНСУ-ын Сөүл /1995/, Тайландын Хаант Улсын Бангкок /2017/, Нур-Султан /2019/ зэрэг дэлхийн 15 хоттой Ах дүүгийн харилцаа тогтоох тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан байна. БНХАУ-ын Тяньжин /1992/, ОХУ-ын Улаан-Үд /1996/, БНСУ-ын Намьянжү /1998/, ХБНГУ-ын Берлин /1998/, Бонн /1999/, Японы Саппоро /1999/, Мияконожёо /1999/ зэрэг дэлхийн 20 гаруй хотуудтай найрамдалт харилцаатай.

Мөн Нийслэлийг хөгжүүлэхээр гадаадын зээл, тусламжаар төсөл хэрэгжүүлж байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь 2020 оны байдлаар Монгол Улсын Засгийн газар, түншлэгч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2020 онд 143,061.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй нийт 11 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна.

**Хүснэгт 15. ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БҮЙ ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭ /сая, нэгж/**

№	Төслийн нэр	Донор	Хэрэгжих хугацаа	Нийт санхүүжилт		2020 онд санхүүжих /төгрөг/	Хэрэгжилт
				Дүн	Валют		
1	Улаанбаатар хотын цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл	ДБ	2020-2021	12.0	USD	2,366.9	65%
2	Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарцын төсөл	БНХАУ	2016-2021	42.4	USD	32,000.0	87%
3	Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах төсөл	БНХАУ	2016-2021	30.3	USD	-	100%
4	Туул гол дээгүүрх Баянзүрхийн 281.2 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөрбетон гүүрийг шинээр барих төсөл	БНХАУ	2018-2021	21.3	USD	833.4	95%
5	Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн төсөл	БНХАУ	2018-2021	38.2	USD	23,797.0	84.5%
6	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл 1, 2	АХБ	2014-2019	64.6	USD	29,706.2	Төсөл 1 – 89.01%
		АХБ		36.1	SDR	14,996.5	
		ЕХОБ		37.3	EUR	13,013.6	Төсөл 2 – 24.62%
		ТУСЛАМЖ		3.7	USD	-	
7	Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл 1	АХБ	2015-2020	29.7	USD	-	-
		АХБ		19.8	SDR	-	
		ТУСЛАМЖ		1.5	USD	-	
8	Улаанбаатар хотын цэвэр усны хоолойг шуудуу ухалгүйгээр шинэчлэх технологийг нэвтрүүлэх төсөл	Австри	2017-2022	7.0	EUR	2,000.0	70.5%

9	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл	АХБ	2017-2027	60.0	USD	592.1	5%
		УАНС		20.0	USD	2,000.0	
				95.0	USD	-	
				50.0	USD	-	
		ӨТС		3.0	USD	-	
10	Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл	ЕСБХБ	2019-2021	16.7	USD	500.0	10%
11	Нийслэлийн нийтийн тээвэрт агаарын дүүжин тээврийг нэвтрүүлэх төсөл	Франц улсын ЗГ	2020-2023	60.7	EUR	21,255.8	0%
	НИЙТ					143,061.5	

Нийслэлийн өнөөгийн нөхцөл байдлыг тодруулах чанарын судалгааны үр дүнг нэгтгэн үзвэл дараах гол дүгнэлтүүдийг хийж болохоор байна. Үүнд:

Нэгд, Улаанбаатар хотын дэд бүтцийн хөгжил сул, хүн амын хэт төвлөрлөөс шалтгаалан амьдрах орчин, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, хотын агаар, ус, хөрсний бохирдол, замын түгжрэл зэрэг асуудлууд тулгарч байна. Энэ нөхцөл байдлыг хотуудын өрсөлдөх чадварын индексээр тодорхойлсон үр дүн баталж байгаа юм. Улаанбаатар хотын өрсөлдөх чадварын индексээс харвал эдийн засаг, амьдралын чанарын индекс сайн, аюулгүй байдал дундаж, засаглал, амьдрах орчны индекс бага үзүүлэлттэй байна. Эндээс хотын засаглал, амьдрах орчны үзүүлэлтүүдийг анхаарах шаардлагатай нь харагдаж байна. Ялангуяа бусад үзүүлэлтүүдээс хамгийн доогуур үзүүлэлттэй байгаа нь амьдрах орчин (0.490)-ыг онцгойлон анхаарах шаардлагатай юм. Мөн нийслэлийн орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх чиг үүргийн хэрэгжилт хамгийн бага буюу 59.2 хувь /мандатын шинжилгээний үр дүн / байна.

Хоёрт, Байгаль орчны хамгаалал, ялангуяа хотын нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ 4.8 м2 байгаа нь чамлалтай байна. Энэ нь иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, орчны тоос, тоосонцрыг нэмэгдүүлж, үер усны эрсдэлд өртөмтгий болгож байна. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт мандатын шинжилгээний үр дүнгээр 64.5 хувийн үнэлгээтэй байна.

Гуравт, Улаанбаатар хотын иргэдийн хүний хөгжлийн индекс 0.823 байгаа хэдий ч түүний дэд үзүүлэлтийг хувьд ажилгүйдлийн түвшин 6.3, ажиллах хүчний оролцооны түвшин 54.1, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж сайнгүй, жилээс жилд хүртэмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байгаа боловч хүн амын өсөлтөө даган төдийлөн хурдацтай нэмэгдэж чадахгүй байна. Тухайлбал, Нийслэлийн хэмжээнд 3 ээлжээр 23 сургуулийн 188 бүлэгт 7743 суралцагч хамрагдаж байгаа бөгөөд нийт сургуульд 08 цагаас 18 цагийн цагийн хооронд тасралтгүй үндсэн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна. Мөн Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллага болон Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийт 7,000 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байгаа ба эмч, сувилагчийн харьцаа 1:0.9 байгаа нь стандартын шаардлагад хүрэхгүй, юуны өмнө сувилагчийн хүрэлцээг нэмэгдүүлэх нэн шаардлагатай байна. Улаанбаатар хотод нэг эмчид ногдох хүний тоо 200.6, нэг

сувилагчид ногдох хүний тоо 213.8 байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиг үүргийн хэрэгжилтийн түвшин мандатын шинжилгээгээр 68.1 гэсэн үнэлгээ авсан.

Эцэст нь гадаад ба дотоод орчны зүгээс нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсны үндсэн дээр орчны шинжилгээний үр дүнг CBOT (Strengths, Weaknesses, Opportunities, Threats) дараах хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 16. НИЙСЛЭЛИЙН ДОТООД БА ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН /SWOT МАТРИЦ/

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
- Улаанбаатар хотын нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээнд шинэ менежмент, мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглаж байна. (сайт, аппликейшн, гар утасны аппликейшн г.м) - Монгол улсын газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг хэдий ч нийт хүн амын 46 хувь, их дээд сургууль, коллежийн 96 хувь, иргэдийн хадгаламжийн 82 хувь, автомашины 68 хувь, бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 75 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 66 хувийг эзэлдэг. - Бусад хотуудтай харьцуулахад Улаанбаатарчуудын хүний хөгжлийн индекс нь харьцангуй өндөр байна. (2019 оны байдлаар 0.823) - Хотын хүн амын насны бүтцийн хувьд ерөнхийдөө залуу хэвээр байна. - Сүүлийн 10 жилийн хугацаанд Улаанбаатар хотод олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо буурах хандлагатай байна. 15, түүнээс дээш насны хүн амын 99.5 хувь нь бичиг үсэгт бүрэн тайлагдсан. - Сүүлийн 10 жилд ерөнхий боловсролын сургуулийн тоо 18.3 хувиар, суралцагчдын тоо 42.8 хувиар, багшийн тоо 37.3 хувиар нэмэгдсэн 2016-2020 оны хооронд	- Улаанбаатар хотын өрсөлдөх чадварын индекс 0.557 /засаглал, амьдрах орчны үзүүлэлт дундаас доогуур байна/ байна. - Дагуул хотуудын хөгжил удаашралтай. - Улаанбаатар хотод эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг нэмэгдсэн. /2018 оны үзүүлэлтээс 3.5 пунктээр өссөн/ 2019 оны судалгаагаар иргэд Улаанбаатар хотын нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны шударга байдлыг 71.2 хувь гэж үнэлсэн. Үүнд: ил тод хариуцлагатай байдал дутмаг, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг, бусдад хууль бусаар давуу байдал олгодог гэсэн асуудлууд байна. - Хотын хүн ам сүүлийн 10 жилд 24.6 хувь буюу 295 мянгаар нэмэгдэж 1.5 саяд хүрч, хүн амын нягтаршил нэмэгдсэн. (Монгол улсын хүн амын ½ хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 0.5% нь бусад хот, суурин газар амьдарч байгаа нь дэлхийн хотжилтын түвшингээс дээгүүр байна.) - Хүн амд эзлэх хөгшчүүлийн ачаалал 6.8 болсон нь бага мэт харагдаж байгаа боловч тооллогоос тооллогод тасралтгүй нэмэгдэж өмнөх тооллогоос 1.7 пунктээр нэмэгдсэн. - Нийслэлийн хэмжээнд 3 ээлжээр 23 сургуулийн 188 бүлэгт 7743 суралцагч хамрагдаж байгаа бөгөөд нийт сургуульд 08 цагаас 18 цагийн цагийн хооронд тасралтгүй үндсэн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна. - Ковид-19 цар тахал дэгдсэний улмаас суралцагчид теле болон цахим хичээлд хамрагдсан боловч сургалтын хөтөлбөрийн агуулгын 48-54 хувийг эзэмшиж, хичээлийн хоцрогдол үүссэн. - Хүн амын нас баралтын 77 хувийг урьдчилан сэргийлж, эрт үед нь илрүүлж, эмчлэх боломжтой халдварт бус өвчин зонхилж байна. - Нийгмийн эрүүл мэндийн боловсрол сул. - Иргэдийн эрүүл амьдралын зөв хэвшил дадал төлөвшөөгүй. - Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллага болон Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийт 7,000 гаруй

нийт 99 цэцэрлэгийн барилга, 43 сургуулийн барилга, 12 бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга баригдаж, цэцэрлэгийн хүчин чадлыг 15805-аар, сургуулийн хүчин чадлыг 25760-аар, бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын хүчин чадлыг 3600-аар тус тус нэмэгдүүлсэн.

9. Хүмүүсийн халдварт өвчний талаар болон түүнээс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага сайжирсан.
10. 2021 онд Ковид 19 цар тахлыг даван туулах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулгын хүрээнд цахим хичээлийн иж бүрэн сан бүрдүүлж, зайн сургалтын үйл ажиллагааг дэмжин ажилласан.
11. Улаанбаатар хотын 6, түүнээс дээш насны хүн амын 91.2 хувь буюу 1136.6 мянган иргэн гар утас хэрэглэж байгаа бол интернэт сүлжээ хэрэглэгчдийн хувьд 6, түүнээс дээш насны нийт хүн амын 76.0 хувь буюу 946.7 мянган хүн интернэт хэрэглэж байна.
12. Албан хаагчид цахим хэлбэрээр ажиллах нөхцөл бүрдсэн болон аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын цаг, хуваарь уян хатан болж, ашиглалтын зардлыг бууруулж байна.
13. Цахим худалдаа, цахимаар ажиллах, цахим үйлчилгээ гэх мэт зайлшгүй шаардлагууд нь иргэдийн цахим ур чадвар сайжрахад түлхэц болж байна.
14. 2016-2020 онуудад Дүүргийн эмнэлгүүдэд хорт хавдрын өдрийн хими эмчилгээний нэгж, гемодиализийн эмчилгээ, нярайн эмгэгийн тасаг, мэс засал, гэмтэл, харвалт шигдээсийн нэгжүүдийг нээн ажиллуулснаар эмнэлгүүдийн ачааллыг бууруулж, иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж,

эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байгаа ба эмч, сувилагчийн харьцаа 1:0.9 байгаа нь стандартын шаардлагад хүрэхгүй, юуны өмнө сувилагчийн хүрэлцээг нэмэгдүүлэх нэн шаардлагатай байна. Улаанбаатар хотод нэг эмчид ногдох хүний тоо 200.6, нэг сувилагчид ногдох хүний тоо 213.8 байна.

13. Нийслэлд коронавирусын КОВИД-19 халдварын анхны тохиолдол бүртгэгдсэн 11 сарын 11-ний өдрөөс хойш 2021 оны 6 сарын 19-ны байдлаар нийслэлд 75.721 тохиолдол бүртгэгдсэн, цаашид нэмэгдэх магадлалтай байна.
14. Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төрийн байгууллагын уялдаа холбоо сул, зохицуулалт удаан.
15. Иргэдийн эрүүл хооллолт, зохистой хэрэглээ алдагдсан.
16. Улаанбаатар хотын хүн ам улсын хүн амын 45.9 хувийг эзэлж, хувийн жин нь жилээс жилд нэмэгдэж байгаа боловч ажил эрхэлдэг хүний хувийн жин хүн амын өсөлтөө даган төдийлөн хурдацтай нэмэгдэж чадахгүй байна.
17. Хөдөлмөрийн зах зээлд боловсролын түвшин, мэргэжлийн байдлаар эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт харьцаа алдагдсан. /2020 оны 4 дүгээр улирлын байдлаар нийслэлийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 48.9 хувь, ажилгүйдлийн түвшин 6.3 хувь/
18. Хөдөлмөр эрхлэгчдийн орлого буурсан, түрээсийн төлбөр, ажилчдын цалин, өр зээлийн асуудал, ажилгүйдэл нэмэгдсэн.
19. Хотын төв хэсэгт дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн тул барилгажилт эрчимтэй явагдаж, хэт бөөгнөрсөн.
20. Улаанбаатарын хувьд ногоон байгууламж шаардлагатай хэмжээнээс хэд дахин бага (олон улсад 1 хүнд 10 м²) буюу нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ 2020 онд 4.8 м² байна.
21. Насжилт өндөр, түймэрт өртсөн зэрэг “Нийслэлийн ногоон бүсийн ой зохион байгуулалтын тайлан”-д ойжуулах, нөхөн сэргээх шаардлагатай 17098 га талбай байгаа.
22. Нийслэлийн нутаг дэвсгэрт 2412 га талбай уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэгдсэн ба үүнээс 2374 га нь тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаагаар эвдэгдсэн байна.
23. Бичил уурхайн улмаас эвдэгдсэн /Налайх/ 667 га талбайгаас 338 га эзэнгүй орхигдсон талбайг “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хүрээнд нөхөн сэргээхээр зорилт тавин ажиллаж байгаа боловч коронавируст цар тахлын улмаас аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж нөхөн сэргээлтийн ажил орхигдох эрсдэлтэй байна.
24. Бичил уурхайн улмаас ухагдаж эвдэгдэн, эзэнгүй орхигдож, нөхөн сэргээгдэлгүй үлдсэн нийт 192,3 га талбай байгаа.
25. Агаарын бохирдол 50 орчим хувиар буурч байгаа

үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.

15. Нийслэлийн хэмжээнд сүүлийн 3 жилийн дундажтай харьцуулахад нийт төрөлт 1,185-р нэмэгдсэн ба эхийн эндэгдэл 2016 онтой харьцуулахад 100,000 амьд төрөлтөд 17.5 промилээр, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1,000 амьд төрөлтөд 3.3, нийт халдварт өвчин 2016 оноос 10,000 хүн амд 120.6 промилээр тус тус буурсан байна.
16. Нийслэлийн Эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тусламж үйлчилгээний төсөв, хөрөнгө оруулалт жил ирэх бүр нэмэгдэж байна. 2016 онтой харьцуулахад 2020 онд төсөв 70 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба үүнтэй зэрэгцээд улс, нийслэлийн хөрөнгө оруулалт нэмэгдэж олон эмнэлэг шинэ барилгатай болж тоног төхөөрөмжийн хангалт сайжирсан.
17. Сүүлийн жилүүдэд орон сууцны барилга нэмэгдэж байгаатай холбоотойгоор гэр хорооллын өрхийн эзлэх хувь бага зэрэг буурах хандлагатай байна.
18. Хотын стандарт шалгуур үзүүлэлтийг тогтоож барьж байгуулах нөхцөл боломж эрх зүйн орчинг бүрдүүлж ажиллаж байна.
19. Дагуул, хаяа, хот, тосгодыг түүхий эд боловсруулах, түлш эрчим хүч, уул уурхай, барилгын материалын болон хөдөө аж ахуй, хүнс хөнгөн үйлдвэрлэл, аялал жуулчлалын чиглэлээр хөгжсөн, оршин суугчдын амьдралын таатай орчин бүрдсэн хот, тосгод болон хөгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
20. Бусад бүстэй харьцуулахад бизнес эрхлэх боломж хамгийн өндөр.

боловч агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас их хэвээр байгаа. //

26. Улаанбаатар хотод саарал усыг ашигладаггүй.
27. Хөрсний бохирдлын 80 гаруй хувь нь гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлонгоос, үлдсэн 20 хувь нь хог хаягдлаас шалтгаалдаг.
28. Хотын бохир ус цэвэрлэх байгууламж, аж үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагаас гарах хаягдал ус, төрийн эзэмшлийн болон хувийн цэвэрлэх байгууламжаас гарах дутуу цэвэршүүлсэн хаягдал усыг нийтийн татуургад нийлүүлэх, аж үйлдвэрийн болон ахуйн шингэн хаягдал зэрэг нь хөрс, усны нөөцийг бохирдуулагч гол эх үүсвэр болж байна.
29. Улаанбаатар хотын автозамын даац хэтэрсэн. Хүн ам, автомашины тооны өсөлттэй харьцуулахад зам, гүүр хангалтгүй хэвээр байна.
30. 2021 онд орон нутгийн өмчит байгууллагаас 250 ширхэг, хувийн хэвшлийн 280 ширхэг нийт 530 тээврийн хэрэгсэл насжилт дуусаж ашиглалтаас хасагдана.
31. Өнөөгийн түвшинд дулаан хангамжийн системийн нийт 334 км урттай шугамын 27% буюу 90.7км урттай дулааны төв шугам 30 жилээс дээш насжилттай, насжилтын хугацаа дууссан.
32. Нийслэлийн дагуул хот тосгодын дулааны шугам сүлжээний ихэнх хэсэг хуучирч элэгдэх шатандаа орсон.
33. Вакцинжуулах үйл ажиллагаа эхэлснээс хойш Монгол Улсын хувьд эсрэгээрээ, халдварын тархалт эрчимтэй нэмэгдэж байна.
34. Улаанбаатар хотын газар зүйн байршлын хувьд тэлэх боломж хязгаарлагдмал.

Эрсдэл

1. 2019 оны байдлаар аз жаргалын индексээр 186 хотоос 136 дугаарт орж байна.
2. Монгол улсын татварын орлого бүрдүүлэх төвлөрсөн тогтолцоо нь Улаанбаатар хот, төвлөрүүлж болох татварын орлогодоо түшиглэн төрийн үйлчилгээний хангамжийг бие даан санхүүжүүлэх бололцоог хязгаарлаж байна.
3. Ковид 19 цар тахлын халдвар нийгмийн бүхий л салбарын үйл ажиллагааг хязгаарлаж, иргэдийн эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байна.
4. “Ковид-19” цар тахлын улмаас сургууль, цэцэрлэгийн их засварт төлөвлөгдсөн 19 сургууль, цэцэрлэгийн их засварын хөрөнгө эргүүлэн татагдсан.
5. Хүнсний бүтээгдэхүүний экспорт, импортын зохистой харьцаа алдагдаж, импортоос хараат орны тоонд багтдаг болсон.
6. Цаг агаарын эрс тэрс уур амьсгалтай.
7. Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй, зорилтот бүлэг оновчтой бус.

21. Мэдээллийн хүртээмж, хурд сайжирч байгаа.

8. Хөдөө орон нутагт дэд бүтэц, зах зээлийн орчин дутмаг байгаагаас Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн тасрахгүй байгаа нь агаарын бохирдлыг нэмэгдүүлэх томоохон хүчин зүйлс болж байна.

Боломж

1. Олон улсын байгууллагын санхүүжилтээр хотын нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор хэрэгцээнд суурилсан сургалтын хөтөлбөрийг үе шаттайгаар зохион байгуулж байна. /Хотын сайн засаглалыг бэхжүүлэх хүрээнд өмнө нь 2015 оноос “Хотын засаглал” төслийг Швейцарын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлж эхэлсэн/
2. Гадаадын зээл тусламж, олон улсын байгууллагын тусламжаар 2020 онд нийслэлийн нийт 50 сургууль, цэцэрлэгт 4.3 тэрбум төгрөгийн их засварын ажил хийгдэх хөрөнгө батлагдан засварын ажил бүрэн дууссан.
3. Төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох боломжгүй гэр хорооллын дундын бүсэд инженерийн хангамжийг нэвтрүүлэх “Дэд бүтцийн төв” төслийг Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банк болон нийслэлийн төсвийн хөрөнгөөр хамтран санхүүжүүлэх ба нийт 3 үе шаттайгаар 6 дэд төвийн суурь дэд бүтцийн ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.
4. Улаанбаатар хот нь дэлхийн 20 гаруй хотуудтай найрамдалт харилцаатай
5. Мэдээлэл, технологийн салбар хурдтай хөгжиж байна.
6. Бизнесийн шинэ хандлага хөгжих нөхцөл бүрдсэн (цахим сургалт, цахим ажлын байр, цахим бизнес)
